МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,**
**ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН**

# “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ БА МОНГОЛ УЛС”

Судалгааны төрөл: **Хамаарлын судалгаа**
Судалгааны код: **БГСТ-24/019**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: С.Чулуундолгор

**Улаанбаатар хот**
**2024**

# АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР ..... 2
ХУРААНГУЙ ..... 3
1. УДИРТГАЛ ..... 6
2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН ТОЙМ ..... 7
2.1 Судалгааны зорилго: ..... 7
2.2 Судалгааны арга зүй ..... 7
2.3 Судалгааны хамрах хүрээ: ..... 7
3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦЫН ТАЛААРХ ТОЙМ ..... 9
МОНГОЛ УЛС ДАХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ .....10
4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦ БА МОНГОЛ УЛСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД БА НИЙЦЛИЙН ШИНЖИЛГЭЭ .....12
ХБХЭТК-ийн тусгай эрхүүдийг зохицуулах 5-аас 33-р зүйл ба тус бүрийг зохицуулж буй хууль эрх зүйн зохицуулалтууд ба нийцэл .....13
Нэг. Хувь хүн, гэр бүл, халдашгүй дархан байдлыг хангах тухай эрхүүд .....14
Хоёр. Эдийн засаг, нийгэм, улс төрийн оролцооны эрхүүд .....17
Гурав. Нийгмийн хүртээмж, оролцоог хангаж буй байдал .....25
Дөрөв . Хуулийн өмнө тэгш байх эрхүүд .....29
Тав. Тухайлсан бүлгүүд ба тэдгээрийн эрхийг хангаж буй байдал .....34
Зургаа. Конвенцын хэрэгжилт, хяналт, хамтын ажиллагаа .....38
5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦ БА МОНГОЛ УЛСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД БА НИЙЦЛИЙН ШИНЖИЛГЭЭ .....40
6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД ..54

## Товчилсон Үгсийн Тайлбар

| | |
|---|---|
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ХЭҮК | Хүний эрхийн үндэсний комисс |
| БШУЯ | Боловсролын яам |
| ГБХНХЯ | Гэр Бүл Хөдөлмөр Нийгмийн Хамгаллын Яам |
| ХНХЯ | Хөдөлмөр Нийгмийн Хамгаллын Яам |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ХБХХЕГ | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар |
| ХБХЭТК | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц |
| ХБХЭТХ | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль |
| ХБХЭ | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх |
| ХБ | Хөгжлийн бэрхшээл |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ХБХ | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс |

# ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны гол зорилго нь Монгол улсын  хууль, эрх зүйн зохицуулалт нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцтой хэр нийцэлтэй байгааг судлан  шинжилж, дүгнэлт хийх, нийцлийг сайжруулахад шаардлагатай үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох байв. Тиймээс, энэхүү судалгааг гүйцэтгэхдээ конвенц болон судалгааны хүрээнд илэрсэн 34 хууль, эрх зүйн зохицуулалтуудыг илрүүлэн, харьцуулан шинжилж, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлд ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөллүүдтэй гүнзгийрүүлсэн ярилцлага хийж мэдээлэл цуглуулсан. Эдгээр цуглуулсан анхдагч болон хоёрдогч мэдээллийн үр дүнд үндэслэн энэхүү тайланг боловсрууллаа.

Энэхүү нийцлийн судалгааг гүйцэтгэхдээ үндсэн 3 гол алхмыг баримталсан.

i. Монгол улсын  хууль, эрх зүйн зохицуулалт нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцтой хэр нийцтэй байгааг шинжлэх ажлыг хялбаршуулах зорилгоор, конвенцын зүйл заалтуудыг зохицуулж буй Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалтын ижил, төстэй, нийтлэг зохицуулгатай байдлаар нь конвенцын 1-33 дугаар зүйлийг 7 бүлэгт бүлэглэн хуваж, конвенцын зүйл тус бүрийг зохицуулж буй хуулиуд, тэдгээрт туссан заалтуудыг нарийвчлан оруулсан.
ii. Зүйл заалтуудыг дарааллын дагуу шинжилж, нийцтэй байдал болон зөрүүтэй байдлыг тусгасан үр дүнг танилцуулсан.
iii. Зүйл заалт тус бүрийн хүрээнд зөрүүтэй байдлыг арилган авч хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг нарийвчлан гаргаж санал болгосон.

Нийцлийн судалгааны үр дүнг хураангуйлан танилцуулбал, ерөнхийд нь нийцлийн асуудлыг Бүрэн нийцтэй, Нэр томьёолол болон тодорхойлолтын зөрүүтэй, Агуулга, арга хэмжээ дутуу тусгасан, Конвенцын заалт, агуулга зөрчилтэй тусгагдсан гэсэн 4 бүлэг шинжид хуваж болохоор байна.

- *Нэгдүгээрт, Бүрэн нийцтэй буюу конвенцын зүйл заалтуудад тусгагдсан агуулга, авах арга хэмжээ нь бүрэн тусгагдсан*, түүний дагуу хуулийн бүхий л зүйл заалтууд нь хүчинтэй байгаа зүйл заалтууд байна. Үүнд, хуулийн салбартай холбоотой хуулийн өмнө тэгш байх, туслалцаа авах, 12 дугаар зүйл. Хуулийн өмнө тэгш байх эрх, 13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох, 14 дүгээр зүйл. Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх, 15 дугаар зүйл. Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх, 16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх, 23 дугаар зүйл. Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх, 24 дугаар зүйл. Боловсрол, 27 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлт зэрэг эрхүүд багтаж байна. Эдгээр эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулахын сацуу, ХБХЭТХ, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, Шүүхийн тухай хууль, Эрүүгийн тухай хууль, Эрүүгийн хэргийг хянан шалгах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, зэрэг урьдчилан сэргийлэх, хэргийг хянан шийдвэрлэх, зөрчлийг арилгах хуулиудаар бүрэн зохицуулж байна. Үүнээс гадна, 11 дүгээр зүйл. Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдлыг зохицуулж буй ХБХЭТХ, Онц байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, түүнтэй

нийцүүлэн гаргасан Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам, ‘Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)’ зэрэг зохицуулалтууд нь уг конвенцын зүйлд тусгагдсан агуулга, авах арга хэмжээг бүрэн тусгажээ. Бүрэн нийцэлтэй буюу конвенцод тусгасан асуудал, авах арга хэмжээ нь хууль, эрх зүйн ямар нэгэн актаар бүрэн баталгаажсан зүйл заалтуудын талаар үндэсний болон оролцогч талууд, олон нийт, ХБХ болон тэдгээрийн гэр бүлийг нэгдсэн ойлголттой болгох, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэх, тогтмол хянаж тайлагнах нь нэн тэргүүний ач холбогдолтой ажил болох юм.

- *Хоёрдугаарт, Нэр томьёоллын зөрүүтэй зүйл заалтын тухайд,* Конвенцод заасан ‘Хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах’ гэсэн тодорхойлолтыг ХБХЭТХ-ийн 4.1.2."хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах" гэсэн нэршлээр, мөн бусад салбарын хуулиудад алагчлах, ялгаварлах гэсэн ойлголтуудыг жигд бусаар ашиглаж байна. Үүний дараа, Конвенцод заасан Сэргээлт, Нөхөн сэргээлтийн талаар ХБХЭТХ-д тусгаагүй, энэхүү нэр томьёог ашиглаагүй байгаа бөгөөд сэргээн засалт хэмээх хэллэгийг ашигласан цөөн заалт байна. Тухайлбал, Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.21-т "сэргээн засах" гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах болон эмнэлгийн бусад мэргэжилтний хамтын цогц үйл ажиллагааг;Тиймээс, уг нэр томьёог нэгдсэн байдлаар ойлгохын тулд нэгдсэн тодорхойлолтыг гаргаж, түүнийг бусад хууль, эрх зүйн зохицуулалтуудад жигд ашиглах шаардлагатай нь харагдаж байлаа.
- *Гуравдугаарт, Конвенцын агуулга, арга хэмжээг нэмж тусгах заалтуудын тухайд,* 7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, 8 дугаар зүйл. Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, 9 дүгээр зүйл. Хүртээмж, 10 дугаар зүйл. Амьд явах эрх , 19 дүгээр зүйл. Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх , 20 дугаар зүйл. Хувийн хөдөлгөөн, ХБХЭТК-ын 21 дүгээр зүйлд заасан Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх, 25 дугаар зүйл. Эрүүл мэнд, 30 дугаар зүйл. Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх тухай зүйл заалтууд багтжээ. Нийтлэг байдлаар харвал, энэ нь гол төлөв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй, хүртээмжтэйгээр оролцохыг хөхиүлэн дэмжих зүйл заалтууд байна. Гэвч, эдгээр эрхийг бүрэн хангахын тулд энэ эрхүүдийг тодорхойлсон тодорхойлолтуудыг бүрэн тусгах, хамрах хүрээ, авах арга хэмжээг нэмж тусгах шаардлага харагдаж байна. Тухайлбал, зүйл заалтуудаасаа орхигдсон асуудлуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн шийдвэр гаргалт дах оролцоо, ХБХ-ийн эрхийн талаарх мэдлэгийг боловсролын бүхий л түвшинд суулгах, олон нийтэд бүх мэдээллийн хэрэгслүүдээр хүргэх, хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг зохиох, үйлдвэрлэх, түгээн борлуулах асуудлууд, тэдгээрийг хөхиүлэн дэмжих, 'нийтэд нээлттэй үйлчлэх объект, үйлчилгээ'-г тодорхойлох замаар үндэсний болон салбарын холбогдох хууль, журам, стандарт, шаардлагуудад нэмж тодорхойлж, тусгах замаар конвенцтой нийцүүлэх шаардлагатай зүйл, заалтууд багтаж байна. Тиймээс, эдгээр дутуу тусгагдсан агуулга, арга хэмжээг тусгах боломжийг судалж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай хуулиудад шаардлагатай өөрчлөлтүүдийг зөв томьёолон оруулж, тусгахтай холбоотой ажлын

хэсэг гаргаж, хариуцсан яамдад холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах ажлыг нэн тэргүүнд анхааран гүйцэтгэх нь зүйтэй.

- *Дөрөвдүгээрт, Конвенцын заалт, агуулга зөрчилтэй байдлаар тусгагдсан асуудлууд багтах бөгөөд үүнд* 6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, 17 дугаар зүйл. Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах болон 18 дугаар зүйл. Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхэд тусгагдсан заалтууд, арга хэмжээ багтаж байна. Конвенцын 6, 17, 18 дугаар зүйлүүдэд нийтлэг байдлаар тусгагдсан асуудал нь ‘сэтгэцийн бэрхшээлтэй иргэн’-ий асуудал бөгөөд түүний тодорхойлолт, болон эрх зүйн чадамжгүй гэсэн хуулийн заалтуудаас үүдэн түүний гэр бүлтэй байх, нөхөн үржихүй эрхүүдээ хязгаарлуулах, хувийн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх боломжгүй болох, мөн Монгол улсын харьяат болох хүсэлтийг түдгэлзүүлэх зэрэг конвенцод заасан эрхүүдтэй зөрчилдсөн буюу тэдгээрийн эсрэг хуулийн заалтууд байгаа юм. Ялангуяа, Иргэний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Харьяатын тухай хууль, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиудад зөрчилтэй заалтууд тусгагджээ. Тиймээс, энэхүү зөрчилтэй агуулга, зөрүүтэй заалтуудыг шийдвэрлэхийн тулд салбарын мэргэжилтнүүд болон хүний эрхийг хамгаалагчид, хуульчид зэрэг олон салбарын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх, ойлголтыг нэгтгэх, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийх, шаардлагатай тохиолдолд Хүний эрхийн хороонд санал хүргүүлж шийдвэрлүүлэх нь нэн тэргүүний хийгдэх ёстой ажил болж байна.

# 1. УДИРТГАЛ

Монгол Улс нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцод (ХБХЭТК) 2006 онд нэгдсэн орж, хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил эрхээ эдэлж, сурч боловсрох, хөгжих, хөдөлмөрлөх, төрийн үйлчилгээ авах, хөгжлийн үр шимээс хүртэх адил, тэгш боломж олгох үүргийг хүлээсэн.

Монгол улсын Засгийн газар дээрх конвенцын хэрэгжилтийг хангах хүрээнд 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталсан. Тус хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод тусгагдсан олон асуудлыг хөндсөн. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш эрхийг хангах, боловсрол, хөдөлмөр, эрүүл мэндийн үйлчилгээ, тээвэр, орон сууц зэргийг тэднийг оролцуулсан хүртээмжтэй байх тухай асуудлууд тусгагдсан. Гэсэн хэдий ч хуулийн заалт бүрэн хэрэгжихгүй байх, дүрэм журмууд өөр хоорондоо зөрчилдөх, бусад салбарын хуулиудад асуудал бүрэн дүүрэн тусгагдахгүй байх бэрхшээл саад байсаар байна. Иймд Монгол улсын хууль, эрх зүйн зохицуулалт нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцтой хэр нийцэлтэй байгааг судлан шинжилж дүгнэлт хийх, асуудлыг сайжруулахад шаардлагатай сайжруулахад шаардлагатай үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох нэн шаардлагатай байна.

Энэхүү судалгааг хийснээр холбогдох хууль, хууль эрх зүйн зохицуулалт, тэдгээрийг хэрэгжилтийг хангах практик үйл ажиллагаанууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангахад бүрэн чиглэгдэж чадаж байгаа эсэхийг тодорхойлно. Улмаар ямар хууль, бодлого, стратеги зорилтот иргэдийн эрхийг ханган, хамгаалж мөн эрхийг хязгаарлаж байгааг тодорхойлон гаргана. Ингэснээр зорилтот иргэдэд чиглэсэн бодлого үйл ажиллагааны үр ашиг сайжирна.

Мөн НҮБ-ны Тогтвортой хөгжлийн зорилт 2030 , Монгол улсын Засгийн газрын Алсын хараа 2050 зэрэгт зорилтуудын тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаагаа Монгол улсын Засгийн газар үнэлэх, цаашлаад үйл ажиллагаагаа төлөвлөхөд энэхүү судалгааны тайлан хувь нэмрээ оруулна. Түүнчлэн судалгааны мэдээлэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмд оролцох эрх, тэдэнд зориулсан үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

# 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН ТОЙМ

Энэхүү хэсэгт өгөгдсөн ажлын даалгаварт заасан уг судалгааны зорилго, хамрах хүрээ болон түүнийг гүйцэтгэхэд ашигласан арга зүйг тоймлон танилцууллаа.

## 2.1 Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын зарчмууд үндэсний (The United Nations Department of Economic and Social Affairs, 2008) хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан байгааг үнэлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг бүрэн хангах бодит боломж ямар түвшинд байгаа болон хууль, эрх зүйн зохицуулалтад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тодорхойлж, хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Үүний дагуу, уг судалгаа нь дараах үндсэн зорилготой байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн зохицуулалтын нийцлийг шинжлэх;
2. Өнөөгийн түвшинд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, эрх зүйн актууд дах зөрүү болон асуудлуудыг тодорхойлох;
3. Нийцлийн шинжилгээ болон хэрэгжилтийн үнэлгээнд суурилан зохицуулалтгүй байгаа асуудлуудыг илрүүлж, түүнийг тусгах, сайжруулах зорилго бүхий бодитой, хэрэгжихүйц санал зөвлөмжийг боловсруулах зэрэг багтана.

## 2.2 Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны зорилгод хүрэхийн тулд чанарын судалгааны аргад тулгуурлан уг ажлын даалгаврыг гүйцэтгэлээ. Нарийвчлан дурдвал, хууль, эрх зүйн зохицуулалт дүн шинжилгээ хийхийн тулд баримт бичгийн судалгааны аргыг ашигласан. Харин одоогийн тулгамдаж буй сорилтууд болон цаашид сайжруулах санал зөвлөмжийг тодорхойлох зорилгоор  төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын гол талуудтай хагас бүтэцлэгдсэн ярилцлагыг хийсэн болно. Судалгааны хүрээнд нийт 13 ярилцлагыг гүйцэтгэлээ. Энэхүү судалгааг ажлын даалгаварт өгөгдсөн хугацааны хүрээнд 2024 оны 12 сараас эхлэн 3 долоо хоногийн хугацаанд гүйцэтгэсэн болно.

## 2.3 Судалгааны хамрах хүрээ:

Энэхүү судалгаа нь конвенцын нийцлийн судалгаа тул Ажлын даалгаварт өгсний дагуу зөвхөн хууль, эрх зүйн актуудын нийцтэй байдалд төвлөрөх тул конвенцын хэрэгжилтийн асуудлыг хөндөхгүй гэдгийг анхаарах нь зүйтэй. Конвенцын хэрэгжилтийн асуудлыг МУ-н ЗГ -аас НҮБ-ын ХБЭТК-н хороонд илгээсэн тайлан болон ХБИ-н ТББ-уудын бичсэн сүүдэр тайлан тусгадаг бөгөөд хэрэгжилтийн асуудал нь үндэсний хэмжээнд яригдах бөгөөд одоогийн байдлаар илэрсэн 34 хууль тус бүрийн хэрэгжилтийн үнэлгээ байдлаар буюу олон салбарын бүтэц, механизм, төлөвлөгөө, төсвийг хамруулсан, хөндлөнгийн, өргөн цар хүрээний ажил болох тул, энэхүү судалгааны өгөгдсөн хугацаанд хийх боломжгүй, өргөн хүрээтэй ажил юм. Тиймээс, бид нийцлийн судалгааг гүйцэтгэхдээ, дараах хуулиуд болон

тэдгээрийг дагаж мөрдөх хүрээнд батлан гаргасан нийтээр дагаж мөрдөх журам, дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актуудыг хамруулна. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон түүнтэй нийцүүлэн гаргасан, конвенцод тусгагдсан асуудлыг зохицуулах зорилго бүхий дараах 34 хууль, эрх зүйн актуудыг шинжиллээ.

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)
2. Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо, салбар хорооны үлгэрчилсэн дүрэм (2018)
3. Барилгын тухай хууль (2016)
4. Боловсролын ерөнхий хууль (2023)
5. Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)
6. Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам (2011)
7. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)
8. Гэр бүлийн тухай хууль (1999)
9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016)
10. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)
11. Зөрчлийн тухай хууль (2017)
12. Иргэний хууль (2002)
13. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2020)
14. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)
15. Монгол Улсын Үндсэн Хууль (1992)
16. Оношилгоо, эмчилгээний зориулалтаар шинээр гарч байгаа болон био технологи, нано технологи, инновацын технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд судалгаа, шинжилгээ явуулах, турших, баталгаажуулах, бүртгэх, мэдээлэх, тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам (2019)
17. Онц байдлын тухай хууль (1995)
18. Оюуны өмчийн тухай хууль (2020)
19. Соёлын тухай хууль (2021)
20. Сонгуулийн тухай хууль ()
21. Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага (2023)
22. Тэгш хамруулах боловсролын талаар баримтлах чиглэл (2022)
23. Үр хөндөлтийг зохицуулах журам (2019)
24. Харьяатын тухай хууль (1995)
25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр (2023)
26. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)
27. Хөдөлмөрийн тухай хууль (2021)
28. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021)
29. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)
30. Шүүхийн тухай хууль (2021)
31. Эрүүгийн тухай хууль (2015)
32. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
33. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015)
34. Эрүүл мэндийн тухай хууль (2011)

Эдгээрээс гадна, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахад чиглэсэн бусад салбарын хуулиудыг судалж, дүн шинжилгээ хийлээ.

# 3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦЫН ТАЛААРХ ТОЙМ

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц (ХБХЭТК) нь 2006 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61-р чуулганаар батлагдсан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг хөндсөн анхны эрх зүйн баримт бичиг юм (The United Nations Department of Economic and Social Affairs, 2008). Энэхүү конвенцын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршдог. 2024 оны байдлаар, 191 тал нэгдэн орж баталгаажуулсан бол, үүнээс 164 орон Конвенцод гарын үсэг зуран нэгдэж, уг конвенцыг хэрэгжүүлж байна (The United Nations Department of Economic and Social Affairs, 2008). Монгол улсын хувьд тус конвенцод 2009 онд нэгдэн орсон орж, хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил эрхээ эдэлж, сурч боловсрох, хөгжих, хөдөлмөрлөх, төрийн үйлчилгээ авах, хөгжлийн үр шимээс хүртэх адил, тэгш боломж олгох үүргийг хүлээсэн.

Энэхүү конвенц нь нийт 50 зүйлээс бүрдэх бөгөөд ерөнхийдөө дараах дөрвөн бүлэгт ангилагддаг (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам , 2018).

**1-ээс 4-р зүйл : Нийтлэг зарчмууд болон үүргүүд:**
Зорилго, тодорхойлолт, нийтлэг зарчмууд, нийтлэг үүргүүд

**5-аас 30-р зүйл: Тусгай эрхүүд:**
Хөгжлийн бэрхшээлтэй хүний нарийвчилсан эрхүүд

**31-ээс 33-р зүйл: Конвенцын хэрэгжилт, хяналт, хамтын ажиллагаа:**
Оролцогч улсууд үндэсний түвшинд уг конвенцыг хэрэгжүүлэхтэй холбоотой хийх зохицуулалт, хамтын ажиллагааны тухай

**34-өөс 50-р зүйл Оролцогч улсуудын зохион байгуулалт, үүрэг:**
Уг конвенцыг хэрэгжүүлэх, ашиглах зэрэгтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтын тодорхой үүргүүдийг тусгасан асуудлуудыг багтаасан байна.

Уг конвенцын 35 дугаар зүйл буюу Оролцогч улсуудын тайлан илтгэлийг зохицуулсан зүйлд заасан шаардлагын дагуу уг конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэгдэн орсон улсууд хоёр жилийн дотор үндэсний тайлан илтгэлээ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Хороонд хүргүүлэхээр заажээ. Үүний дагуу, Монгол Улс анх удаа 2011 онд ХБХЭТК -ын хэрэгжилтийн талаарх анхдугаар илтгэлээ хүргүүлжээ. Уг илтгэл нь уг конвенц нь Үндэсний хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа хийгээд, тусгай эрхүүдийг эдлүүлэх тухайд гарсан амжилт, ахиц, сургамж, цаашид авах арга хэмжээний талаарх саналуудыг тусгажээ. Түүний дараагаар нийт хоёр болон гуравдугаар тайланг хянаж Хорооноос ирүүлсэн саналуудад тусгаснаар, ХБХ-ний эрхийг хангахад чиглэсэн хуулиуд, түүний дагуу хөдөлмөрлөх эрх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, ХБХ-ний эрхийн асуудлыг хариуцах үүрэг бүхий яам, агентлаг, холбогдох

хороонуудыг байгуулсан явдлыг сайшаан, онцлон дурдсан байна. Энэ нь Монгол Улсад ХБХ-ний эрхийн асуудлыг шийдвэрлэх хууль, эрх зүйн тогтолцоо, бүтэц зохион байгуулалт бүрдсэн байдал ахицтай байгааг илтгэж байлаа. Гэвч, сайжруулах ажлын хүрээнд ХБХ-ний эрхийн асуудлыг эрүүл мэндийн загвараар харах байдлыг халж, хүний эрхийн загварыг хөхиүлэн дэмжиж, түүний дагуу холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтуудыг шинэчлэх зөвлөмжийг өгчээ. Мөн олон талын оролцоо, ойлголтыг нэмэгдүүлэхэд анхаарах, оролцоог нь хангах замаар шийдвэр гаргалт дах ХБХ-ийн эрхийн асуудлыг шийдвэрлэх, төлөөллийг хангах, ХБХ-ийн тухайлсан бүлгүүд болох ХБХ болон ХБ-тэй охид, эмэгтэйчүүдийн асуудлыг онцлон анхаарах, ялангуяа онцгой нөхцөл байдал, гамшгийн үе дэх асуудлуудыг онцлон хөндөж, эдгээр чиглэлд арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг онцлон дурджээ (Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, 2023).

## Монгол Улс дах Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Нөхцөл Байдал

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 111,228 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь нийт хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Тэдгээрийн 47430 нь эмэгтэйчүүд байгаа нь дээрх иргэдийн 42.6 хувийг эзэлж байгаа бол үлдсэн 62.4 хувь буюу 63798 нь эрэгтэйчүүд байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 10.8 хувь нь буюу 12,053 нь харааны, 3.3 хувь буюу 3,618 нь ярианы, 7.0 хувь буюу 7,800 нь сонсголын, 18.0 хувь буюу 20,018 нь хөдөлгөөний, 19.2 хувь буюу 21,396 оюун сэтгэцийн, 6.7 хувь буюу 7,409 нь хавсарсан, 35,0 хувь буюу 38,934 иргэн бусад төрлийн бэрхшээлтэй иргэд байна хэмээжээ. Оршин суугаа байршлаар нь авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 32 хувь (35608) нийслэл Улаанбаатар хотод, 22,4 хувь нь (24947) хангайн үс нутагт, 19,3 хувь нь (21491) төвийн бүс, 16,4 хувь нь (18225) баруун бүс нутагт амьдардаг бол хамгийн бага буюу 9,9 хувь нь (10957) зүүн бүс нутагт оршин суудаг байна (ҮСХ. Нийгмийн зарим үзүүлэлт https://shorturl.at/LXIG6 )

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 47.6 хувь (52944) төрөлхийн, 52.4 хувь нь (58283) олдмол хэлбэрийн бэрхшээлтэй байгаа ба тэдгээрээс 10053 нь хүүхдүүд байна. Хөдөлмөрийн насны буюу 16-64 насны 90,0 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй байгаа ч тэдгээрийн дөнгөж 17% орчим нь (15300) хөдөлмөр эрхэлдэг гэсэн тоон мэдээ байна. Харин гэр бүлийн бизнесийн оролцогч, туслагч байдлаар 13% орчим нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн мэдээлэл байгаа ч, энэ талаар албан ёсны статистик тоо байхгүй байна. 2021 онд Төрийн албаны зөвлөлийн хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчдын тухай хийсэн судалгааны дүнгээр 1456 иргэн төрийн албанд ажиллаж байгаагийн 880 нь эрэгтэй, 576 нь эрэгтэйчүүд байв. Ажилтнуудыг төрийн албаны ангиллаар авч үзвэл улс төрийн албан тушаалд 94, төрийн тусгай албанд 41, төрийн захиргаанд 224, төрийн үйлчилгээнд 1017 ХБИ ажиллаж байна хэмээжээ. (http://gadpwd.gov.mn/index.php/page/277)

БШУЯ-ны 2022 оны тоон мэдээгээр боловсрол шинжлэх ухааны яамны тоон мэдээллээр 1498 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаагийн 835 Улаанбаатар хотод амьдарч байна. Харин ЕБС-н 1-12 дугаар ангиудад 5673 хөгжлийн

бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа бөгөөд үүнээс бага ангид 2653 хүүхэд, дунд ангид 2285 хүүхэд, ахлах ангид 735 хүүхэд тус тус суралцаж байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны 12 сарын мэдээгээр 65,5 мянга, нийгмийн халамжийн сангаас 36,2 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус тус тэтгэвэр, тэтгэмж авч байгаа бол, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа 16,7 мянга, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа 14,8 мянган асран хамгаалагч нарт тус тус нийгмийн халамжийн сангаас мөнгөн тэтгэмжийг олгож байгааг дурджээ. Мөн 41,4 мянган хүнд нийгмийн халамжийн шаардлагатай хөнгөлөлт тусламжийг үзүүлжээ. (https://rb.gy/me1f3m)

Монгол улсын хувьд 2018 онд ХНХЯ-ны харьяа ХБХХЕГ (хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар) гэсэн хэрэгжүүлэгч агентлаг байгуулагдсан. Ингэснээр төрөөс хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр гаргаж байгаа бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх төрийн нэгж байгууллагатай бий болж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээ, бодлогын хэрэгжилтийг хангах нөхцөл илүү сайн бүрдэх боломжтой болсон гэж үздэг. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр дамжуулан зорилтот иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2023 оны эхний хагас жилд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Борлуулалтын дэмжлэг, Хөдөлмөр эрхлэлтийн түр сургалт, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байранд дадлагажуулах арга хэмжээ, Аж ахуй нэгж, төрийн бус байгууллагуудын түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр нийт 64 байгууллагад 1,149,050,100.0 төгрөг тус тус олгосон байна. 354.Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ: ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 2019-2023 онуудад 55 ТББ-уудтай гэрээ байгуулан, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлж, нийт 342,840,866 төгрөгийн санхүүжилт олгосон байна. Тухайлбал: 2019 онд нийт 33 байгууллагад 209,638,400.00 төгрөг, 2020 онд нийт 3 байгууллагад 28,600,000.00 төгрөг, 2021 онд нийт 5 байгууллагад 35,455,800.00 төгрөг, 2022 онд нийт 11 байгууллагад 54,046,666.00 төгрөг, 2023 оны эхний хагас жилд 3 байгууллагыг 15,100,000 төгрөгөөр тус тус санхүүжүүлсэн байна.

ХБХЭТХ-н 41.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийг ХБИ-н эрхийн хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын төлөөлөл, аймаг дүүргийн Засаг дарга нар болон, бүх яамдын төрийн нарийн бичгийн дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байгаа явдал юм. Зөвлөл нь аймаг, нийслэл, дүүрэгт орон тооны бус салбар зөвлөлтэй байх бөгөөд Дэд зөвлөлийн дарга нь тухайн яамны Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга байна. Салбар зөвлөлийн дарга нь тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга байхаар хуульд тусгагдан ажиллаж байна

# 4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦ БА МОНГОЛ УЛСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД БА НИЙЦЛИЙН ШИНЖИЛГЭЭ

ХБХЭТК-ын 1-ээс 4-р зүйлд, конвенцын зорилго, тодорхойлолтууд, нийтлэг зарчим болон нийтлэг үүргүүдийн талаар тус тус тусгасан байдаг.

- **ХБХ-ний эрхийг хангаж, хамгаалахаас гадна, тэдгээрийн нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжих агуулга дутмаг тусгагджээ.** ХБХЭТК-д нийцүүлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг (цаашид ХБХЭТХ) баталсан бөгөөд уг конвенцийн дагуу ХБХЭ-ийг хамгаалах, хангах чиглэл дэх талуудын харилцааг зохицуулах агуулгыг түлхүү тусгажээ. Гэвч, конвенцын зорилгын  бас нэгэн гол агуулга болох эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хөхиүлэн дэмжих, нэр төр, нандин чанарыг хүндэтгэх тухай утга санаа дутмаг тусгагджээ. ХБХЭХ тухай хуулиар зөвхөн эрхийг хангах тухай зорилгыг тодруулан авч үзсэн нь хүний эрхийг нь хангах хүрээнд хязгаарлагдмал байдлаар ойлгох, түүний хүрээнд арга хэмжээ авах, нэр, төр нандин чанарыг нь хүндэтгэсэн нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход саад болж болох юм.
- **Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг хангах, ялгаварлан гадуурхахгүй байхтай холбоотой зүйлд хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах асуудлыг орхигдуулжээ**. Үндсэн Хуулийн 2-р бүлэг болох Хүний эрх, эрх чөлөөг тусгасан 14-р зүйлд хүн бүр хууль, шүүхийн өмнө адил тэгш байхыг баталгаажуулсан боловч ялгаварлан гадуурхалттай холбоотой 14.2-р зүйлд хөгжлийн бэрхшээлээс шалтгаалсан ялгаварлан гадуурхалтыг тусгаагүй байна. Тухайлбал, зөвхөн хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн заажээ. Үүнээс гадна, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 14-р бүлэг болох ‘Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг’-ийн 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхахтай холбоотой зүйлд Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан тохиолдолд олгох шийтгэлийг заасан. Гэвч мөн л адил, хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах асуудлыг орхигдуулсан нь харагдаж байна.  Энэ нь конвенцод заагдсан үндсэн тодорхойлолт болох ‘хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах’ гэсэн нийтлэг тулгамддаг асуудлыг орхигдуулсан буюу тусгаагүй байгааг харуулж байна.
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад баримтлах нийтлэг зарчмуудаас бие даасан байдал, нэр төр, нандин чанарыг нь хүндэтгэх, хүйсээс үл хамааран тэгш эрхтэй байх тухай зарчмууд дутмаг тусгагджээ.** ХБХЭТХ-ийн 5 дугаар зүйлд заасан ХБХ-ний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчимд конвенцын гол зарчмууд тусгагдсан хэдий ч, ХБХ-ий бие даасан байдлыг оролцуулан нэр төр, нандин чанарыг хүндэтгэх, алагчлахгүй байх,  эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх, зөвхөн

хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бус насанд хүрэгчдийн онцлог байдлыг хангах зэрэг зарчмуудын гол санаа тусгагдаагүй байна. Үүнээс хамааран, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалахад нас, хүйсээс үл хамаарсан онцлог байдал, хэрэгцээ, асуудлыг нь онцлон харах, түүнд чиглэсэн тухайлсан асуудлуудыг хөндөх, таниулах, онцлог хэрэгцээ бүхий асуудлуудыг шийдвэрлэх боломжуудыг хязгаарлах эрсдэлтэй.

## ХБХЭТК-ийн тусгай эрхүүдийг зохицуулах 5-аас 33-р зүйл ба тус бүрийг зохицуулж буй хууль эрх зүйн зохицуулалтууд ба нийцэл

ХБХЭТК-д хөгжлийн бэрхшээлтэй хүний суурь эрхүүд болон тусгай эрхүүдийг багтаасан нийт 29 эрхийг тусгасан байдаг бөгөөд тэдгээрийг асуудлын холбоо хамааралтай байдал болон зохицуулж буй хууль, тогтоомжийн нийтлэг байдлаас нь хамааруулан дараах 6 бүлэгт хуваах болохоор байна.

**Хувь хүн, гэр бүл, халдашгүй дархан байдлыг хангах**

- ✓5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл алагчилал
- ✓17 дугаар зүйл. Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах
- ✓18 дугаар зүйл. Чөлөөтэй зорчих болон иргэний харьяалаллаа чөлөөтэй сонгох эрх
- ✓19 дүгээр зүйл. Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх
- ✓22 дугаар зүйл. Хувийн нууцыг хүндэтгэх
- ✓23 дугаар зүйл. Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх

**Эдийн засаг, нийгэм, улс төрийн оролцооны эрхүүд**

- ✓21 дүгээр зүйл. Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө
- ✓24 дүгээр зүйл. Боловсрол
- ✓25 дугаар зүйл. Эрүүл мэнд
- ✓26 дугаар зүйл. Нөхөн сэргээлт
- ✓27 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлт
- ✓28 дугаар зүйл. Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал
- ✓29 дүгээр зүйл. Улс төр, нийгмийн амьдралд оролцох

**Нийгмийн хүртээмж, оролцоог хангаж буй байдал**

- ✓8 дугаар зүйл. Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх
- ✓9 дүгээр зүйл. Хүртээмж
- ✓20 дугаар зүйл. Хувийн хөдөлгөөн
- ✓30 дугаар зүйл. Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх

**Хуулийн өмнө тэгш байх эрхүүд**

- ✓10 дугаар зүйл. Амьд явах эрх
- ✓12 дугаар зүйл. Хуулийн өмнө тэгш байх эрх
- ✓13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох
- ✓14 дүгээр зүйл. Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх
- ✓15 дугаар зүйл. Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх

Тухайлсан бүлгүүд ба тэдгээрийн эрхийг хангах

- ✓6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
- ✓7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
- ✓16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх

Конвенцын хэрэгжилт, хяналт, хамтын ажиллагаа

- •31 дүгээр зүйл. Статистик, тоон мэдээллийг цуглуулах
- •32 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа
- •33 дугаар зүйл. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих

## Нэг. Хувь хүн, гэр бүл, халдашгүй дархан байдлыг хангах тухай эрхүүд

ХБХЭТХК-д ХБХ-ний эрхийг хангаж, хамгаалахаас гадна, тэдгээрийн нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжих тухай онцгойлон тусгасан байдаг. Энэхүү нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хувь хүн, гэр бүл, халдашгүй дархан байдлыг хангахтай холбоотой тусгай эрхүүдийг зааж өгсөн бөгөөд тус бүрийг дараах хуулиудаар зохицуулж байна.

**Адил тэгш байдал, үл алагчлалтай холбоотой асуудлууд тодорхойлолт байдлаар туссан хэдий ч, хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхсан тохиолдолд авах арга хэмжээ, зохицуулалт дутмаг байна.** ХБХЭТК-ийн 5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл алагчлалтай холбоотой эрхийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчлах явдлыг хориглох, адил тэгш, үр дүнтэй хамгаалалтыг бий болгох, тэгш байдлыг хөхиүлэн дэмжиж, тэгш, үр дүнтэй хамгаалалтыг бий болгох талаар заасан байдаг. Үүний дагуу, ХБХЭТХ-д 4.1.2."хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах" тухай тодорхойлолтыг тусгаж, энэ хуулийг зөрчсөн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зохицуулахаар заасан. Гэвч, Эрүүгийн тухай хуулийн 14 дүгээр бүлэг. Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт хамааруулан 14.1 дүгээр зүйл болох ’Ялгаварлан гадуурхах’ тухай зүйлээр асуудлыг зохицуулсан боловч, уг тодорхойлолтын хүрээнд хөгжлийн бэрхшээл бус эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхсан тохиолдолд шийтгэх тухай агуулга л тусжээ. Үндсэн эрхүүдийг хангах чиглэлд Боловсролын ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хуулиуд дээр төрөөс баримтлах үндсэн зарчмууд хэлбэрээр туссан байна. Гэвч энэхүү ерөнхий зарчим байдлаар тусгагдсан асуудлуудын хувьд ХБХ-үүдийн сурч боловсрол эрхийн хэрэгжилтийг хангах, тэднийг боловсролоос ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхад чиглэсэн хууль эрх зүйн заалт хэрэгжилт дутмаг, үр дүнгүй байна (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын ялгаварлан гадуурхалтад өртөх, нийгмийн сөрөг хандлагын судалгаа, 2021). Харин Хөдөлмөрийн тухай хууль дээр нийтлэг баримтлах зарчим (5 дугаар зүйл) болон тухайлсан зүйлүүдээр (6 болон 144 дүгээр зүйл) нарийвчлан зохицуулжээ. Монгол Улсад түгээмэл тохиолддог ялгаварлан гадуурхалтын төрөлд Хөгжлийн бэрхшээл, өвчний улмаас ялгаварлан гадуурхах асуудал ордог боловч, энэ талаар хуулийн байгууллагад хандсан тохиолдлууд байхгүй байгаа нь гомдол, зөрчил, мэдээллийг зохицуулж буй хууль, эрх зүйд хариу арга хэмжээний талаар мэдлэггүй байх, зүйл заалт тодорхойгүй байх зэрэг асуудлуудаас үүдэлтэй

**Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийнхөө нэгдмэл байдлыг хүндэтгүүлэх, хамгаалуулахтай холбоотой эрх нь сэтгэцийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд зөрчигдөж байна.** ХБХЭТК-ын зорилгод нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжих тухай заасан байдаг. Гэвч, 2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороонд илгээсэн ‘Сүүдэр тайлан’-д дурдсанаар, нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой эрхүүдийг зохицуулж буй Эрүүл мэндийн тухай хуулийн 32-р зүйлд туссан Эхийн хэвлий дэх ураг удамшлын болон бие эрхтний гаж хөгжилтэй болох нь тогтоогдсон үед жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах тухай заалт мөн уг хуулийн дагуу Эрүүл мэндийн сайд 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А/387 дугаар тушаалын хавсралтаар баталсан Үр хөндөлтийг

зохицуулах журмуудад иргэний эрх зүйн чадамжгүй сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн өмнөөс хууль ёсны асран хамгаалагч нь шийдвэр гаргахаар заажээ. Эдгээр зүйл заалтууд нь сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйгээс зөвшөөрөл авах талаар огт дурдаагүй, зөвхөн асран хамгаалагчийн шийдвэрээр үр хөндөлт хийхээр зааж байгаа нь хүний нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх боломжийг хязгаарлаж, албадан үр хөндөх, үрийн суваг боох зэрэг хүний нөхөн үржихүйн эрхийг нь зөрчиж байна гэж дүгнэжээ.

**Сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн хувьд чөлөөтэй зорчих, иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх нь хязгаарлагдмал байгаа бөгөөд Харьяатын тухай хуулийн 10-р зүйлд энэхүү эрхийг зөрчсөн заалтыг тусгажээ.** Монгол Улсын иргэн чөлөөтэй зорчих, иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх нь 4 дэд эрхээс бүрдэх бөгөөд иргэний харьяаллаа олж авах, өөрчлөх, төрөлх улсаа орхин явах, эх орондоо эргэн ирэх эрхүүдийг тусгасан байдаг. Эдгээр эрхийг, Монгол Улсын хувьд ‘Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах’ тухай хууль болон ‘Харьяатын тухай хууль’ тус бүрээр зохицуулдаг боловч ‘Иргэний хуулийн 18 дугаар зүйлд Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх ‘эрх зүйн чадамжгүй иргэн хэмээн тодорхойлдог учраас уг хууль мөн гол зохицуулалт болдог. ‘Монгол Улсын иргэн’ гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах’ тухай хуульд зааснаар ‘эрх зүйн чадамжгүй’ иргэнийг заавал асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамт гадаадад зорчих эрхийг олгосон байдаг. Тиймээс, асран хамгаалагчийн дэмжлэггүйгээр гадаадад зорчих эрх нь хангагдахааргүй байна. Харин ‘Харьяатын тухай хууль’-д харьяатаас гарах асуудалд хөгжлийн бэрхшээлтэй хамааралтай ямар нэгэн заалт байхгүй байгаа бөгөөд харин уг хуулийн 10 дугаар зүйлд Монгол Улсын харьяат болгохоос татгалзах, түдгэлзүүлэх үндэслэлийн нэг нь хүсэлт гаргагчийн өргөдлийн хүлээн авахаас түдгэлзүүлэх тохиолдол нь 4/сэтгэл мэдрэлийн буюу гоц халдвартай өвчтэй нь зохих журмаар тогтоогдсон тохиолдолд өргөдлийг түдгэлзүүлнэ гэжээ. Энэ нь ХБХЭТК-н 18 дугаар зүйлд заасан чөлөөтэй зорчих, иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхийг нь хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хязгаарласан буюу түдгэлзүүлсэн нь уг конвенцыг мөрдөх үүрэгтэй оролцогч орны хувьд бүрэн зөрчиж байгааг харуулж байна.

**ХБХ-д ээлтэй орчин бүрдээгүй, дэд бүтэц хангалтгүй, хувийн тусламжийн үйлчилгээ хөгжөөгүй нь ХБХ бие даан амьдрахад шаардлагатай суурь нөхцөлүүдийг хязгаарлаж улмаар байнгын гэр бүл, асран хамгаалагчаас хамааралтай болгож байна.** Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрхийн хүрээнд оршин суух газар, хаана хэнтэй амьдрахаа сонгох, оршин суугаа орчиндоо бүрэн дүүрэн оролцохын тулд хувийн туслалцаа авах боломжтой байх, нийтийн үйлчилгээг тэгш хүртэхтэй холбоотой нөхцөлөөр хангуулах эрхийн тухай заасан байдаг. Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн нийт 18 эрхийг баталгаатай эдлэхээр зааж өгсөн бөгөөд түүний 13-т халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зааж өгсөн бөгөөд үүнд иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална хэмээн заажээ. Үүнийг зохицуулах зорилгоор ХБХЭТХ-ийн 4.1.11."бие даан амьдрах эрх" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломж хэмээн тусгасан байдаг. Гэвч, конвенцын уг зүйл дээр бие даан амьдрах эрхийг тайлбарлахдаа дурдсан ‘нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, объектыг хэрэглэх боломжтой байх’ хэмээх нэр томьёог тусгасан

боловч, Монгол Улсын хууль тогтоомжуудад үүнийг тодорхойлсон заалт байхгүйгээс аливаа стандарт, шаардлагын хамрах хүрээ мөн харилцан адилгүй тодорхойлогдож байна. Энэ нь ХБХ-ийг боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах, амьжиргаагаа залгуулж, бие даан амьдрахын тулд ажил хөдөлмөр эрхлэх зэрэг эрхүүдийг хязгаарласан эс үйлдэхүй юм. Тиймээс, ХБХ нь өөрсдийн бие даан амьдрах, боловсрох, хөгжих эрхээ хязгаарлуулснаар байнга гэр бүл, асран хамгаалагчаас эдийн засаг, нийгмийн оролцооны хувьд хамааралтай байх нөхцөл рүү түлхэгдэж байна.

**ХБХЭТХ-аас бусад уг асуудлыг нарийвчлан зохицуулж буй хуулиудад Хөгжлийн бэрхшээлтэй хүн болон тэдгээрийн эрүүл мэндийн болон нөхөн сэргээлтийн талаарх нууцлалын тухай нарийвчилсан зохицуулалт дутмаг байна**. ХБХ-ий хувийн нууцыг хүндэтгэх асуудал нь ХБХЭТХ-д тодорхой заагдсан бөгөөд хамаарах бусад хуулиудад нийтлэг байдлаар буюу аливаа иргэний эрүүл мэндийн мэдээлэл нь хүний эмзэг мэдээлэл гэдэг ангиллаар тусгагдаж, хамгаалуулахаар заагджээ. Тухайлбал, ХБХЭХТК-ийн 22 дугаар зүйлд заасан ‘ХБХ-ий хувийн нууцыг хүндэтгэх’ эрхийн хүрээнд хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс хууль бусаар оролцох, халдах, захидал харилцааных нь нууцад нэр төр, алдан хүндэд нь халдах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн, эрүүл мэндийн болон нөхөн сэргээлтийн талаарх нууцлалыг хамгаалах тухай заасан байдаг. Уг асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан ‘Хувийн нууцыг хамгаалах’ зүйлээр хуульчилж, конвенцын заалтуудыг бүрэн тусгасан бөгөөд нэмэлтээр эд хөрөнгийн нууцыг хамгаалах болон ХБХ-д үйлчилгээ үзүүлж байгаа аливаа этгээдүүдийг нууцыг нь задруулахыг хориглосон нэмэлт зааж оруулах байдлаар тусгайлан тодотгожээ. Үүнээс гадна, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар уг асуудлыг нарийвчлан зохицуулдаг бөгөөд уг хуулийн 5 дугаар зүйл болох ‘Мэдээлэл цуглуулах, тухай заасан бөгөөд 4 дүгээр зүйлд заасан хуулийн нэр томьёоны тодорхойлолтод ‘4.1.15."эрүүл мэндийн мэдээлэл" гэж хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг’ тусган заажээ. Уг тодорхойлолтод заасан эрүүл мэндээс өөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарч болох тодорхойлолт, ‘хөгжлийн бэрхшээл’ гэсэн нэр томьёо уг хуульд тусгагдаагүй байна. Үүнээс гадна, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн ‘мэдээллийн эзэн’ гэсэн тодорхойлолтод зааснаар Иргэний хуулийн 18.2-р зүйл заасан иргэн буюу Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, уг хуулийн дагуу асран хамгаалагч нь эзэн нь байхаар зохицуулагджээ. Үүний дагуу, Зөрчлийн тухай хуулийн 6.27 дугаар зүйл.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан ‘Хүний эмзэг мэдээллийг’ хууль бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор хариу арга хэмжээг тодорхой заажээ.

**Сэтгэцийн бэрхшээлтэй хүний гэр бүл болох эрх нь Гэр бүлийн тухай хууль болон Иргэний тухай хуулиудад заасан заалтуудаар хязгаарлагдаж байна**. ХБХЭТК-ийн 24 дүгээр зүйлд заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орон байр болон гэр бүлийг хүндэтгэх чиглэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд гэрлэлт, нөхөн үржихүйн эрх гэх мэт гэрлэлт болон гэр бүлийн харилцааг хөндөж авч үздэг. Үүнээс гадна, хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдийн асран хамгаалуулах арга хэмжээг авч үздэг. Эдгээр асуудлыг ХБХЭТХ-ийн 6 дугаар зүйл буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах тухай зүйлийн 6.5.2.-т гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх нь ялгаварлан гадуурхалт болохыг хуульчилж өгчээ. Үүнээс гадна, уг хуулийн 28 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, тэр дундаа эцэг эх, асран хамгаалагчдын хүлээх үүргийг тухайлан зааж өгсөн нь зохицуулалтад сайтар туссаныг харуулж байна. Гэвч гэр бүлийн харилцаа, түүнд дотроо хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих асуудлыг Гэр бүлийн тухай хуулиар заах боловч уг хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлыг онцлон дурдсан ямар ч заалт байхгүй байна. Уг хуулийн 4 дүгээр зүйлд гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчимд гэрлэлт нь тэгш эрхт харилцаан дээр үндэслэхийг заасан боловч иргэний гэрлэхэд ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтад хөгжлийн бэрхшээл бус үндэс угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгийн талаар л тусгажээ. Харин уг хуулийн 8 дугаар зүйлд гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээг заавал хийлгэж, түүн дундаа сэтгэцийн өвчний шинж тэмдэг илэрсэн бол мэргэжлийн байгууллагад шинжилгээ хийлгэж, түүний хариуг гэрлэхийг хүсэгчдэд танилцуулж, удамшил, гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгч, тэдний хэн нэг нь энэ хуулийн 8.2-т заасан өвчтэй нь тогтоогдсон бол түүний үр дагаврын талаар тайлбарлаж өгнө гэжээ. Мөн 9 дүгээр зүйлд заасан ‘Гэрлэхэд харшлах шалтгаан’-д гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй гэсэн шалтгааныг оруулжээ. Энэ нь ХБХ-ий гэрлэлтийн асуудлыг зөвхөн сэтгэцийн архаг өвчтэй хүний тохиолдолд онцлон хязгаарлаж байгааг харуулж байна. Гэвч уг 9 дүгээр зүйл нь өөрөө ХБХЭТК-н 23.1 дүгээр зүйлд заасан гэрлэх насанд хүрсэн ХБХ-ий гэр бүл болох эрхийг гэрлэх хүнийх нь бүрэн, чөлөөтэй өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хүлээн зөвшөөрөх заалтыг бүрэн зөрчиж байгаа хуулийн заалт болж байна. Энэ нь Иргэний тухай хуульд сэтгэцийн өвчтэй иргэний эрх зүйн чадамжгүй гэж үздэгтэй мөн холбоотой юм. Мөн хүүхдээ асрамждаа авах асуудлын хүрээнд ХБХЭТХ-ийн 6.5.3-т ХБХ-ийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг үр хүүхдээ асрамждаа авах эрхийг хязгаарлах нь ялгаварлан гадуурхалт болохыг тусгаж өгсөн нь чухал заалт болж байна.

### Хоёр. Эдийн засаг, нийгэм, улс төрийн оролцооны эрхүүд

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл хүртэх эрх чөлөө нь бүрэн хангагдахад шаардлагатай арга хэмжээнүүдийг тусгасан заалтууд дутмаг, конвенцод заагдсан арга хэмжээг авах талууд тодорхойгүй байна**. ХБХЭТК-ын 21 дүгээр зүйлд заасан Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө нь ХБХ-ийг өөрсдийг сонгосон харилцааны бүх төрлийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрхтэй тухай заасан бөгөөд үүний тулд оролцогч орнууд нийгмийн бүх гишүүнд зориулсан мэдээллийг түгээхдээ хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн хэлбэрт нийцсэн арга замаар хүргэх, хүртээмжтэй байлгахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авахаар заасан. ХБХЭТХ-д өөр олон эрхүүдийг конвенцтой нэгэн адилаар тусгасан ч, уг эрхийг хангахтай холбоотой тухайлсан хуулийн зүйл дутмаг байна. Ялангуяа, уг конвенцод заасан албан харилцаанд дохионы хэл, брайль үсэг гэх мэт ХБХ-ий сонгосон мэдээлэл хүртэх харилцааны бусад арга зам, хэлбэр, хэв маягийг ашиглах, мөн нийгмийн бүх гишүүдэд үйлчилгээ үзүүлдэг хувийн ААН-үүдийг мэдээлэл түгээх, үйлчилгээ үзүүлэхдээ хүртээмжтэй

байлгахыг уриалах, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн үзүүлдэг үйлчилгээг ХБХ-т хүртээмжтэй байлгах заалтууд орхигдсон байна. Уг заалттай нийцэхүйц нэг заалт байгаа нь ХБХЭТХ-ийн 28 дугаар зүйлд заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хүрээнд ХБХЭТХ-ийн 28.5-д Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой аливаа бодлого, шийдвэрийг гаргах явцад тэднийг үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана хэмээн тусгасан байна. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх боломжийн тухай заасан ганц зохицуулалт байна. Харин уг хуулийн 11 дүгээр зүйл. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх тухай заалтууд нь мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээдийг өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлэхээр заасан боловч ХБХ-ий мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээг зөвхөн телевиз, цахим хуудас, нэвтрүүлгийн хүрээнд илүү анхаарчээ. Гэвч, хараагүй иргэдэд зориулсан брайл үсгийг ашиглан мэдээлэл түгээх, нийгмийн харилцаанд оролцоход дэмжлэг үзүүлэх талаар 11 дүгээр зүйлд огт дурдаагүй байна. Энэ нь эдгээр иргэдийг нийгмийн харилцаан оролцоход шаардлагатай олон төрлийн мэдээлэл хүртэх боломжийг нь хязгаарлаж байгаа учраас түүний дагуу үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх боломжийг нь мөн дордуулж байгааг дурдах нь зүйтэй.

**Конвенцын 24 дүгээр зүйлд заасан Боловсролын эрхтэй хууль, эрхзүйн орчинд хангалттай сайн тусгасан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг боловсрол эзэмшихэд шаардлагатай сургалтын орчин, хүртээмжтэй сургалтын хэрэглэгдэхүүн тохируулга, багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй болон эцэг эх асран хамгаалагч нарын тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг ойлголт хангалтгүй байгаагаас хууль дүрэм бүх газарт бүрэн дүүрэн хэрэгжихгүй байна**. ХБЭТХ-н 15 дугаар зүйлд бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжлийн сургалтын төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх, суралцагчийн онцлогт нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг тохируулах, суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг бий болгох асуудлыг тусган авч үзсэн. Энэ хүрээнд ХБХЭТХ-ийн 4 дүгээр бүлэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг Сурч боловсрох эрх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл, Багшийн мэргэжил гэсэн 3 дэд зүйлээр тусгаж, эрхийг нь баталгаажуулсан байдаг. Үүнтэй нийцүүлэн, салбарын хууль, журмуудыг мөн мөрдөн ажиллаж байна. Суралцах эрхийг хангах хүрээнд, Монгол улс 2023 онд Боловсролын багц хуулийг баталж дагалдах бүх хуульдаа боловсролын зарчим тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байхыг тодорхойлон тусгасан. Тухайлбал, Боловсролын ерөнхий хуульд “4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж...” гэж; “3.1.24."ялгаатай хэрэгцээ" гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг ойлгоно” гэж; боловсролын бодлого, үйл ажиллагаанд “5.1.3.тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх” зарчмыг баримтлах, суралцагч нь “10.1.9.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангагдах;”, “10.1.11.ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор

хангагдах” эрхтэй хэмээн заасан бол Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, багшийн арга зүй, сургалтын орчин, санхүүжилт, эцэг эхийн оролцоо хамтын ажиллагааг бүхэлд нь тусгасан “Тэгш хамруулан сургах боловсрол” гэсэн бие даасан бүлэг /гуравдугаар бүлэг/ батлагдаж, заалт бүрд Боловсролын ерөнхий хуульд туссан үзэл санааг шингээн хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зохицуулалтыг хуульчилсан. БШУЯ-ны сайдын 2022 оны 12 сарын А/553 дугаар тушаалаар “Тэгш хамруулах боловсролын талаар баримтлах чиглэл”-ийг баталж, 13 чиглэлээр 44 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөлийг хангах хүрээнд, БШУЯ-ны сайдын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/184 тушаалаар батлагдсан Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэршээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмын огт хэрэгжихгүй байна. Сургууль, цэцэрлэгийн багш удирдлагууд, тохирох хэрэглэгдэхүүний талаарх ойлголт мэдлэг байхгүй байна. Ердийн сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хэрэгцээндээ нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн болон бусад дэмжих үйлчилгээг түүнчлэн сургалтын туслах хэрэгсэл болон хүртээмжтэй хэлбэрээр хэвлэсэн сурах бичгээр хангагдаж чадахгүй байна. Тухайлбал ердийн сургуульд суралцаж буй хараагүй хүүхдүүд брайл үсгээр хэвлэсэн ном сурах бичиггүй, зарим тохиолдолд брайл самбар, шивүүр, брайл цаасыг хаанаас авах талаар мэдээллийн талаарх ойлголтгүй байна. Ойлгоход хялбар форматаар ном, сурах бичиг боловсруулах, хэвлэх, дохионы хэлний хэлмэрч орчуулгаар хангах үйлчилгээ огт байхгүй.

Багш нарыг бэлтгэх, ажиллуулах хүрээнд, багш бэлтгэдэг их дээд сургуулиуд хичээлээрээ хөгжлийн бэрхшээлийн төрөл, шалтгаан, онцлог, хөгжлийн бэрхшээл тус бүрд заах арга зүй гэхчлэн зааж байгаа нь хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүн бүрд ялгаатай зааварчилгаагаар суралцахуйн түгээмэл загварыг ашиглан заах талаар ойлголт өгөхгүй байгаа нь бүгдийг тэгш хамруулах концепцээсээ зөрчилдөж байна. Их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын сургалтын төвүүдийн сургалтын орчныг хөгжлийн бэрхшээлтэй оюутан сурагчдад хүртээмжтэй болгох чиглэлд авч хэрэгжүүлж буй бодитой бодлого, үйл ажиллагаа байхгүй байна. Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшсэн багш боловсон хүчин дутагдалтай, дохионы хэл, брайль заах мэргэшсэн багш маш цөөн. Иймд боловсон хүчин бэлтгэхдээ боловсролын зээлийн сангаар, хатуу гэрээ нөхцөлтэйгөөр оюутныг гадаадад бэлтгэх, багш болж байгаа бүх оюутнуудад боловсролд тэгш хамруулах, суралцахуйн түгээмэл загварын агуулгыг заавал эзэмших хичээлийн хөтөлбөрт оруулж, дохионы хэлийг сонгон судлах хэлбэрээр суралцдаг болгох ажлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн сургуулийн удирдлага, багш нарт чиглэсэн тэгш хамруулах боловсрол, хөгжлийн бэрхшээлийн хүний эрхэд суурилсан загвар хандлага болон заах арга зүйн талаар тогтмол системтэй сургалт явуулдаг тогтолцоог бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд тэгш хамруулах орчинд чанартай боловсрол эзэмшихэд нь хэрхэн дэмжиж хамтран ажиллах болон эрхийн хэрэгжилтийг бодит болгоход хэрхэн нөлөөлж ажиллах талаар чадавх бэхжүүлэх сургалт арга хэмжээг тогтмол явуулдаг болох шаардлагатай байна.

**ХБХЭТК-ын 25 дугаар зүйлд Эрүүл мэндийн эрх нь Монгол Улсын хууль, эрх зүйд зөвхөн хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмж гэсэн хүрээнд хязгаарлагдаж байгаа бөгөөд хүртээмжтэй үйлчилгээ, эрүүл мэндийн ажилтнуудын ажиллах ур**

**чадвар, ёс зүй, урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнт эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг онцлогт нийцсэн асуудлуудыг нь орхигдуулжээ.** ХБХЭТК-н 25 дугаар зүйлд ХБХ-г хүн амд суурилсан нийтийн эрүүл мэндийн хөтөлбөр, бэлгийн болон НҮЭМ-н салбарыг оролцуулан бусад хүнд хүргэдэгтэй ижил түвшин, чанар, стандарт бүхий үнэ төлбөргүй буюу худалдан авах чадавхад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрүүдээр хангах; эрт оношлох, цаашид хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах; эрүүл мэндийн үйлчилгээг аль болох гэрт нь ойр газарт үзүүлэх; зэрэг арга хэмжээг авахаар заасан. Үүнтэй нийцүүлэн, ХБХЭТХ-н 20-р зүйлд ‘Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна’ хэмээн заасан. Гэвч ХБХЭТХ 4.1.3."тохирох хэрэглэгдэхүүн" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг; 4.1.2."хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг хэлнээ хэмээн заасныг цаашид анхаарах шаардлагатай байна. Мөн ХБХЭТХ-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн тодорхой бодлого үйл ажиллагаа байхгүй байгааг ЭМЯ-ны тайлан, төлөвлөгөө харуулж байна. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн салбар хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ гэдэг ойлголтод эмнэлгийн орчны хүртээмжтэй байдлыг хамруулан авч үзэж, эмч мэргэжилтнүүдэд хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээ, болон тэдний эрхийг таниулах арга хэмжээ, болон эмнэлгийн орчин болон үйлчилгээнд тохируулга хийх үйл ажиллагааг орхигдуулсаар байна. Эдгээр заалтууд нь ХБХЭТК-ын Эрүүл мэндий эрхийн хэсэгт заагдсан үйлчилгээний хүрээнд алагчлахгүй байх, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байршлаас үл хамааран эмнэлгийн үйлчилгээг ХБХ-ийг аль гэрт нь ойр газар хүртээмжтэйгээр хүргэх гэм мэт заалтуудыг орхигдуулжээ.

Эмч мэргэжилтнүүд, эмнэлгийн ажилтнуудыг чадавхжуулах үйл ажиллагааг Эрүүл мэндийн салбар ихэвчлэн аль нэг төслийн хүрээнд хийгдсэн нэг удаагийн сургалт үйл ажиллагаагаар хязгаарлаж байгаад хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн төлөөллийн байгууллагууд шүүмжлэлтэй хандсаар ирсэн. Цаашид эмч, эмнэлгийн ажилтан бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт ХБХ-ий онцлог хэрэгцээ, эрх, нийгмийн загварыг таниулах сургалтын агуулгыг тусгах шаардлагатай байна.

**ХБХЭТК-ын 26 дугаар зүйлд заасан Сэргээлт, Нөхөн сэргээлтийн нэгдсэн тодорхойлолт, авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрүүл мэндээс бусад салбарт тусгаагүй учраас ХБХ-ийг нийгмийн олон талт харилцаанд бие даан оролцох боломжийг хязгаарлаж байна.** Монгол Улсын хувьд ХБХЭТК-ын 26 дугаар зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний сэргээлт, нөхөн сэргээлтийн асуудлын тухайд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн бүхий л хүрээнд хамрагдахад шаардлагатай эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүрээнд сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээг бий болгож, хүртээмжтэй айлгах, салбарын ажилтнуудыг бэлтгэх, туслах тоног төхөөрөмж, технологиудыг хүртээмжтэй байлгах талаар тусгасан байдаг. Гэвч, ХБХЭТХ-д сэргээлт, нөхөн сэргээлтийн тухай тодорхойлолт тусгагдаагүй, энэхүү нэр томьёог

ашиглаагүй байгаа бөгөөд сэргээн засалт хэмээх хэллэгийг ашигласан цөөн заалт байна. Тухайлбал, Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.21-т "сэргээн засах" гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах болон эмнэлгийн бусад мэргэжилтний хамтын цогц үйл ажиллагааг; хууль, болон ХБХЭТХ-ийн 20-р зүйлд заасан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хэсэгт заасан 20.1-т Төрөөс ХБИ-ийг сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ хэмээн заасан. ХБХЭТХ-д сэргээн засах арга хэмжээг зохицуулсан заалтууд нь гол төлөв санхүүжилтийн асуудлыг хөндсөн байдлаар тусгагджээ. Тухайлбал, 28 дугаар зүйлд заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хэсэгт сэргээн засах үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх тухай, 26 дугаар зүйлд Нийгмийн халамжийн сангаас сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлтийн тухай заажээ. Эдгээр заалтуудаас харахад, нөхөн сэргээлтийг гол төлөв түүнийг эрүүл мэндийн асуудалтай холбон тайлбарлаж, авах арга хэмжээг Эрүүл мэндийн салбартай хамааруулан, арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Монголд нийтлэг ойлгож буй сэргээн засах анагаах ухаанд хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч гэсэн гурван үндсэн мэргэжил байдгаас Монгол Улс хөдөлгөөн засалчийг 2011 оноос, хөдөлмөр засалчийг 2014 оноос бэлтгэж эхэлсэн бол хэл засалчийг хараахан бэлдэж эхлээгүй байна. Бэлдэж буй хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалчийн ангид элсэн суралцагчдын тоо хангалтгүй байгаа зэргээс үзэхэд манайд мэргэжлийн сэргээн засалч дутагдалтай байна. Урт хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээнд ямар өвчнийг хамруулж авч үзэх талаарх ойлголтын зөрүүтэй байдлаас шалтгаалан зарим өвчний зардал ЭМД-с олгогдохгүй байна. Тухайлбал: Нуруу нугасны гэмтэлтэй иргэдэд зонхилон тохиолддог L89 кодтой “холголт цооролт”-өвчний оношийг зөвхөн Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв эмнэлэг ашиглах боломжтой. Энэ шалтгаанаар дээрх өвчнөөр өвдсөн олон арван хөгжлийн бэрхшээлтэй иргэд оршин суугаа газрынхаа эмнэлэгт өвчний оношны дагуу үйлчилгээ авч чаддаггүй. Цаашлаад иргэд цооролтын шархтайгаа тэмцэж, гэр бүлийнхний дэмжлэгтэй шархаа арчлах оролдлого хийж эдийн засаг, сэтгэл санаа, цаашлаад амь насаараа хохирч байгаа бодит кейс олон байна.

Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах, нөхөн сэргээгдэх болон бусад төрлийн эмчилгээ үйлчилгээ авах эрхүүд ХБХЭТХ-д тодорхой тусгалаа олсон хэдий ч Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тодорхой зохицуулалт хийх шаардлагатай байна. Мөн ХБХЭТХ-н 20.1, 20.2, 20.3 дахь заалтыг хэрэгжилт хангалтгүй байна. ХБХ-ийг туслах хэрэгслээр хангах журам зохицуулалт туслах технологи хэрэгслийг сонголт хийн худалдан авах боломжийг хязгаарлан зөвхөн хатуу тогтоосон жишиг үнийн хүрээнд цөөн тооны хэрэгслийг худалдан авдаг нь сонголттой байх эрхийг зөрчиж байна. Хамгийн гол нь хүний эрхэд суурилсан загварт суурилаагүй өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрэгцээндээ нийцүүлэн нийгмийн харилцаанд бие даан оролцоход нь нэн шаардлагатай чанартай боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээг огт тусгаагүй байна. ,

**ХБХЭТК-ийн 27 дугаар зүйл заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн эрхийг хангахад чиглэсэн зүйл заалт, арга хэмжээ нь ХБХЭТХ болон Хөдөлмөрийн тухай хуулиудтай бүрэн нийцтэй байна.** Хөгжлийн бэршээлтэй хүмүүсийн хувьд хүртээлтэй, нээлттэй сонгосон, эсхүл зөвшөөрлөө чөлөөтэй өгсөн нөхцөлд эрхэлж

буй хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжтой байхыг ХБХЭТК-н 27 дугаар зүйлээр баталгаажуулсан. Үүнд: ажилд хөлсөөр ажиллах, мэргэжлийн хувьд өсөн дэвжих, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах, хөдөлмөрт ижил тэгш боломж, адил цалин хөлс авах, дарамт шахалтад өртөхгүй байх, өргөдөл гомдлоо барагдуулах эрхтэй байх, хөдөлмөрийн зах зээлд ажил хайх, ажилд орох, болон ажилдаа буцаж орох, хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах, төрийн албанд ажиллуулах улмаар хөтөлбөр боловсруулах зэрэг эрхийг тусгасан. Үүнтэй нийцүүлэн хэрэгжүүлж байгаа гол хуулиуд нь ХБХЭТХ-ийн 5 дугаар бүлэгт заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт ба Хөдөлмөрийн тухай хуулиуд байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг холбогдох хуульд заасны дагуу тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өмчийн хэлбэр үл хамааран 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах, хэрэв ажиллуулаагүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү төлбөрийг төлөх, энэхүү төлбөрөөс чөлөөлөх нөхцөлийг заах зэрэг ач холбогдол бүхий зохицуулалтуудыг 144.1-144.8 дахь хэсгүүдэд тусгасан. Гэсэн хэдий ч тус хуулийн заалт төрийн байгууллагууд дээр хангалтгүй хэрэгждэг. Учир нь хуульд заасан торгуулийг төлөх санхүүгийн эх үүсвэр төсөвт тусгагдаагүй гэсэн нийтлэг шалтгааныг тайлбарладаг байна. ХНХЯ-ны 2021 онд хийсэн судалгаагаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийгмийн даатгалын санд бүртгэлтэй 25-аас дээш ажилтантай 6.5 мянган байгууллагаас судалгаанд хамрагдсан 3.2 мянган байгууллага 9.6 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 7.2 мянга гаруй иргэн ажиллуулж байгаа нь хуулийн хэрэгжилт аж ахуйн нэгж, байгууллагад 61 хувь, төрийн байгууллагад 59 хувийн хэрэгжилттэй байна гэсэн дүгнэлт гарсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.6 дугаар зүйлд Ажил олгогч энэ хуулийн 144.1-д заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгохыг хориглоно; хэмээн заасан ч тохирох хэрэглэгдэхүүнийг бий болгох, үнэлэх, хэрэгжүүлэх механизм тодорхойгүй тул хэрэгжилт хангагдахгүй байна.

**ХБХЭТК-ын 28 дугаар зүйлд заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьжиргаа, нийгмийн хамгааллын баталгааг хангах зүйл заалт нь холбогдох хуулиудад агуулга болон үйл ажиллагааны хувьд бүрэн тусчээ.** Конвенцын уг зүйлийн агуулга нь, амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгааллын баталгаа хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийн гэр бүл амьжиргааны түвшинд байлгахад чиглэн нийгмийн хамгааллын болон ядуурлыг бууруулах хөтөлбөрт хамруулах, орон сууцаар хангах тухай заалтууд тусгагдсан байдаг.Үүнтэй нийцүүлэн гаргасан хууль, эрх зүйн акт нь ХБХЭТХ болон Нийгмийн халамжийн тухай хууль юм. Тухайлбал, ХБХЭТХ-ийн 25 дугаар зүйлд Нийгмийн хамгаалал хүртэх эрхийг заасан бөгөөд Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт тусламжийг 16 төрлөөр жагсаан гаргаж журмаар олгохоор заажээ. Тус жагсаалтын 26.1.16.аарцаг эрхтэний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх. 25.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлж, туслах үйлчилгээ авах боломжоор хангах; заалтууд огт хэрэгжихгүй

хуулийн заалтыг хэрэгжүүлэх журам батлагдаагүй байна. Мөн нийгмийн халамжийн сангаас хүртэх тусламж хөнгөлөлтийг томьёолон заасан нь өөрийн хэрэгцээнд нийцсэн сонголтод бүтээгдэхүүн үйлчилгээ авах эрхийг хязгаарлаж байгаа төдийгүй ХБХЭТХ-н 5.1.2.х-т заасан ХБХ-ний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх тухай заалттай зөрчилдөж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах эрхийг нь баталгаажуулж, уг зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тусгасан байдаг. 2023 оны 6 сард Засгийн газраас халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгогдох мөнгөн тэтгэмжийг 325000 төгрөг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэршээлтэй гэр бүлийн гишүүн болон хүүхдээ асардаг асран хамгаалагчийн тэтгэмжийг 80,000 төгрөг болгон тус тус нэмэгдүүлсэн. Гэсэн хэдий ч инфляцын өсөлт, валюттай харьцах төгрөгийн ханшны сулрал болон өдрөөс өдөрт бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж байгаа зэрэг хүчин зүйлстэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүнд халамжийн сангаас олгож буй тусламж дэмжлэг нь амьдрах наад захын хэрэгцээг хангаж чаддаггүй. Барилга, хот байгуулалтын яамны сайдын 2023 оны 164/102 тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг баталсан ч, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг хувиарлаагүй тул хэрэгжилт 0 хувьтай байна.

**ХБХЭТК-н 29 дүгээр зүйлд заасан Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг сонгох, сонгогдох эрхийн хүрээнд сонгуулийн хуулиудад баталгаажуулсан ч, түүнээс сэтгэцийн бэрхшээлтэй иргэний улс төр, жагсаал цуглаанд оролцох эрхийг бүрэн хязгаарлажээ.** ХБХЭТК-н 29 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг тусгасан бөгөөд сонгууль өгөх журам, байр, сонгуулийн хуудас нь ашиглахад зохистой, хүртээмжтэй болон ойлгох, ашиглахад хялбар байх явдлыг хангах; ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, туслах болон шинэ технологи ашиглах замаар албан тушаал хаших, төр, засгийн байгууллагын аль ч түвшинд төрийн алба хаах; цаашлаад улс төрийн намуудын үйл ажиллагаа болон засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох; зэрэг асуудлыг тусгасан. ХБХЭТХ-н 30-р зүйлд дугаар зүйлд, мөн адил бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байх, бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох эрхтэйг тунхаглаж, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад төрийн байгууллагууд, нам эвсэл мөрийн хөтөлбөрт тусгах замаар дэмжих үүрэгтэй тухай дурдсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.27-д “Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байна”, Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 46.27-д хуулиудад “Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно” гэж (хүч сулруулсан) тусгасан, харин Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар хүргэх талаар зохицуулалт тусгаагүй байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн

сонгуулийн тухай хуулийн 5.2-т, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5.5-д болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 5.4-д “Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих ял эдэлж байгаа иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй” байхаар зохицуулсан нь оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүний сонгуульд оролцох эрхийг хязгаарласан зохицуулалт юм.

Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5-д “...сэтгэцийн өвчтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ....бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан “хөгжлийн бэрхшээлтэй хүний жагсаал, цуглаанд сайн дураараа нэгдэх, оролцох эрхийг хязгаарлаж байна. Үндсэн хуулийн 1.2-ын “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 14.1-ийн “...хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байна”, 14.2-ын “Хүнийг ..... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, 16.16-ын “...тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”, гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Конвенцын уг зүйл сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хөндөөгүй учраас конвенцод заасан уг эрхийг баталгаажуулах ажил зөрчилтэй байгаа нь харагдаж байна. Тиймээс, хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүн дотроо сэтгэцийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох, түүнтэй холбоотой улс, төр нийгмийн амьдралд оролцох эрх, зөрчлүүдийн төрлийг дахин нягталж, нэгдсэн ойлголтод хүрч, холбогдох хууль, эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт хийх, тайлбар оруулах шаардлагатай байна.

**Монгол Улсын Үндсэн хууль болон мэдээлэл, харилцаа холбоог зохицуулсан хууль, эрх зүйн актууд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх, түүний хүрээнд технологийг ашиглах хүрээнд сайтар нийцтэй байгаа боловч мэдээлэл түгээх, бэрхшээлийн янз бүрийн хэлбэрт нийцсэн мэдээлэл хүртэх, нийгмийн бүх гишүүнд хүрэх үйлчилгээг ашиглахуйц болгох дээр дутмаг байна.** ХБХЭТК-ийн 21 дүгээр зүйл хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн сонгосон харилцааны бүх төрлийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүртэх, түгээх, түүнд шаардлагатай орчныг бүрдүүлэх тухай заасан байдаг. Монгол Улсаад мэдээлэл олж авах, түгээх Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөөг “өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол , боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” хэмээн Үндсэн хуулийн 15-р зүйлд тусгасан. Харин ХБХЭТК-н 21 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийн сонгосон харилцааны бүх төрлийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, түгээх эрхээ эдлэх нөхцөл байдлыг бий болгох асуудлыг тусгасан. Тухайлбал нийгмийн бүх гишүүдэд зориулсан мэдээллийг түгээхдээ янз бүрийн хэлбэрт нийцсэн арга замаар, тухайн цаг хугацаанд нь, нэмэлт өртөг зардалгүйгээр түгээх; албан харилцаанд дохионы хэл, брайль үсэг, болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгосон мэдээлэл хүртэх харилцааны бусад арга зам, хэлбэр, хэв маягийг ашиглах, цахим үйлчилгээгээр дамжуулан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг ААН, байгууллагууд мэдээлэл түгээхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглаж болохуйц хэлбэрээр түгээх зэргийг хамруулсан.

ХБХЭТХ-ийн 8 дугаар зүйлд заасан . Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад

хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах, түүнд мэдээлэл харилцааны технологийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх нь мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэх тухай зааж, холбогдох талууд, санхүүгийн эх үүсвэр болон мэдээлэл ашиглах боломжийг нэмэгдүүлэх чиглэллд арга хэмжээг тусгажээ. Үүний дагуу, Монгол Улсын Засгийн газраас төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор E Mongolia, E-halamj системээр нийгмийн даатгалын 33, нийгмийн халамжийн 64 үйлчилгээг цахимаар хүргэж эхэлсэн. Мөн Интернетийн олон улсын стандартын байгууллага /W3C/-аас батлан гаргасан “Цахим хуудас, контентын хүртээмжийн удирдамж /WCAG/-ийг өөрийн оронд нэвтрүүлэх, цахим хуудас, контентын хүртээмжийн стандарт” батлуулахаар ажиллаж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дижитал болон бусад технологи ашиглах боломж нэмэгдэж, дижитал хүртээмжтэй мэдээллийн системийн Daisy стандарт, Микрософт SAPI дээр суурилсан Монгол сонсох программ, харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан BAT ба Dangina программууд, смарт утасны хэд хэдэн аппликейшныг ашиглаж байна.

Гэсэн хэдий хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд цахим орчинд ажиллах мэдлэг, ур чадвар муу, өөрийн смарт утас, компьютер байхгүй эсхүл дата авах санхүүгийн боломж муу, нөгөө талаас дижитал, цахим мэдээлэл үйлдвэрлэгчдийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, тохирсон тохируулга хийх мэдлэг, чадвар дутагдалтай байдаг зэрэг асуудал тулгарч байна. Нөгөө талаас Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан Брайль үсэг, аудио форматтай мэдээлэл хангалтгүй, Сонсголын бэрхшээлтэй хүмүүст дохионы хэл дээр мэдээлэл өгөх үйлчилгээ хязгаарлагдмал, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дижитал платформ, вэбсайтууд хангалттай хүртээмжтэй биш, хөдөөгийн  алслагдсан бүсийн иргэдэд шаардлагатай мэдээлэл хүрдэггүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хууль, бодлого бодит амьдрал дээр бүрэн хэрэгждэггүй зэрэг асуудал тулгарсаар байна.

## Гурав. Нийгмийн хүртээмж, оролцоог хангаж буй байдал

ХБХЭТК-ын хүрээнд нийгмийн хүртээмжийн асуудлыг хөндөж, түүнийг сайжруулахад чиглэсэн хэд хэдэн зүйлс тусгагдсан байдаг бөгөөд үүнд 8 дугаар зүйл. Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, 9 дүгээр зүйл. Хүртээмж, 20 дугаар зүйл. Хувийн хөдөлгөөн болон 30 дугаар зүйл. Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх зэрэг зүйлс багтаж байна.

**ХБ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхтэй холбоотой  хуулийн заалтууд нь хамрах хүрээ, зорилго,  оролцогч талуудын хувь хязгаарлагдмал байдлаар зохицуулагдаж байна**. ХБХЭТК-ын 8 дугаар зүйлд заасан арга хэмжээний хүрээнд нийгмийн бүхий л хүрээнд, боловсролын бүхий л түвшин, хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан ХБХ-ийн эрхийн тухай мэдлэг нэмэгдүүлэх, хандлага төлөвшүүлэх замаар ХБХ-ий нэр төр, нандин чанарыг хүндэтгэсэн, зөв хандлагыг нийгэмд бий болгох тухай заажээ.  Энэхүү 7 дугаар зүйлтэй нийцүүлэн ХБХЭТХ-ийн 7 дугаар зүйлд ХБ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх тухай тусдаа зүйл оруулж өгсөн бөгөөд Гэр бүл болон нийгмийн бүхий л хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх зорилгоор конвенцтой нэгэн адилаар ХБХ-ий эрхийн талаар сургалт, сурталчилгааг бүхий л талуудад, үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслээр

дамжуулан хүргэх талаар заажээ. Уг хуулийн 7.1.5-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх санаачилгыг дэмжих замаар нийгэмд ХБХ-ийн талаарх эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгыг агуулсан арга хэмжээг зохион байгуулахыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалган тусгажээ. Гэвч энэхүү зохицуулалт нь ХБХ болон залуучуудаар хязгаарлагдаж байгаа нь насаар ялгаварласан заалт болж байна. Мөн ХБХЭ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг зөвхөн боловсролын орчинд, эсхүл зөвхөн Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр дамжуулах мэтээр тусгаж өгсөн нь дутагдалтай байна. Мөн уг хуулийн 7.1.4-т Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлд өгөх, сургалт, сурталчилгаа явуулах арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ. Мөн конвенцын агуулгатай нийцтэй заалт болох уг хуулийн 7.1.3-т хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх эерэг хандлагыг төлөвшүүлэх асуудлыг бүх шатны боловсролын байгууллагын сурах бичигт тусгайлан тусгаж, сургалт, хичээлийн агуулгаар дамжуулан хэрэгжүүлэхээр заасан байсан боловч 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцжээ. Энэ нь ХБХ-ий эрх болон төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг нийгмийн бүхий л хүрээнд бус буцаад зөвхөн ХБХ болон тэдгээрийн гэр бүлд чиглэн хүргэж байгаа нь хязгаарлагдмал зохицуулалт болж байна. Нийгмийн бүхий л орчныг ХБХ-д ээлтэй болгохын тулд нийгмийн бүхий л гишүүд болон хуулийн этгээдүүд тэдний эрхээс гадна, хүртээмжтэй, ээлтэй орчныг бүрдүүлэхэд хуулийн хүрээнд бүх талуудад тавигддаг хуулийн заалт, шаардлага, стандартууд болон ХБХ-т зориулсан үйлчилгээг мэддэг байх шаардлагатай. Тиймээс, конвенцын 8 дугаар зүйлийг илүү сайтар нийцүүлэхийн тулд ХБХЭТХ-д заасан мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хамрах хүрээ, оролцогч талуудыг илүү өргөн хүрээнд тодорхойлж, үүрэгжүүлэх, авах арга хэмжээний төрөл, цар хүрээг өргөн хүрээнд хуульд тусгах шаардлагатай байна.

**ХБХЭТК-ийн 9 дүгээр зүйлд заасан Хүртээмжийн асуудлыг нэгдсэн байдлаар тодорхойлох, стандарт, гарын авлага гаргах, ялангуяа, нийтэд нээлттэй үйлчлэх объект, үйлчилгээг тодорхойлж тэмдэглэгээ хийх, хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх шаардлагатай байна.** ХБХЭТК-ийн 9 дүгээр зүйлд тусгайлан заасан Хүртээмжийн асуудлын хүрээнд ХБХ бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор байршлаас үл хамааран нийтэд нээлттэй үйлчлэхээр зохицуулагдсан бүхий л объект үйлчилгээг хүрэх явдлыг хангах арга хэмжээг оролцогч улсуудыг авахыг уриалсан байдаг. Үүнд, хүрээлэн буй орчин, гаднах болон доторх байгууламжууд, тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи зэргийг хамруулан үзэх бөгөөд эдгээрийг хүртэхэд тулгарч буй саадыг илрүүлэх, устгах талаар заасан байдаг. Конвенцын уг зүйлтэй нийцүүлэн ХБХЭТХ-д ХБХЭ-ийг хангах, хамгаалахад баримтлах зарчимд хоёр гол зарчмын хүрээнд буюу 5.1.3-д заасан сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх; 5.1.5-д заасан хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх тухай зарчмаар тус тус зааж бүхий л асуудлын хүрээнд баримтлахаар заажээ. Мөн уг хуулийн 6 дугаар зүйлд заасан дэд заалтуудаар Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл,

үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах болон аливаа иргэн, хуулийн этгээдүүд нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй бол ХБХ-ийг үл ялгаварлан гадуурхсан гэж үзэхээр заажээ. Эдгээр зарчим болон ялгаварлан гадуурхалтын хүрээнд хүртээмжтэй байдлыг тодорхойлсон бөгөөд конвенцтой адилаар хүртээмжийг тусдаа авч үзээгүй ч, бусад ХБХ-ний эрх тус бүр дээр хүртээмж байдлыг бий болгох арга хэмжээг тусгаж оруулжээ. Тухайлбал, 15 дугаар зүйлд заасан ХБХ-ий сурач боловсрох нөхцөл, 20 дугаар зүйлд заасан ‘Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ’, 22 дугаар зүйлд заасан ‘Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ’, 27 дугаар зүйл заасан Хууль зүйн туслалцаа авах эрхийн хүрээнд шүүх, Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь ХБХ-д хүртээмжтэй байх, 30 дугаар зүйлд заасан ‘Улс төрийн үйл ажиллагаанд оролцох’ хэсэгт сонгуулийн сурталчилгаа хүртээмжтэй байх, ‘Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ’, 35 дугаар зүйл заасан ‘Соёл, урлагийн бүтээлийн хүртээмж’, 36 дугаар зүйлд заасан ‘Онцгой байдлын үед авах арга хэмжээ’-д мэдээллийг хүртээмжтэйгээр хүргэх талаар тус тус заажээ. Эдгээрээс гадна, конвенцод тусгайлан тодотгосон мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй байлгах асуудалтай нийцүүлэн ХБХЭТХ-ийн 11 дүгээр зүйлд тусгайлсан ‘Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх’ тухай зохицуулж, түүн дотроо ХБХ-ийг аливаа мэдээлэл авах, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлд авах арга хэмжээ авахыг мэдээлэл түгээдэг хуулийн этгээдээс гадна төрийн байгууллага, бусад хуулийн этгээдүүдэд үүрэг болгож, дэмжих зохицуулалтыг тусгаж өгчээ. Үүнтэй холбоотойгоор, Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд Барилгын үйл ажиллагааны зарчмын 11.1.6-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах: барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх; зарчмыг тусгаж өгчээ. Харин мэдээлэл, харилцаа холбооны хувьд, ‘Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага’-ын 5. Сонгон шалгаруулалтад оролцогчийг сонгох шалгуур үзүүлэлтийн 5.1.5-д зааснаар Өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргадаг байх тухай шаардлага тавьж, түүний дагуу үнэлэх аргачлалд Тухайн телевизээр хадмал тайлбар, дохионы хэлтэйгээр нэвтрүүлсэн нэвтрүүлгийн нийт нэвтрүүлэгт эзлэх хувь нь 3-5 хувь байхаар заажээ. Үүнээс гадна, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар бүлэг буюу Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд хориглох зүйлсэд хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас үзэн ядах, ялгаварлан гадуурхсан агуулга бүхий нэвтрүүлэг, зар сурталчилгааг хориглохоор заажээ. ХБХЭКТК-ын хүртээмжтэй холбоотой заасан заалтуудаас орхигдсон зүйлс нь нийтэд үйлчлэх обьект, үйлчилгээг хүртээмжтэй байлгахад хүний туслалцаа, хэлбэрүүд, тухайлбал, хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчдыг зуучлалын бий болгох мөн хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг зохиох, үйлдвэрлэх, түгээн борлуулах асуудлууд, тэдгээрийг хөхиүлэн дэмжих талаар огт зохицуулалтгүй орхигджээ.

**ХБХЭТК-ын 20 дугаар зүйлд заасан хувийн хөдөлгөөнийг дэмжих хүрээнд туслах үйлчилгээ хүргэх, туслах мэргэжсэн ажилтнуудыг бэлтгэх, туслах технологийг үйлдвэрлэх, дэмжих асуудлууд орхигджээ.** ХБХЭТК-ын 20 дугаар зүйлд заасан Хувийн хөдөлгөөнтэй холбоотой хэсгүүдэд ХБХ-ийн бие даасан байдлыг байж болох дээд түвшинд хангах замаар хувийн хөдөлгөөний хангах, түүн дотроо дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологийг үйлдвэрлэх, боловсруулах, үйлчилгээ хүргэх, туслагчид болон дэмжлэг үзүүлэгчдийн үйлчилгээг дэмжих, мэргэжсэн ажилтнуудыг бэлтгэх зэрэг технологи, туслах ажилтнуудын аль алиныг хөгжүүлэхэд анхаарсан заалтуудыг тусгажээ. Үүнтэй нийцүүлэн ХБХЭТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тохирох хэрэглэгдэхүүн" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээ гэдгийг заан тодорхойлж, уг хуулийн 6 дугаар зүйлээр 6.2.Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байхыг ялгаварлан гадуурхалт гэж үзэхээр заажээ. Мөн уг хуулийн 14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх, 17 дугаар зүйл. Хөдөлмөрлөх эрх болон 33 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих хүрээнд тусгаж өгчээ. Эдгээрээс гадна ХБХЭТХ-д заасан заалтууд нь хүрээнд гол төлөв нийгмийн хамгаалал хүртэх эрхийн хүрээнд заасан 25.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглээний протез, ортопед, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, асаргаа сувилгааны болон бусад туслах хэрэгслээр хангах болон 25.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлж, туслах үйлчилгээ авах боломжоор хангах зэргээр тусгагджээ. Мөн уг хуулийн 32 дугаар зүйлд заасан Бие даан амьдрах эрхийн хүрээнд 32.2.Хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хангах, 32.7.Төрөөс хараагүй хүнийг тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах хөтөч нохойг тусгайлан сургаж бэлтгэх зэргээр тусгажээ. Гэвч, конвенцын заалтуудтай харьцуулан харвал, тохирох хэрэглэгдэхүүн болон туслах хэрэгсэл гэдгээр илүү нарийвчлан тусгасан боловч туслах үйлчилгээ хүргэх, туслах мэргэжсэн ажилтнуудыг бэлтгэх, туслах технологийг үйлдвэрлэх, дэмжих зэрэг асуудлуудад төдийлөн анхаарал хандуулаагүй, зохицуулалт байхгүй байгаа нь харагдаж байна. Үүнээс үүдэн, хуультай нийцүүлэн гарсан аливаа хөтөлбөр, бодлого нь асуудлуудыг орхигдуулах,түүнд чиглэсэн арга хэмжээ авахгүй, дэмжих тогтолцоо бүрдүүлэхгүй байх эрсдэлтэй байна.

**ХБХЭТК-ын 30 дугаар зүйлд заасан Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх эрхийг хангахад чиглэсэн заалтууд нь ХБХ-ийг гол төлөв үр шим хүртэгч байдлаар томьёолж, төрөөс дэмжих тухай анхаарсан нь ХБХ нийгэмд өөрсдийн бүтээлээ туурвих, үнэлүүлэх, оюуны эрхээ эдлэх, хувь нэмрээ оруулах талыг нь орхигдуулсан шинжтэй байна.** ХБХЭТК-ын 30 дугаар зүйлд заасан Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх эрхийг хангах хүрээнд нэг талаас эдгээр адил тэгш, хүртээмжтэйгээр оролцох, үйлчлүүлэх тухай асуудлууд бөгөөд нөгөө талаас өөрсдийн оруулж буй хувь нэмрээ адил тэгш үнэлүүлэх, оюуны өмчийн эрхээ эдлэх, хүлээн зөвшөөрөгдөх тухай асуудлууд тусгагдсан байдаг. Үүнтэй нийцүүлэн, ХБХЭТХ-ийн 33 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих, 34 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих, болон 35 дугаар зүйл. Соёл, урлагийн бүтээлийн

хүртээмжтэй байх тухай заалтуудыг тусгасан байдаг. Гэхдээ 33 дугаар зүйлд гол төлөв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулахад төрөөс тохиромжтой заал, талбай болон тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон байх; биеийн тамир, спортоор хичээллэх, өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд дэмжих үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх зэрэг илүү төрөөс хамааралтай байдлаар шийдсэн нь бусад аж ахуй нэгжүүд, төрийн байгууллага, хуулийн этгээдүүд болон олон нийтийн оролцоог хязгаарласан буюу төр өөр дээрээ ачаалал авах байдлаар зохицуулсан заалт болж байна. Харин конвенцод тусгагдсан нэг асуудал нь оюуны өмчийн эрхийн асуудал боловч ХБХЭТХ-ийн 34 дүгээр зүйлд заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих тухай заалтад зөвхөн эдгээр үйл ажиллагаанд оролцох, авьяас чадвараа нээн хөгжүүлэх талаар тусгасан бөгөөд уг хуульд оюуны өмчийн асуудал нэг ч тусгагдаагүй байна. Үүнтэй адилаар, улсын хэмжээнд оюуны өмчийн асуудлыг зохицуулж буй ‘Оюуны өмчийн тухай хууль’-д мөн адил ХБИ-ийн талаар болон үл ялгаварлан гадуурхахтай холбоотой ямар нэгэн заалт байхгүй байна. Эдгээр заалтуудаас харахад Монгол Улсад уг эрх нь тэмцээн, уралдаан оролцож байгаа тохиолдолд мөнгөн урамшуулал олгох зэрэг гол төлөв урамшууллын тогтолцоог тусгасан шинжтэй байна. Гэвч эдгээрийг ХБХ-ийг хүртээмжтэй хамруулах, оролцуулахыг нь дэмжсэн шаардлага, стандартыг гаргаж мөрдүүлэх зэргээр зохицуулалтын шинжтэйгээр шийдэх нь олон нийтэд ойлголтыг нэмэгдүүлэх, ээлтэй, хүртээмжтэй байдал бүхий л орчинд бий болох илүү үр дүнтэй, үр ашигтай шийдэх боломж юм. Харин соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих, соёл, урлагийн бүтээлийн хүртээмжийн асуудлын хүрээнд гол төлөв хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эдгээрийг хүртээмжтэй байдлаар хүргэх эсхүл оролцоход, авьяас чадвараа нээн хөгжүүлэх боломжийг дэмжинэ зэрэг гэсэн байдлаар тусгажээ. Мөн Соёлын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Соёлын үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлагын 37.3-т Соёлын үйлчилгээ эрхлэх барилга байгууламж, танхим, талбай нь ба хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх талаар заажээ. Гэвч, ХБХ өөрөө бүтээгч байх, оюуны өмчийн эрхээ хамгаалуулах, өөрөө бүтээлээ нийгэмд хүргэх, адил тэгш үнэлүүлэх, өрсөлдөх чиглэлд ямар нэгэн зохицуулалт дутмаг байгаа нь харагдаж байна.

## Дөрөв . Хуулийн өмнө тэгш байх эрхүүд

ХБХЭТК-д заасан эрхүүдээс амьд явах, халдашгүй дархан байх, хуулийн өмнө тэгш байхтай холбоотой 5 гол зүйл байдаг. Үүнд, 10 дугаар зүйл. Амьд явах эрх, 12 дугаар зүйл. Хуулийн өмнө тэгш байх эрх, 13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох, 14 дүгээр зүйл. Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх, 15 дугаар зүйл. Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх зэрэг заалтууд орно. Эдгээр зүйлийг Монгол Улсын Үндсэн хууль, ХБХЭТХ, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хууль зэрэг нийтлэг хуулиудаар зохицуулж байна.

**ХБХ-ий ‘Амьд явах эрх’-ийг Монгол Улсын Үндсэн хуульд амьд явах эрхийг баталгаажуулж, Монгол Улсын Эрүүгийн хуулиар хамгаалахаар нийцүүлжээ.** ХБХЭТК-ийн 10 дугаар зүйлд заасан Амьд явах эрхэд оролцогч улсууд нь хүн бүр амьд явах салшгүй эрхтэй гэдгийг нотолж, ХБХ бусдын нэгэн адил энэхүү эрхээ бүрэн дүүрэн эдлэх явдлыг

хангах шаардлагатай арга хэмжээ авна гэжээ. Уг заалттай нийцүүлсэн хууль, эрх зүйн зохицуулалт нь манай улсын хувьд Үндсэн хууль болж байгаа бөгөөд уг хуулийн 2 дугаар бүлэг болох Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 16 дугаар зүйл 1/амьд явах эрхийг тусган заасан бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглохоор заажээ. Мөн уг 2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол Мөн Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй хэмээн баталгаажуулсан боловч хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заажээ. Эдгээр ялгаварлан гадуурхалтад мөн адил ХБХ-ийн дунд тохиолддог ялгаварлан гадуурхалтыг харгалзан үзэж тусгаагүй буюу хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан гадуурхсан тохиолдлыг тусгаагүй байна. Харин Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлгээр хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийг зохицуулан, 10.1 дүгээр зүйлд хүнийг 2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол тусгай зүйл ангиар шийтгэх боловч эдгээр үзэн ядах төрөлд хөгжлийн бэрхшээлээс шалтгаалсан тохиолдлыг мөн тусгайлан авч үзсэн заалт байхгүй байна. Харин ХБХЭТХ-д амьд явах эрхтэй холбоотой ямар нэгэн тухайлсан заалт байхгүй байна.

**ХБХЭТК-ийн Хуулийн өмнө тэгш байх эрхийг хангахуйц хууль, эрх зүйн орчин бүрджээ.** ХБХЭТК-ийн 12 дугаар зүйлд заасан Хуулийн өмнө тэгш байх эрхийн хүрээнд ХБХ-ийн эрх зүйн чадамжийг хүлээн зөвшөөрч, түүнтэй холбоотой дэмжлэг туслалцааг хүртээмжтэй байлгах, хувийн нөхцөл байдалд нь тохирсон хамгаалалтыг бий болгох тухай заалтууд хамрагддаг. Мөн хөрөнгө эзэмших, өвлөх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээ авах талаар оролцогч улсуудад зөвлөсөн байдаг. Энэхүү заалттай нийцэх хууль, эрх зүйн зохицуулалт нь нэн түрүүнд Монгол Улсын Үндсэн хууль бөгөөд уг хуулийн хүний эрх, эрх чөлөөг тусгасан 2 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлд Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна хэмээн тусгажээ. Харин санхүүгийн эрхийн хүрээнд, ХБХЭТХ-ийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлд заасан ХБХ-ийг үл ялгаварлан гадуурхах тухай зүйлийн 6.3.4.-т хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгааны улмаас зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг ялгаварлан гадуурхалт болохын тусгайлан заажээ. Мөн ХБХЭТХ-ийн 31 дүгээр зүйлд, хувийн нууцыг хүндэтгэх тухай заалтад ХБХ-ий эд хөрөнгийг холбогдох хуулиар хамгаалах, түүнтэй холбоотой нууцыг задруулахыг хориглосон заалтуудыг тусгажээ. Эдгээрээс гадна, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр бүлэг болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт, зарчимд 1.12 дугаар зүйлээр Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тухай заасан бөгөөд үүний агуулгад Монгол Улсад хүн бүр, түүн дотроо хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан гадуурхагдахгүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна хэмээн тусгаж өгчээ.

**ХБХЭТК-ын Шүүхийн ажиллагаанд хүртээмжтэй оролцох нөхцөлийг сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст чиглэн сайтар тусгаж өгсөн нь сайшаалтай ч, орчны хүртээмжийг сайжруулах, ажилтнуудын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлд**

**заалт, арга хэмжээ дутмаг байна.** ХБХЭТК-ын ‘Шүүхийн ажиллагаанд хүртээмжтэй оролцох’ нөхцөлийг хангах хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр бүхий л үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох үйл ажиллагаанд онцлог хэрэгцээнд нийцсэн хэрэглэгдэхүүн ашиглах замаар хүртээмжтэй, үр дүнтэй оролцуулах тухай заасан байдаг. Нөгөө талаас шүүх болон хорих үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг зохих сургалтад хамруулах тухай заажээ. Үүнийг ХБХЭТХ-ийн 6 дугаар зүйлд заасан ХБХ-ийг үл ялгаварлан гадуурхах тухай зүйлийн 6.1-д тусган Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх эрхтэй хэмээн заасан байдаг. Үүнээс гадна, ХБХЭТХ-ийн 27 дугаар зүйлд ‘Хууль зүйн туслалцаа авах эрх’-ийг тусгайлан 4 дэд зүйлээр зааж өгсөн бөгөөд 27.1 Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх тухай заалт нь гол ерөнхий заалт болж байна. Үүнээс гадна, үлдсэн гурван дэд заалтын хүрээнд ХБХ-д хууль зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээг үнэ төлбөргүйгээр, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, тайлбарлаж өгөх, эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх, түүний зардлыг улсын төсөвт тусгах тухай заажээ. Хэдийгээр конвенцод үзэх болон хорих үйл ажиллагаанд оролцогч талуудыг сургалтад хамруулж, орчныг бүрдүүлэхэд дэмжих талаар заасан боловч ХБХЭТХ-ийн 27 дугаар зүйлд энэ талаар заалт дутмаг байна. Харин зөвхөн ХБХЭТХ-ийн 7 дугаар зүйлд заасан хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх заалтуудад төрийн албан хаагч нарыг ХБХ-ий эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах талаар тусгажээ. Энэ нь шүүх болон хорих гэх мэт холбогдох гол талууд, тэдгээрийн үйл ажиллагаа, орчин, нөхцөлд ХБХ-ий онцлог нийцүүлэн, хүртээмжтэй, тэгш байх тухай асуудлыг ХБХЭТХ-даа орхигдуулсан байгааг харуулж байна. Салбарын нарийвчилсан хуулиудыг судалж үзвэл, 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хууль нь гол хууль бөгөөд үүний 7 дугаар зүйлд хууль, шүүхийн өмнөх эрх тэгш байх тухай зүйлийн 7.1-д Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал зэргээс үл хамаарч хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна хэмээн заажээ. Уг заалтад хөгжлийн бэрхшээлийн онцлог байдлыг энэхүү зарчимд тусгайлан авч үзээгүй байна. Харин уг бүлгийн 11 дүгээр зүйлд заасан шүүн таслах үйл ажиллагаа явуулах хэл дээр хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал хүн өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдах тухай зааж, уг эрхийг баталгаажуулж өгчээ. Түүнчлэн, уг хуулийн 69 дүгээр зүйлд шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчим хэсэгт 69.1.4-р заалтаар Шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх тухай зарчмыг баримтлах тухай заажээ. Харин уг хуулиар үйлчилгээ хүргэгч гол субъектүүдээс шүүгчийг онцлон ХБХ-ийг ялгаварлахгүй байх заалтыг оруулж өгчээ. Тодруулбал, уг хуулийн 11 дүгээр бүлэг. Шүүгчид хориглох зүйл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүлгийн 50 дугаар зүйлд заасан шүүгчид хориглох зүйлсийн 50.1.31.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэх тухай хориглосон заалт тусгажээ. Эдгээрээс гадна, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйл болох Өмгөөлөгчийг оролцуулах

тухай дэд зүйлийн 1.1-т хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн, эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй аливаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй хэмээн заасан нь хуулийн туслалцаа авах эрхийг нь баталгаажуулсан заалт болж байна. Цаашилбал, уг хуулийн 7.5 дугаар зүйл болон Мэдээлэл авах тухай хэсэгт яллагдагч хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл авах эрхтэй хэмээн зааж өгчээ. Мөн 9.4 дүгээр зүйлд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг мэдэх хэлмэрчид хүлээх үүрэг, түүний эрх, хариуцлагын тухай заалтуудыг нарийвчилж зааж өгчээ. Мөн Мэдүүлэг авахтай холбоотой 25.1 дүгээр зүйлд хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүнээс мэдүүлэг авах, хэлмэрчийг оролцуулах боломжгүй бол түүний зөвшөөрснөөр бичгээр асуулт тавьж, мэдүүлэг авч болох тухай мөн Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны Орчуулагч, хэлмэрчид түүний үүргийг тайлбарлах ажиллагааг 35.2 дугаар зүйлээр тус тус нарийвчлан заажээ. Эдгээр заалтууд нь дан ганц шүүхийн өмнө тэгш эрхтэй байх тухай биш, шүүхийн бүхий л үйл ажиллагаанд хууль зүйн туслалцаа авах, эрх, үүргээ эдлэх нөхцөлийг нь сайтар тусгаж өгснийг харуулж байна. Эдгээрээс гадна, тэднийг төлөөлж, мэдээлэл дамжуулж буй хэлмэрчийн эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан зааж өгсөн нь онцлог байна. Гэхдээ, шүүхийн үйл ажиллагаа явуулах явцад бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх, үг хэлэх, оролцоход шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах, саадгүй зорчих, оролцох нөхцөлүүдийг нэмж тусгаж сайжруулах хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

**ХБХЭТК-ийн 14 дүгээр зүйл Эрх чөлөө, хувийн халдашгүй эрхийн тухай заалтууд нь Үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулагдаж байна**. Конвенцын уг заалт нь оролцогч улсууд нь ХБХ-ийг эх чөлөөтэй байх, хувийн халдашгүй эрхээ эдлэх нөхцөлөөр хангах тухай, мөн хэрвээ ХБХ-ийн эрх чөлөөг аливаа журмын дагуу хассан бол бусадтай адил тэгш нөхцөлийн үндсэн дээр боломжит хэрэглэгдэхүүнээр хангаж, тэгш хандах явдлыг хангах тухай тус тус заасан байдаг. Монгол Улсын Үндсэн Хуулийн 2-р бүлэг болох Хүний эрх, эрх чөлөөг тусгасан 14-р зүйлд хүн бүр хууль, шүүхийн өмнө адил тэгш байхыг баталгаажуулсан боловч ялгаварлан гадуурхалттай холбоотой 14.2-р зүйлд хөгжлийн бэрхшээлээс шалтгаалсан ялгаварлан гадуурхалтыг тусгаагүй байна. Үүнтэй адилаар, Эрүүгийн хуулийн 14-р бүлэг болох ‘Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг’-ийн 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхахтай холбоотой зүйлд хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах асуудлыг орхигдуулсан нь харагдаж байна. Гэхдээ, Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн нийт 18 эрхийг баталгаатай эдлэхээр зааж өгсөн бөгөөд түүний 13-т халдашгүй, чөлөөтэй байх эрх дурдагдсан бөгөөд үүнд дээрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаалах тухай зааж өгчээ. Гэхдээ, эрх чөлөөг хасах асуудлыг Эрүүгийн тухай хуулийн 1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчимд зааснаар Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй тухай зааж өгчээ. Эдгээрээс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд Хүний халдашгүй байх эрхийг хангах талаар нарийвчилж өгсөн бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах,

эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглохоор заажээ.

**Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх, зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулах асуудал нь нийтлэг хуулиар зохицуулагдаж байна**. ХБХЭТК-ийн 15 дугаар зүйлд заасан Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн хүрээнд өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөлгүйгээр эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулахыг хориглох тухай заасан байдаг. Мөн бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглох чиглэлд оролцогч улсуудыг хууль тогтоох, захиргааны, шүүхийн буюу бусад арга хэмжээг авахаар заажээ.  Энэхүү конвенцын заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөний 'Халдашгүй байх эрхийн хүрээнд тодорхойлсон  'Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй' гэсэн заалтаар баталгаажуулж болох юм. Эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилттай холбоотой асуудлын хүрээнд Эрүүл мэндийн тухай хууль нь гол хууль болох бөгөөд үүний 37 дугаар зүйлд Оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх шинэ аргыг турших, бүртгэх, нэвтрүүлэх асуудлыг тусгахдаа тусгай журмаар буюу 'Оношилгоо, эмчилгээний зориулалтаар шинээр гарч байгаа болон био технологи, нано технологи, инновацын технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд судалгаа, шинжилгээ явуулах, турших, баталгаажуулах, бүртгэх, мэдээлэх, тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам' -аар зохицуулахаар заасан байдаг. Уг журам нь Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2019 оны 05 сарын 31-ны өдрийн А/253/А/348 дугаар тушаалаар батлагдсан байдаг. Гэвч уг журмын Хоёр. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд судалгаа, шинжилгээ явуулахад тавигдах шаардлагад зааснаар 2.1.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо, салбар хорооноос судалгааг эхлүүлэх зөвшөөрөл авсан байх үндсэн шаардлага байдаг. Харин Эрүүл мэндийн сайдын  2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/217 дугаар тушаалаар батлагдсан Анагаах Ухааны Ёс Зүйн Хяналтын Хороо, Салбар хорооны үлгэрчилсэн дүрмийн 2 дугаар бүлэгт заасан уг хороодын баримтлах зарчимд Судалгаа, эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг хамрагдаж буй хүний хүсэл сонирхол, албан ёсны зөвшөөрлийн үндсэн дээр явуулах тухай заасан байдаг. Энэ нь уг конвенцын эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад өөрийнх нь өгсөн зөвшөөрлийн дагуу оруулах эрхийг нь хангах гол заалт болж байна. Эрүү шүүлтээс ангид байх тухай уг эрхийн нийцлийг хангаж буй гол хууль нь Эрүүгийн хэргийг хянах шийдвэрлэх тухай хууль бөгөөд уг хуулийн 1.9 дүгээр зүйлд Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх тухай тусдаа зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглож, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглохоор заажээ. Мөн уг хуулийн 1.12 дугаар зүйлд Монгол Улсад хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тухай заахдаа хөгжлийн бэрхшээлээс нь үл хамааран хууль, шүүхийн өмнө тэгш байх тухай онцлон зааж өгчээ.

# Тав. Тухайлсан бүлгүүд ба тэдгээрийн эрхийг хангаж буй байдал

Энэхүү хэсэгт ХБХ дотроо тодорхой бүлгүүд буюу хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүүхдүүд, болон бусад төрлийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдалд эмзэг бүлгийг тодруулан тэдний эрхийг хангах чиглэлд конвенцтой уялдуулсан хууль, эрх зүйн зохицуулалтуудыг авч үзнэ.

**ХБХЭТК-ын 6 дугаар зүйл болох Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлыг нөхөн үржихүй, хүчирхийллийн асуудлын хүрээнд хууль, эрх зүйн зохицуулалтуудад сайтар тусгажээ.** ХБХЭТК-ын 6 дугаар зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь давхар алагчлал, хүчирхийлэлд өртөмтгийн байдлыг нь харгалзан, тэдгээрийн эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх, хөгжүүлэх, аж байдлыг дээшлүүлэх болон эмэгтэйчүүдийн эрх, боломжийг нь нэмэх арга хэмжээг авахыг оролцогч улсууд үүрэг болгон авчээ. Эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах тухай 1924 оны анхдугаар Үндсэн хуулиас эхлэн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Үндсэн хууль” болон бусад хуулиудад хүйсээс шалтгаалан ялгаварлан гадуурхахгүй байх тухай сайтар тусгаж өгсөн. Үүнээс гадна, ХБХЭТХ-ийн 29 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг тусгайлан тусгаж өгсөн бөгөөд үүнд бүхий л салбарт эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, ялангуяа хүчирхийллийн хохирогч болох магадлалыг нь харгалзан гэр бүлийн хүчирхийлэл болон нөхөн үржихүйн эрхүүдийн хүрээнд хамгаалах, туслалцаа үзүүлэх, эрсдэлийг бууруулах ажлуудыг тусгайлсан зааж өгчээ. Үүнээс гадна, Монгол Улсад 2011 оноос хойш Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль нь эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэх, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулахад чиглэсэн гол зохицуулалт болж байна. Мөн уг хуульд ‘жендерийн ялгаварлан гадуурхалт" гэсэн ойлголтыг тусгаж, түүгээрээ улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйн талаар тусгаж өгчээ. Хэдийгээр уг хуулийн 5 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчимд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тусгасан ч түүнийгээ эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх гэдгээр тодорхойлсон. Эдгээр зүйлсэд хөгжлийн бэрхшээлийн тухай дурдагдаагүй байна. Эдгээрээс гадна, ХБ-тэй эмэгтэйчүүдэд тулгарч болзошгүй гэр бүлийн хүчирхийллийн тухайд, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл 33.4.Хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэх тухай, мөн 33.7-д хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид энэ хуулийн 33.1-д заасан үйлчилгээ үзүүлэхэд орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангах тухай зааж өгчээ. Мөн Эрүүгийн тухай хуулийн 11.7 дугаар зүйлд заасанчлан Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхдээ жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн бол тусгай зүйлээр шийтгэхээр зааж өгчээ. Үүнээс гадна, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйл.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих тухай зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авсан тохиолдолд ажил олгогчдод урамшуулах тухай зааж өгчээ. Хэдийгээр хүйсийг онцлон дурдаагүй ч, энэ нь хүйсээс үл хамааран нийгэм болон эдийн засгийн хувьд ХБ-тэй эмэгтэйчүүд боломжийг адил тэгш хүртэх, хувь нэмэр оруулах үүдийг нь нээж өгч байгаа юм. Үүнээс гадна, аливаа байгалийн гамшиг, гэнэтийн аюултай үед ХБХ-ний эрхийг хангах талаар ХБХЭТХ-ийн 36 дугаар зүйл. Онцгой байдлын үед авах арга хэмжээ хэмээх тусгай заалтаар зохицуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах үүргийг төрийн холбогдох байгууллага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэхээр заасан. Гэвч тухайлсан хүйс заасан заалт байхгүй байна.

**ХБХЭТК-ын 7 дугаар зүйлд заасан ХБХ-ийн эрхийг хангахтай холбоотой нийцүүлэн гаргасан хууль, эрх зүйн актууд нь хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх, хамгаалах, чиглэлд илүү анхаарчээ**. ХБХЭТК-ын 7 дугаар зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлыг тусгайлан авч үздэг бөгөөд үүний хүрээнд бүх эрх, эрх чөлөө бүрэн дүүрэн эдлүүлэх, ашиг сонирхлыг нь нэн түрүүнд харгалзах үзэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхүүдийг хангаж, насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэхээр заажээ. Үүнтэй нийцүүлэн, ХБХЭТХ-ийн 28 дугаар зүйлд мөн адил Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн талаар тусгасан байдаг бөгөөд конвенцод заасан тэдэнтэй холбоотой аливаа бодлого, шийдвэр гаргахдаа үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангах тухай тусгаж өгчээ. Эдгээрээс гадна уг хуулийн бусад зүйл, заалтуудад тусгасан сурч боловсрох, эрүүл мэндийн болон нийгмийн бусад үйлчилгээ авах эрхүүдийг хангаж, үйлчилгээг хүртээмжтэй, үнэ төлбөргүй байлгах, хүчирхийллээс ангид байлгах, асран хамгаалагчид, эцэг эхчүүдийг нь дэмжих, үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг нь хориглох гэх мэт олон асуудлуудыг нарийвчлан тусгаж өгчээ. Эдгээрээс гадна, зохицуулах гол эрх зүйн зохицуулалт нь Хүүхдийн эрхийн тухай хууль бөгөөд уг хуулийн 4 зүгээр зүйлд Хүүхдийн эрхийн үндсэн зарчмыг заахдаа, 4.1.2-т Ялгаварлан гадуурхахгүй байх, 4.1.3.хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах; 4.1.5-д хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээллээр хангах тухай тусгажээ. Эдгээр зарчмуудыг зөвхөн нас, төлөвшил, бие, сэтгэхүйн онцлог гэсэн ойлголтуудын хүрээнд тайлбарласан нь нэг талаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог, ялгаатай байдлыг тусгалгүй орхисон харагдаж болох бөгөөд ХБХ-ий адилаар хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлийг нь харгалзан үзэл бодолд нь хүндэтгэлтэй хандах, хөгжлийн онцлогт нь тохирсон мэдээллээр хангах зэргээр онцлох нь ХБХ-ийг бүхий л хүрээнд хүлээн зөвшөөрөх, энэ талаар мэдлэг, ойлголтыг хүүхдийн эрхийн бүхий л зохицуулалтад жигд харгалзан үзэхэд тустай юм. Эдгээрээс гадна, хөгжийн бэрхшээлтэй хүүхдийн хүчирхийлэлд өртөхөөс сэргийлсэн, хамгаалсан хэд хэдэн зохицуулалтууд Монгол Улсын хуулиудад тусгагджээ. Эрүүгийн тухай хуулийн 11.7-д хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг тусгай зүйл заалтаар шийтгэхээр заасан. Уг хуулийн 16 дугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийг тусгайлан зохицуулсан байдаг бөгөөд 16.1-т 18 насанд хүрсэн хүн хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хөгжлийн бэрхшээлтэй байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол; мөн 16.4 дүгээр зүйлд заасан Хүүхдээр гуйлга гуйлгах гэмт хэргийн хүрээнд дотроо хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй байдлыг далимдуулж гуйлга гуйлгасан тохиолдолд тусгай зүйл заалтаар шийтгэхээр тус тус тусгайлан заалтууд оруулжээ. Үүний дагуу, хэрвээ

хүүхэд хүчирхийлэлд өрсөн бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлд 33.4-т Хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн, хэрэгцээ, шаардлагыг харгалзан хохирогчид үйлчилгээ үзүүлэхээр заажээ. Эдгээр зүйл заалтууд нь нэг талаасаа хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх, хамгаалах, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хариу арга хэмжээ авах зохицуулалтыг сайтар тусгасан байгааг харуулж байна.

**Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах тухай ХБХЭТК-ын 16 дугаар зүйлийн хүрээнд нийцсэн хууль, эрх зүйн актууд нь ХБ-тэй эмэгтэйчүүд болон хүүхдүүд болон хохирогчдод илүү чиглэжээ.** ХБХЭТК-ын 16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах хүрээнд ХБХ-ийн хамгааллын арга хэмжээнд нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирсон тусламж, үйлчилгээ үзүүлэх, мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой мэдээлэл түгээх тухай заажээ. Мөн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын хохирогч болсон тохиолдолд түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд дахин оролцуулах, хамгаалах үйлчилгээ үзүүлэхэд арга хэмжээ авахыг оролцогч улсуудад зөвлөжээ. Эдгээр дурдагдсан асуудлын хүрээнд нийцүүлэн гаргасан зохицуулалтуудыг дурдвал, ХБХЭТХ-ийн 9 дүгээр бүлгийн 28 дугаар зүйлд заасан ХБХ-ийн эрх хэсэгт 28.4.-р заалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын болон төрийн эрх бүхий холбогдох байгууллага хэрэгжүүлнэ хэмээн заажээ. Мөн Хүүхдийн эрхийн тухай хуулийн Хүүхдийн хамгаалуулах эрхийн 7.1.-т Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй хэмээн тусгаж, эрхийг баталгаажуулж өгсөн. Харин ХБ-тэй насанд хүрсэн иргэдийн хувьд мөлжлөгийн асуудлыг дурдаагүй ч, уг хуулийн 6.5-д заасан ялгаварлан гадуурхалтын ойлголтод хөгжлийн бэрхшээлээр нь доромжлохыг тодотгож оруулжээ. Харин Эрүүгийн тухай хуулийн 12.3 дугаар зүйл дээр Бэлгийн мөлжлөг гэсэн тусдаа заалт оруулж түүнийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг хэмээн тодорхойлсон. Хэдийгээр ХБХ-ий эсрэг тухайлсан бэлгийн мөлжлөгийн асуудлыг тусгаагүй ч, уг хууль нь Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй хэмээн зааж өгсөн байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүн эдгээр мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын хохирогч болсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэн заавал өмгөөлөгчтэй оролцох талаар Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нь хамгаалалт болж байна. Нөгөө талаас, ХБХЭТХ-д 28 дугаар зүйлд заасан ХБХ-ийн эрх, 29 дүгээр зүйлд заасан ХБ-тэй эмэгтэйчүүдийн эрхийн хүрээнд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэшлийн түвшинд чанартай үзүүлэхээр заажээ. Харин сэргээн засах, нийгмийн амьдралд дахин оролцуулах, хамгаалах үйлчилгээнүүдийг ХБХЭТХ-ийн 6 дугаар бүлэгт заасан ХБХ-д үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, 7 дугаар бүлэгт заасан ХБХ-ийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хүрээнд тусгажээ. Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ, хохирогчид үзүүлэх үйлчилгээтэй холбоотой

заалтуудаас 33 дугаар зүйлд хохирогчид үзүүлэх 7 төрлийн үйлчилгээг зааж өгсөн бөгөөд үүнд аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ; сэтгэл зүйн үйлчилгээ; нийгмийн халамжийн үйлчилгээ; хүүхэд хамгааллын үйлчилгээ; эрх зүйн туслалцаа; болон холбон зуучлах үйлчилгээ багтгаж байна. Эдгээр үйлчилгээ нь хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах зорилготой бөгөөд үйлчилгээ тус бүр тусгай журмуудаар зохицуулагдаж байгаа бөгөөд хуулийнхаа дагуу хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, үл бируутгах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөхөөр зааажээ.

**Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал хэсэгт эрсдэл бүхий байдалд ХБХ-ийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлд хууль, эрх зүйн зохицуулалтуудыг сайтар нийцүүлэн, тусгажээ.** ХБХЭТК-ийн 11 дүгээр зүйлд туссан Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал хэсэгт эрсдэл бүхий байдал, тухайлбал зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн гамшиг, байгалийн аюул гамшиг тохиолдсон үед ХБХ-ийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авахаар зааажээ. Энэхүү 11 дүгээр зүйлд нийцүүлэн ХБХЭТХ-ийн 36 дугаар зүйлд Онцгой байдлын үед авах арга хэмжээг зааж өгсөн бөгөөд 36.1.-д тодорхойлсноор ‘Хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал зэрэг онцгой байдал бий болох үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах үүргийг төрийн холбогдох байгууллага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ’ хэмээжээ. Үүнээс гадна, Монгол Улсад хэрэгжиж буй гол хууль нь Онц байдлын тухай хууль бөгөөд уг хуулийн 5 дугаар бүлэг болох Онц байдлын үед иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах хүрээ хэсэгт зааснаар, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино хэмээжээ. Хуулийн энэхүү ялгаварлан гадуурхахгүй байх тухай заалтад хөгжлийн бэрхшээлийн асуудал тусгагдаагүй байна. Гэвч, уг хуультай уялдуулан баталсан ‘Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)’-ийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.2-т Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах зорилт дэвшүүлсэн бөгөөд 3.2.3-т гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг олон нийтэд олгох, эрсдэлгүй зан үйлийг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийцүүлэн тохирсон байдлаар бэлтгэх, 3.2.4-т олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ном, гарын авлага, заавар, сэрэмжлүүлэг, дүрс бичлэгийн богино хэмжээний кино хийх, үзүүлэн таниулах болон тараах материал бэлтгэж түгээх зэрэг ажлууд багтжээ. Харин Гамшгаас хамгаалах тухай хуультай нийцүүлэн гаргасан Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журмын 4.1.2-т зааснаар нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэхдээ эхний ээлжид аюулгүй бүс рүү хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, эд материалын болон түүх, соёл, урлагийн үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч ажиллахаар зааажээ. Эдгээр хууль, журмууд нь ХБХЭТК-ийн 11 дүгээр зүйлд туссан Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах тухай

заасан асуудлыг хууль, эрх зүйн зохицуулалтад бүрэн тусгаж, мэдээлэл түгээх, тусламж, үйлчилгээ хүргэх, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх үед ХБХ нь эхний ээлжид тусламж авахаар заалтууд байгааг харуулж байна.

## Зургаа. Конвенцын хэрэгжилт, хяналт, хамтын ажиллагаа

**Статистик, тоон мэдээллийг цуглуулах агуулгыг Конвенцын 31 дүгээр зүйтэй уялдуулан өргөжүүлэх шаардлагатай байна.** ХБХЭТК -н 31-р зүйлд: ‘Оролцогч улсууд энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор бодлого, стратеги боловсруулах, статистик болон судалгааны мэдээллийг оролцуулан шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулах, тэдгээр мэдээллийг тухайн бодлогод ашиглах үүрэг хүлээнэ’ хэмээн заасан төдийгүй , мэдээллийг цуглуулахдаа a)хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй байдал, хувийн нууцыг чанд сахих; b) статистик мэдээллийг цуглуулах, ашиглахдаа хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаарх олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ болон ёс зүйн хэм хэмжээг чанд сахих; тухай тусгасан. YCX-ноос хөгжлийн бэрхшээлийн статистикийг олон улсад харьцуулагдахуйц байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Вашингтон бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тодорхойлох богино багц асуулгаар Ажиллах хүчний судалгаа /2020-2022 он/, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг /2020, 2022/ хийж холбогдох мэдээллийг цуглуулсан. Мөн БШУ-ны сайдын 2022 оны А/ 313 дугаар Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” тушаалаар Сургуулийн өмнөх боловсролын бүртгэлийн маягтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг мэдээг авахдаа даун, аутизмтай хүүхдийн мэдээллийг тусад нь авахаар нэмэлт өөрчлөлт оруулсан бол мөн 2020 оноос бүх шатны боловсролын байгууллагад суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын мэдээллийг захиргааны болон албан ёсны статистикийн маягтад тусгадаг болсон. ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл II”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх зорилгоор www.cwd.mlsp.gov.mn домэйн нэр авч, “ХУР” болон ehalamj.mn системүүдэд холбож, мэргэжилтнүүдийг чадавхжуулжээ. Манай улс БСШУЯ, ЭМЯ, ГБХНЯ болон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон насанд хүрэгчид, хүүхдийн талаарх мэдээллийг бүртгэж байна. БСШУСЯ, YCX хамтран дээд боловсролын байгууллагын багц маягт, нөхөх зааврыг 2019 онд шинэчлэн боловсруулж, хөгжлийн бэрхшээлийн асуултуудыг YCX, Хүн ам, орон сууцны нэгдсэн тооллого-2010-т шинээр нэмж оруулаад байна. Эмнэлэгт хандсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо, нийгмийн хамгааллын үйлчилгээ түүний доторх тэтгэвэр тэтгэмжид хамрагдаж байгаа болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй оюутан сурагчдын тоон мэдээллүүдээс ХБХ-н тоон мэдээллийн гол цөм хэсэг бүрдэж байгаа. Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал буюу "ICF" (International Classification of Functioning, Disability and Health) ангиллыг нэвтрүүлэх ажил удааширч байгаатай холбоотой хөгжлийн бэрхшээлийн талаарх статистик тоон мэдээллийн асуудал мөн удаашралтай хэрэгжиж байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үндэсний болон тодорхой бүлгүүдэд чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэгч гол байгууллагууд нь олон улсын байгууллагууд**

**байна.** Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл” /2018-2025/, 2. ЖАЙКА олон улсын байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бэхжүүлэх төсөл” /2021-2025/, 3. Монгол дахь Норвегийн тусламжийн байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил төсөл” /2020-2024/ зэргүүд нь ХБХЭТК-н зүйл заалтуудын хэрэгжилтийг хангахад чиглэгдэж тодорхой үр дүнгүүд гарч байна. Гэсэн хэдий ч төслийг удирдан хэрэгжүүлж байгаа зарим баг, мэргэшлийн хувьд маш сайн байдаг ч хүний эрх, хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын талаар мэдлэг ойлголтгүйн улмаас эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлж чадахгүй байгаад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэдгээрийн ТББ-ууд шүүмжлэлтэй хандаж байна. Цаашлаад төсөл хөтөлбөрүүдийн төсвөөр олон тооны бодлогын судалгаануудыг зөвлөх үйлчилгээний хүрээнд дотоодын байгууллага, мэргэжилтнүүдээр хийлгэдэг ч судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг хэрэглэх, бодлогод тусгах байдал хангалтгүй байна. Тухайлбал: Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Монгол Улсад нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний жагсаалт бичиг баримт бодлогын бичиг баримтыг боловсруулан гаргасан.

Энэ мэт ахиц дэвшил гарч байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхээ эдлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлсон, тэдний боловсрол, хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин, орон байр, бэлгийн чиг хандлага, гэр бүлийн нөхцөл байдлыг харуулсан статистик тоон мэдээлэл байхгүй нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлсон судалгаа тоон мэдээлэл дутмаг байсаар байна. Дэлхийн ихэнх улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн статистикийн уламжлалт чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг үзэл санаа өргөжин тэлж, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг өргөн агуулгаар хөгжиж байна.

**Харин конвенцын хэрэгжилтэд хяналт тавих, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөөллийн байгууллагуудыг бие дааж үр дүнтэй оролцуулах, төсөв бүхий хараат бус, хяналтын механизм манай улсад хараахан бий болоогүй байна**. Конвенцыг хэрэгжүүлж буй талууд, тэдгээрийн ахицад хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, бүтцийг тогтвортойгоор ажиллуулах. иргэний нийгмийн байгууллагуудын хяналт, оролцоог дэмжих, хамруулах үүрэг хүлээдэг. ХБХЭТХ-н 40-р зүйлд ”Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байх тухай заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг 2028 онд ХНХЯ-ны харьяанд байгуулсан нь конвенцын 33-р заалт хэрэгжихэд нэг алхам болсон. Гэсэн хэдий ч тус агентлагийн хуулиар олгогдсон эрх хэмжээ нь хязгаарлагдмал, ХНХЯ-ны харьяанд ажиллаж байгаа зэрэг шалтгаанаас агентлаг нь салбар дундын уялдааг зохицуулан конвенцын хэрэгжилтийг ханган ажиллахад бэрхшээл саадтай тулгарсаар байна.

# 5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦ БА МОНГОЛ УЛСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД БА НИЙЦЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Дээрх бүлэгт нарийвчлан шинжилсэн конвенцын зүйл заалт тус бүрийг Монгол Улс дах хууль, эрх зүйн зохицуулалтуудтай харьцуулсан үр дүнд ажиглагдсан зөрүүтэй байдлыг энэхүү хэсэгт өгөгдсөн 4 бүлэг асуудлын хүрээнд дүгнэн танилцуулна.

**ХБХЭТК-ий нийтлэг зарчмууд болон үүргүүд**

ХБХЭТК-ын 1-ээс 4-р зүйлд, конвенцын зорилго, тодорхойлолтууд, нийтлэг зарчим болон нийтлэг үүргүүдийн талаар тус тус тусгасан байдаг. Үүний хүрээнд, дараах нийтлэг зөрүү ажиглагдаж байна.

- **1 дүгээр зүйл. Зорилго.** Конвенцын зорилгын хүрээнд тодорхойлсон ‘Хөгжлийн бэрхшээлтэй хүн’ гэсэн тодорхойлолт нь ХБХЭТХ-д бүрэн агуулгаар тусгагдсан. ХБХЭТК-ын зорилгод нийцүүлэн ‘Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай’ хуулийг баталсан бөгөөд уг конвенцын дагуу ХБХЭ-ийг хамгаалах, хангах тухай уг хуулийн зорилгод тусгасан хэдий ч, гол агуулга болох эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хөхиүлэн дэмжих, нэр төр, нандин чанарыг хүндэтгэх тухай утга санаа дутмаг тусгагджээ
- **2 дугаар зүйл. Тодорхойлолт.** Энэхүү конвенцын хүрээнд ойлгох гол тодорхойлолтууд нь ХБХЭТХ-д заасан зарим тодорхойлолтуудтай орчуулга болон агуулгын хувьд ялгаатай буюу нийцгүй байна. Тухайлбал, ‘Боломжит хэрэглэгдэхүүн’ гэсэн ойлголтыг ХБХЭТХ-д ‘Тохирох хэрэглэгдэхүүн’ хэмээн орчуулсан бол ‘Түгээмэл загвар’ гэсэн тодорхойлолтыг нийцтэй байдлаар томьёолсон ч, агуулгын орчуулга жигд бус байна. Энэ нь конвенцод заагдсан үндсэн тодорхойлолт болох ‘хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах’ гэсэн нийтлэг тулгамддаг асуудлыг зохицуулах тодорхойлолтыг Үндсэн хууль болон ХБХЭТХ-иудад орхигдуулсан буюу тусгаагүй байна. Тухайлбал, Үндсэн хуулийн 14.2-т заасан ялгаварлан гадуурхалтын тодорхойлолтод хөгжлийн бэрхшээлийг бус эрүүл мэндийн байдал нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж, эрх эрх чөлөөг нь хязгаарласан тохиолдлыг тодорхойлжээ. Тиймээс, конвенц болон түүнтэй нийцүүлэн гаргасан ХБХЭТХ-д тодорхойлсноор, хөгжлийн бэрхшээл нь зөвхөн эрүүл мэндийн нөхцөл байдал биш тул түүнтэй нийцүүлэн үндсэн хууль болон болон ялгаварлан гадуурхалтыг тодорхойлохдоо хөгжлийн бэрхшээлийн асуудлыг тусгаагүй дараах хуулиудад тусгаж оруулах шаардлага харагдаж байна.
- **3 дугаар зүйл. Нийтлэг зарчмууд.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад баримтлах нийтлэг зарчмуудаас бие даасан байдал, нэр төр, нандин чанарыг нь хүндэтгэх, хүйсээс үл хамааран тэгш эрхтэй байх тухай зарчмууд нь ХБЭХТХ-ийн агуулгад дутмаг тусгагджээ. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн ажлуудад нас, хүйсээс хамаарсан ялгаатай, хэрэгцээ, асуудлыг нь хөндөх, таниулах, шийдвэрлэх боломжуудыг хязгаарлах эрсдэлтэй.

- **4 дүгээр зүйл. Нийтлэг үүргүүд.** Оролцогч улсуудын хүрээлэн үүргийн хүрээнд нийт 9 үүргийг зааж өгсөн бөгөөд ХБХЭТХ болон бусад холбогдох хуулиудад туссан байдлыг шинжилсэн. Эдгээр 9 үүргээс, хууль тогтоох, захиргааны болон холбогдох бусад арга хэмжээг авах, бодлого, хөтөлбөрт ХБХЭ-ийг хамгаалах, дэмжих явдлыг тусгах, үйлдэхүй, эс үйлдэхийг тусгах, тохируулах хэрэгслийг хүртээмжтэй болгох заалтууд, зохицуулалтуудыг харьцангуй сайн тусгажээ. Гэвч, ХБХ-ийг алагчлах явдлыг үүсгэж байгаа зан заншил, уламжлалыг арилгах, үүнд хувийн хэвшлийн оролцоог хангуулах, түгээмэл загвар бүхий бараа, үйлчилгээ, төхөөрөмж, хэрэгслийг зохион бүтээх боловсруулах, судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих явдлыг дэмжих зэргийг тусгасан, тодорхойлсон заалтууд, зохицуулалтууд маш дутмаг байна.
- **5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл алагчлал**. Конвенцын тодорхойлолт ‘Хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах’ гэсэн тодорхойлолт байгаа бол ХБХЭТХ-ийн 4.1.2."хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах" гэсэн зөрүүтэй нэршлээс явж байна. Агуулгын хувьд  гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэхийг үгүйсгэх, хязгаарлах, үйлдэх эс үйлдэхийг заасан нь нийцтэй байна. Харин ХБХЭТК-д ялгаварлан гадуурхах гэсэн тодорхойлолтдоо заасан хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан эдгээр эрхээ эдлэх боломжийг сулруулах буюу ийм эрхийг хүлээн зөвшөөрөхийг үгүйсгэх зорилго агуулсан, эсхүл тийм үр дүнд хүргэсэн бүх төрлийн алагчлал, гадуурхалт, хязгаарлалтыг хамруулах тухай агуулгыг орхигдуулжээ. Эдгээр нь ялгаварлан гадуурхалтын талаарх ойлголтыг хязгаарлах, тулгарч болзошгүй асуудлуудыг ялгаварлан гадуурхалт биш хэмээн ойлгох эрсдэлтэй. Харин, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломж гэсэн агуулгаар нэмж баяжуулсан байна.
- **6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд.** Уг заалтын хүрээнд тусгагдсан хүйсээс хамаарсан хүчирхийлэл, гадуурхалттай холбоотой эрсдэлүүдэд өртөмтгийн байдлыг бууруулах, урьдчилсан сэргийлэх, илрүүлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэгчийг шийтгэх асуудлуудыг ХБХЭТХ, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Эрүүгийн тухай хууль зэргээр сайтар зохицуулжээ. Гэвч Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчимд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тусгасан ч түүнийгээ эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх гэдгээр тодорхойлсон. Гэвч, эдгээр зүйлсэд хөгжлийн бэрхшээлийн тухай дурдагдаагүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхүүдийн онцлог асуудлуудад, түүний эсрэг зөрчлүүдийг орхигдуулсан буюу үл хайхрах, түүнд чиглэсэн арга хэмжээ авахгүй байр эрсдэлүүдийг дагуулна.
- **7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй  хүүхэд.** ХБХ-ийн эрхийг хангахтай холбоотой нийцүүлэн гаргасан хууль, эрх зүйн актуудад ХБХЭТХ болон Хүүхдийн эрхийн тухай хуулиуд багтаж байна. Эдгээр хуулиудын хүрээнд хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, эрүүл мэндийн болон нийгмийн бусад үйлчилгээ авах эрхүүдийг хангаж, үйлчилгээг хүртээмжтэй, үнэ төлбөргүй байлгах, аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх, хамгаалах, чиглэлд илүү анхаарсан байна. Гэвч, ХБХЭТК-д заасан бүх эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх, ашиг сонирхлыг нь нэн түрүүнд харгалзах үзэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхүүдийг хангаж, насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх тухай агуулга, заалтууд дутмаг тусгагджээ. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийн хүрээнд шийдвэр гаргах, үнэлэлт, дүгнэлт өгөхөд оролцох, үзэл бодол, саналаа илэрхийлэх, өөрөө болон бусдаар уламжлан өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх талаар агуулга тусгасан. Гэвч Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиудад хүүхдүүдийн оролцооны тараар ямар ч заалт тусгагдаагүй байгаа нь энэ асуудлын хүрээнд конвенц, хуулиуд нийцлийг хангахгүй байгааг харуулж байна.

- **8 дугаар зүйл. Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх.** Конвенцын энэ зүйлд нийгмийн бүхий л хүрээнд, боловсролын бүхий л түвшин, хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан ХБХ-ийн эрхийн тухай мэдлэг нэмэгдүүлэх, хандлага төлөвшүүлэх замаар ХБХ-ий нэр төр, нандин чанарыг хүндэтгэсэн, зөв хандлагыг нийгэмд бий болгох тухай заасан. Гэвч зүйлтэй нийцүүлэн ХБХЭТХ-ийн 7 дугаар зүйлийг баталсан ч, ХБ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх тухай тусдаа зүйл оруулж өгсөн боловч хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг зөвхөн боловсролын орчинд хүүхэд залуучуудын дунд эсхүл зөвхөн Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр дамжуулах мэтээр тодотгон тусгаж өгчээ. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлд хүргэх байдлаар хязгаарласан нь дутагдалтай байна. Нийгмийн бүхий л орчныг ХБХ-д ээлтэй болгохын тулд нийгмийн бүхий л гишүүд болон хуулийн этгээдүүд тэдний эрхээс гадна, хүртээмжтэй, ээлтэй орчныг бүрдүүлэхэд хуулийн хүрээнд бүх талуудад тавигддаг хуулийн заалт, шаардлага, стандартууд болон ХБХ-т зориулсан үйлчилгээг мэддэг байх шаардлагатай. Гэвч ХБХЭТ хуулийн 7 дугаар зүйл нь хувийн хэвшил, хуулийн этгээд, нийт иргэдийн оролцоог хөндөөгүй, хөгжлийн бэрхшээлийн эрхүүд, төрөөс үзүүлж буй дэмжлэгийн хүрээнд агуулгыг онцолсон нь дутагдалтай байна.
- **9 дүгээр зүйл. Хүртээмж.** Конвенцын уг зүйлд хүртээмжийн асуудлыг хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор хүрээлэн буй орчин, гаднах болон доторх байгууламжууд, тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи зэргийг хамруулан үзэж, эдгээрийг хүртэхэд тулгарч буй саадыг илрүүлэх, устгах талаар заасан байдаг. Конвенцын уг зүйлтэй нийцүүлэн ХБХЭТХ-д хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчимд хүртээмжтэй орчныг бүрдүүлэх, хүртээмжтэй байх зарчмуудыг тусгаж, бүрдүүлээгүй тохиолдолд ялгаварлан гадуурхалт гэж үзэхээр заажээ. Эдгээр зарчим болон ялгаварлан гадуурхалтын хүрээнд хүртээмжтэй байдлыг тодорхойлсон бөгөөд конвенцтой адилаар

хүртээмжийг тусдаа бүлэг асуудал болгон авч үзээгүй ч, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, онцгой байдал, тусламж үйлчилгээ, мэдээлэл, харилцаа холбоо, технологи, соёл урлаг, спорт арга хэмжээ, хууль зүйн туслалцаа авах гэх мэт тусгай эрхүүд тус бүрийн хүрээнд зааж өгсөн байна. Гэвч эдгээр эрхийг хангах хүрээнд орчны асуудал болон дохионы хэлийг илүү онцлон дурдаж байгаа ч, хүний туслалцаатай буюу мэргэжлийн туслах үйлчилгээ, чадавх, нөөцийг бүрдүүлэх тухай заалтууд ихээхэн орхигджээ. Тухайлбал, нийтэд үйлчлэх объект, үйлчилгээг хүртээмжтэй байлгахад хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүд, тухайлбал, хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчдыг бий болгох мөн хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг зохиох, үйлдвэрлэх, түгээн борлуулах асуудлууд болон саадуудыг илрүүлэх, устгахад чиглэсэн ажлуудыг хөхиүлэн дэмжих талаар огт зохицуулалтгүй орхигджээ. Мөн конвенцод заасан нийтэд үйлчлэх буюу зориулагдсан объект хэмээх тодорхойлолтыг тусгаж, хүртээмжтэй байх асуудлын хамрах хүрээг тодорхойлох шаардлагатай байна.

- **10 дугаар зүйл. Амьд явах эрх.** Уг конвенцод нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний ‘Амьд явах эрх’-ийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж, Монгол Улсын Эрүүгийн хуулиар хамгаалахаар тусгажээ. Гэхдээ, Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй хэмээн баталгаажуулсан боловч уг хуулийн ялгаварлан гадуурхалтыг тодорхойлохдоо ялгаварлан гадуурхалтад хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан гадуурхсан тохиолдлыг тусгаагүй байна. Харин Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлгээр хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийг зохицуулан, 10.1 дүгээр зүйлд хүнийг 2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол тусгай зүйл ангиар шийтгэх боловч эдгээр үзэн ядах төрөлд хөгжлийн бэрхшээлээс шалтгаалсан тохиолдлыг мөн тусгайлан авч үзсэн заалт байхгүй байна. Мөн ХБХЭТХ-д амьд явах эрхтэй холбоотой ямар нэгэн тухайлсан заалт байхгүй байгаа нь уг конвенцод заасан бие даасан эрхийг ХБХЭТХ-д тусгаагүй байгааг анхаарч, нэмж тусгах нь зүйтэй.
- **11 дүгээр зүйл. Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал.** Конвенцын уг зүйлтэй нийцтэй гол хууль, журмууд болох Онц байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуультай нийцүүлэн гаргасан Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам, ‘Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)’ зэрэг нь гол зохицуулалт болж байна. Эдгээр хууль, журмууд нь конвенцын 11 дүгээр зүйлд туссан мэдээлэл түгээх, тусламж, үйлчилгээ хүргэх, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх үед ХБХ нь эхний ээлжид тусламж авах талаар нарийвчлан тусгасан тул үндэсний хууль, эрх зүйн зохицуулалтууд бүрэн нийцэж байна.
- **12 дугаар зүйл. Хуулийн өмнө тэгш байх эрх.** Монгол Улсад конвенцод заасан уг эрхэд нийцүүлсэн олон хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгосон нь агуулга болон зохицуулалтын хувьд хангалттай орчин бүрдсэнийг харуулж байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна хэмээн тусгажээ. Харин ХБХЭТХ-д үл ялгаварлах, санхүүгийн эрхийг тэгш хангах, нууцыг задруулахгүй байх тухай

заасан бол Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулиар Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тухай заасан байна. Эдгээр заалтууд нь эрхийг баталгаажуулахаас гадна, эрхийг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ, шийтгэлийг тусгасан тул уг конвенцын агуулгыг үндэсний хууль, эрх зүйн зохицуулалтад хангалттай туссан нь харагдлаа

- **13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох.** Уг эрхтэй нийцүүлсэн хууль, эрх зүйн зохицуулалт нь ХБХЭТХ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай хуулиуд болж байна**.** Үүнийг ХБХЭТХ-ийн 6 дугаар зүйлд заасан ХБХ-ийг үл ялгаварлан гадуурхах тухай зүйлийн 6.1-д тусган Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх эрхтэй хэмээн заасан байдаг. Үүнээс гадна, ХБХЭТХ-ийн 27 дугаар зүйлд ‘Хууль зүйн туслалцаа авах эрх’-ийг тусгайлан 4 дэд зүйлээр зааж өгсөн бөгөөд 27.1 Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх тухай заалт нь гол ерөнхий заалт болж байна. Хэдийгээр конвенцод үзэх болон хорих үйл ажиллагаанд оролцогч талуудыг сургалтад хамруулж, орчныг бүрдүүлэхэд дэмжих талаар заасан боловч ХБХЭТХ-ийн 27 дугаар зүйлд энэ талаар заалт дутмаг байна. Хэдийгээр ХБХЭТХ-ийн 7 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх заалтуудад төрийн албан хаагч нарыг ХБХ-ий эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах талаар тусгасан ч шүүх болон хорих гэх мэт холбогдох гол талууд, тэдгээрийн үйл ажиллагаа, орчин, нөхцөлд ХБХ-ий онцлог нийцүүлэн, хүртээмжтэй, тэгш байх тухай асуудлыг уг хуульд орхигдуулсан байгааг харуулж байна. Шүүхийн тухай хуулиар, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна хэмээн заасан ч хөгжлийн бэрхшээлийн онцлог байдлыг энэхүү зарчимд тусгайлан авч үзээгүй байна. Харин уг хуулиар хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэд орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдах, шүүхийн үйл ажиллагааг хүртээмжтэй байх, шүүгчид нь хүнийг хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэх тухай хориглосон заалтуудыг тусгажээ. Эдгээрээс гадна, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэд заавал өмгөөлөгчтэй оролцох тухай зааж, хуулийн туслалцаа авах эрхийг нь баталгаажуулж өгсөн. Мөн орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар мэдээлэл авах, дохионы хэлийг мэдэх хэлмэрчид хүлээх үүрэг, түүний эрх, хариуцлагын тухай заалтуудыг нарийвчилж зааж өгчээ. Эдгээр заалтууд нь дан ганц шүүхийн өмнө тэгш эрхийн хүрээнд шүүхийн бүхий л үйл ажиллагаанд хууль зүйн туслалцаа авах, эрх, үүргээ эдлэх нөхцөлийг нь сайтар тусгаж өгснийг харуулж байна. Гэхдээ, шүүхийн үйл ажиллагаа явуулах явцад бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх, үг хэлэх, оролцоход шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах, саадгүй зорчих, оролцох нөхцөлүүд болон шүүхийн бүх үйл ажиллагаанд оролцогчдыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн зэрэг агуулгаар сургах талаар нэмж тусгаж сайжруулах хэрэгцээ байгаа нь харагдаж байна.
- **14 дүгээр зүйл. Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх.** Конвенцод заасан уг эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулж, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар хамгаалж, зохицуулж байна. Монгол Улсын Үндсэн

Хуулийн 14-р зүйлд Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна хэмээн зааж өгсөн бол 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн нийт 18 эрхийг баталгаатай эдлэхээр зааж өгсөн бөгөөд түүний 13-т халдашгүй, чөлөөтэй байх эрх дурдагдсан бөгөөд үүнд дээрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаалах тухай зааж өгчээ. Үүнтэй адилаар, Эрүүгийн хуульд 'Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг'-ийг зааж өгсөн боловч, 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхахтай холбоотой зүйлд хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах асуудлыг орхигдуулсан нь харагдаж байна. Гэхдээ, эрх чөлөөг хасах асуудлыг Эрүүгийн тухай хуульд гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй хэмээн тухай зааж тусгажээ. Эдгээрээс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд халдашгүй байх эрхийг хангах талаар нарийвчилж өгсөн бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч уг эрхийг хязгаарлахыг хориглохоор заажээ. Тиймээс, конвенцод заагдсан энэхүү эрхтэй нийцсэн, энэхүү баталгаажуулсан, хамгаалсан хангалттай зохицуулалт бүрдсэн байгаа нь харагдаж байна.

- **15 дугаар зүйл. Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх.** Энэхүү конвенцын заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөний 'Халдашгүй байх эрхийн хүрээнд тодорхойлсон 'Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй' гэсэн заалтаар баталгаажуулж байна. Мөн Эрүүгийн хэргийг хянах шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлд 'Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх тухай тусдаа зүйлийг тусгаж, үүнд оролцогчид эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглож, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэх'-ийг хориглохоор заажээ. Харин эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилттай холбоотой асуудлын хүрээнд Эрүүл мэндийн тухай хууль нь гол хууль, түүнийг даган гаргаж, баталсан 'Анагаах Ухааны Ёс Зүйн Хяналтын Хороо, Салбар хорооны үлгэрчилсэн дүрэм'-ийн 2 дугаар бүлэгт заасан уг хороодын баримтлах зарчимд Судалгаа, эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг хамрагдаж буй хүний хүсэл сонирхол, албан ёсны зөвшөөрлийн үндсэн дээр явуулах тухай хамгаалсан заалтыг тусгажээ. Хэдийгээр, эдгээр хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусад нь тодорхойлж, чиглэсэн заалт байхгүй ч, хууль нь бүх хүнд адил тэгш үйлчилнэ гэдэг утгаар бүрэн тусгагдсан гэж дүгнэж болох юм.
- **16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх.** Уг заалтын хүрээнд хүчирхийлэл, мөлжлөгийн асуудлыг түлхүү авч үздэг тул түүнд нийцсэн хууль, эрх зүйн актууд нь ХБ-тэй эмэгтэйчүүд болон хүүхдүүд болон хохирогчдод илүү чиглэсэн байна. Тусгагдсан асуудлуудыг, ХБЭХТХ, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зэрэг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх

ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд зохицуулж байна. Түүний дараагаар нэгэнт хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн тохиолдолд авах шийтгэл, хариу арга хэмжээг нь ХБХЭТХ-ийн 6 дугаар бүлэгт заасан ХБХ-д үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, 7 дугаар бүлэгт заасан ХБХ-ийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан арга хэмжээгээр зохицуулахаар болжээ. Эдгээр үйлчилгээ нь хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах зорилготой бөгөөд үйлчилгээ тус бүр тусгай журмуудаар зохицуулагдаж байгаа учраас конвенцын хүрээнд тусгагдсан агуулга, асуултуудыг сайтар нийцүүлж тусгасныг харуулж байна.

- **17 дугаар зүйл. Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах.** Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийнхөө нэгдмэл байдлыг хүндэтгүүлэх, хамгаалуулахтай холбоотой эрх нь сэтгэцийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд хангагдах боломжгүй байна. Учир нь ХБХЭТК-ын зорилгод нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжих тухай заасан байдаг ч, түүнийг ХБХЭТХ-д энэ талаар дутмаг тусгажээ. Мөн уг зүйлийн хүрээнд дурдагддаг нөхөн үржихүйн эрхтэй холбоотойгоор, Эрүүл мэндийн тухай хуулийн 32-р зүйлд туссан Эхийн хэвлий дэх ураг удамшлын болон бие эрхтний гаж хөгжилтэй болох нь тогтоогдсон үед жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах тухай заалт мөн уг хуулийн дагуу Эрүүл мэндийн сайд 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А/387 дугаар тушаалын хавсралтаар баталсан Үр хөндөлтийг зохицуулах журмуудад иргэний эрх зүйн чадамжгүй сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн өмнөөс хууль ёсны асран хамгаалагч нь шийдвэр гаргахаар заажээ. Эдгээр зүйл заалтууд нь сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйгээс зөвшөөрөл авах талаар огт дурдаагүй, зөвхөн асран хамгаалагчийн шийдвэрээр үр хөндөлт хийхээр зааж байгаа нь хүний нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх боломжийг хязгаарлаж, албадан үр хөндөх, үрийн суваг боох зэрэг хүний нөхөн үржихүйн эрхийг нь зөрчиж байна гэж дүгнэжээ.
- **18 дугаар зүйл. Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх.** Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн нийт 18 эрхийг баталгаатай эдлэхээр зааж өгсөн бөгөөд түүний 18-т улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхийг баталгаажуулж өгчээ. Гэвч гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно гэсэн нь нь сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн хувьд чөлөөтэй зорчих, иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан заалт болж байна. Иргэний хуулийн 18 дугаар зүйлд Сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг ‘эрх зүйн чадамжгүй иргэн хэмээн тодорхойлдог учраас ‘Монгол Улсын иргэн’ гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах’ тухай хуульд зааснаар ‘эрх зүйн чадамжгүй’ иргэнийг заавал асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамт гадаадад зорчих эрх болгон хязгаарласан байдаг. Харин Оролцогч улсын хувьд иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхийг хангах үүрэгтэй боловч ‘Харьяатын тухай хууль’-иар Монгол Улсын харьяат болгохоос татгалзах, түдгэлзүүлэх үндэслэлийн нэг нь сэтгэл мэдрэлийн буюу гоц халдвартай өвчтэй нь зохих журмаар тогтоогдсон тохиолдолд өргөдлийг түдгэлзүүлнэ гэжээ. Энэ нь уг зүйлд заасан эрхийг нь хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хязгаарласан буюу

түдгэлзүүлсэн нь уг конвенцыг мөрдөх үүрэгтэй оролцогч орны хувьд бүрэн зөрчилдөж байгааг харуулж байна.

- **19 дүгээр зүйл. Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх.** Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн нийт 18 эрхийг баталгаатай эдлэхээр зааж өгсөн бөгөөд түүний 13-т халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зааж өгсөн бөгөөд үүнд иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална хэмээн зааж өгчээ. Харин ХБХЭТХ- д бие даан амьдрах эрхийг хуулийн тодорхойлолтод нарийвчлан оруулж, 32 дугаар зүйлээр конвенцод тусгагдсан асуудлыг бүрэн байдлаар тусгаж авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүрэг хариуцлага, хамрах хүрээг зааж зохицуулж байна. Мөн дээр дурдагдсан Чөлөөтэй зорчих, хүртээмжийн зүйлд заасан зохицуулалтаар конвенцод дурдагдсан нийгмийн амьдралд бүрэн дүүрэн хамрагдаж, бие даан амьдрахад шаардлагатай туслалцаа үзүүлэх, нийтийн үйлчилгээ объектыг бусадтай адил хэрэглэх боломжийг зааж өгчээ. Гэвч, конвенцын 19 дүгээр зүйл дээр дурдсан ‘нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, объект’ хэмээх нэр томьёог нь хамрах хүрээг илэрхийлж байгаа боловч, Монгол Улсын хууль тогтоомжуудад үүнийг тодорхойлсон заалт байхгүйгээс аливаа стандарт, шаардлагын хамрах хүрээ мөн харилцан адилгүй тодорхойлогдож байна. Тиймээс, бие даан амьдрах эрхийг баталгаажуулах, оршин суугаа орчиндоо байх эрхийг нь бүрэн хангахын тулд уг эрхийг хангахад шаардагдах ‘нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, обьект’-ыг тодорхойлох, түүнийг холбогдох хууль, журам, стандарт, шаардлагуудад нэмж тодорхойлж, тусгах шаардлагатай байна.
- **20 дугаар зүйл. Хувийн хөдөлгөөн.** Уг эрхийг хууль, эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн тусгах хүрээнд тусдаа гаргасан хуулийн зүйл, заалт, зохицуулалт дутмаг байна. Гэхдээ ХБХЭТХ-д түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн зэрэгтэй холбоотой асуудлыг нарийвчлан тусгаж, боловсрол, эрүүл мэнд, спорт нийгэм, соёлын үйлчилгээ авах бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээгээр хангагдах эрхүүдийг нарийвчлан зааж өгчээ. Мөн уг хуульд заасан бие даан амьдрах эрхийн хүрээнд, хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх, хараагүй иргэдэд туслах хөтөч нохойг тусгайлан сургаж бэлтгэх тухай асуудлуудыг тусгажээ. Гэвч, конвенцын заалтуудтай харьцуулан харвал, тохирох хэрэглэгдэхүүн болон туслах хэрэгсэл гэдгээр илүү нарийвчлан тусгасан боловч туслах үйлчилгээний асуудлыг тусгаагүй, туслах мэргэжсэн ажилтнуудыг бэлтгэх, туслах технологийг үйлдвэрлэх, дэмжих зэрэг асуудлуудад төдийлөн анхаарал хандуулаагүй, зохицуулалтгүй орхисон зөрүү харагдаж байна. Үүнээс үүдэн, хуультай нийцүүлэн гарах аливаа хөтөлбөр, бодлого нь асуудлуудыг орхигдуулах, дэмжих тогтолцоо бүрдэхгүй байх эрсдэл харагдаж байна.
- **21 дүгээр зүйл. Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө**. Монгол Улсын Үндсэн хуулийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэж заасан байдаг.

ХБХЭТК-ын 21 дүгээр зүйлд заасан Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөөг эдлэхийн тулд ХБХ-ийг өөрсдийг сонгосон харилцааны бүх төрлийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүртэх, түгээх эрхтэй боловч харилцааны хэрэглэгдэхүүнийг сонгохуйц өргөн хүрээнд хувилбартай болгох чиглэлд зохицуулсан зүйл заалт, дэмжсэн арга хэмжээ дутмаг байна.

Хөгжлийн бэршээлтэй хүн ялангуяа хараа сонсгол болон оюун сэтгэхүйн бэршээлтэй хүмүүс төрөөс болон нийтэд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас олон нийтэд түгээж байгаа тэдгээр мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр олж авах боломж нь хязгаарлагдмал ХБХЭТ хуульд мэдээллийн хүртээмж, брайл бичиг үсэг болон дохионы хэл нь сонсголын бэршээлтэй хүний эх хэл мөн болохыг баталгаажуулсан хуулийн заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр төр засгаас дорвитой арга хэмжээ аваагүй, хэрэгжүүлж буй цөөн арга хэмжээ нь цогц , өөр хоорондоо уялдаатай биш байна. Төрийн байгууллагуудын дийлэнх цахим хуудас болон мэдээлэл түгээж буй АПП нь ХБХ-т хүртээмжгүй, ХБИ-н ТББ-ууд шаардлага тавьдаг боловч төсөвгүй гэсэн тайлбар тавьдаг байдал түгээмэл байна.

Иймд Төрийн байгууллагуудын цахим хуудас болон цахимаар үйлчилгээ хүргэдэг байгууллагуудын апп, технологи, хэрэгсэл, хэлбэрийг хүртээмжтэй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх урт хугацааны төлөвлөгөө гаргаж төсвийг хуваарилах замаар мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх; Үндэсний цөөнх болох Казак, Тува үндэстэн ХБ хүмүүсийг ялангуяа хараагүй хүн казах хэлээр audio болон брайл ном хэвлэл ашиглан мэдээлэл авах болон тэдэнд казах брайл бичиг сурах нөхцөл боломжийг бий болгох;Телевизийн мэдээ мэдээлэл болон танин мэдэхүйн бусад нэвтрүүлэг хөтөлбөрийг хөгжлийн бэршээлтэй хүмүүст хүртээмжтэй буюу дохионы хэл, дуун тайлбар, бичмэл хөрвүүлэгтэйгээр нэвтрүүлэх болон цэсийг /menu box/-ыг хараагүй хүмүүст хүртээмжтэй болгох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна

- **22 дугаар зүйл. Хувийн нууцыг хүндэтгэх.** Уг эрхтэй нийцтэй гол зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.13-т заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээнд Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заажээ. Мөн ХБХЭТХ-ийн 31 дүгээр зүйлд заасан ‘Хувийн нууцыг хамгаалах’ зүйл бөгөөд үүнээс гадна хэрэгжиж буй Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль боловч уг хуулийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн нэр томьёоны тодорхойлолтод ‘4.1.15."эрүүл мэндийн мэдээлэл" гэж хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг’ тусган заажээ. Харин Иргэний хуулиар Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, уг хуулийн дагуу асран хамгаалагч нь эзэн нь байхаар зохицуулсан байдаг. Харин ‘Хүний эмзэг мэдээллийг’ хууль бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан нь бол Зөрчлийн тухай хуулиар холбогдох шийтгэл ноогдуулахаар заажээ. Эдгээр заалтуудад тусгасанчлан, конвенцод заасан ХБХ-ий хувийн нууцыг хүндэтгэх эрх, түүний талаарх тодорхойлолт, төрөл, ашиглах, хамгаалах, дамжуулах,

задруулах үед авах арга хэмжээ зэргийг нууцлах заалтуудыг сайтар нийцүүлсэн байна.

- **23 дугаар зүйл. Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх.** Конвенцод заасан энэхүү эрхийг Монгол Улсын Үндсэн хууль болон Гэр бүлийн тухай хууль, Иргэний хуулиудаар зохицуулж байна. Монгол Улсын үндсэн хуульд заасан халдашгүй чөлөөтэй байх эрхийн хүрээнд орон байрны халдашгүй байдлыг хамгаалах асуудлыг зохицуулж байна. ХБХЭТХ-ийн 6.5.3-т ХБХ-ийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг үр хүүхдээ асрамждаа авах эрхийг хязгаарлах нь ялгаварлан гадуурхалт болохыг тусгасан байдаг. Харин гэр бүлийн харилцааг зохицуулж буй Гэр бүлийн тухай хуулийн хүрээнд 'Гэрлэхэд харшлах шалтгаан'-д гэрлэгчдийн сэтгэцийн өвчний асуудлыг тусгасан бөгөөд гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол гэрлэлтийг зөвшөөрөхгүй байж болдог. Энэ нь ХБХ-ийн гэрлэлтийн асуудлыг зөвхөн сэтгэцийн архаг өвчтэй хүний тохиолдолд онцлон хязгаарлаж байгааг харуулж байна. Гэвч уг 9 дүгээр зүйл нь өөрөө ХБХЭТК-н 23.1 дүгээр зүйлд заасан гэрлэх насанд хүрсэн ХБХ-ий гэр бүл болох эрхийг гэрлэх хүнийх нь бүрэн, чөлөөтэй өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хүлээн зөвшөөрөх заалтыг бүрэн зөрчиж байгаа хуулийн заалт болж байна. Учир нь Иргэний тухай хуульд сэтгэцийн өвчтэй иргэний эрх зүйн чадамжгүй гэж үздэг учраас, гэрлэх, хүүхэд төрүүлэх зэрэг асуудлыг нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь өмнөөс нь шийдэх эрхтэй болдог. Тиймээс конвенцод тусгагдсан уг эрхийн агуулга нь үндэсний хууль, зохицуулалтуудад зөрчилтэй тодорхойлогдсон, зөрүүтэй байгааг харгалзан үзэж, хэлэлцүүлэг өрнүүлж, талуудыг нэгдсэн ойлголтод хүргэж, хуулийн зүйл заалтуудыг жигдлэх шаардлага харагдаж байна.
- **24 дүгээр зүйл. Боловсрол.** Тэгш хамруулах боловсролын эрхзүйн орчинд хангалттай сайн бүрдсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг боловсрол эзэмшихэд шаардлагатай сургалтын орчин, хүртээмжтэй сургалтын хэрэглэгдэхүүн тохируулга, багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй болон эцэг эх асран хамгаалагч нарын тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг ойлголт хангалтгүй байна. Боловсролд тэгш хамруулах чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, боловсролын зээлийн сангаар, хатуу гэрээ нөхцөлтэйгөөр оюутныг гадаадад бэлтгэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, багш болж байгаа бүх оюутнуудад боловсролд тэгш хамруулах, суралцахуйн түгээмэл загварын агуулгыг заавал эзэмших хичээлийн хөтөлбөрт оруулж, дохионы хэлийг сонгон судлах хэлбэрээр суралцдаг болгох, сургуулийн удирдлага, багш нарт чиглэсэн тэгш хамруулах боловсрол, хөгжлийн бэрхшээлийн хүний эрхэд суурилсан загвар хандлага болон заах арга зүйн талаар тогтмол системтэй сургалт явуулдаг тогтолцоог бий болгох, ХБ хүүхэдтэй эцэг эхчүүдэд тэгш хамруулах орчинд чанартай боловсрол эзэмшихэд нь хэрхэн дэмжиж хамтран ажиллах болон эрхийн хэрэгжилтийг бодит болгоход хэрхэн нөлөөлж ажиллах талаар чадавх бэхжүүлэх сургалт арга хэмжээг тогтмол явуулдаг болох шаардлагатай байна.
- БШУЯ-ны сайдын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/184 тушаалаар батлагдсан Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэршээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмын хэрэгжилт огт

хангадахгүй, журмыг хэрэгжүүлэх төсвийн эх үүсвэр тодорхойгүй байна. Мөн багш бэлтгэдэг их дээд сургуулиуд хичээлээрээ хөгжлийн бэрхшээлийн төрөл, шалтгаан, онцлог, хөгжлийн бэрхшээл тус бүрд заах арга зүй гэхчлэн зааж байгаа нь хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүн бүрд ялгаатай зааварчилгаагаар суралцахуйн түгээмэл загварыг ашиглан заах талаар ойлголт өгөхгүй байгаа нь бүгдийг тэгш хамруулах концепцээсээ зөрчилдөж байгааг анхааран авч үзэх шаардлагатай.

- **25 дугаар зүйл. Эрүүл мэнд.** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна хэмээн заасан. Харамсалтай нь энэ хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн тодорхой бодлого үйл ажиллагаа байхгүй байгааг ЭМЯ-ны тайлан төлөвлөгөө харуулж байна. ХБХЭТХ 4.1.3."тохирох хэрэглэгдэхүүн" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг хэлэхээр заасан. Эрүүл мэндийн тухай хуульд заасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх байнгын асаргаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх зэрэг асуудлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах ажилтнуудад ХБХ, тэдгээрийн эрхийн талаарх мэдлэг, ойлголт өгөх, чадавхжуулах, ёс зүйтэй, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх чадавхыг суулгах, ХБХ-тэй ажилладаг эмнэлгийн ажилтнуудын төрөл, тоог нэмэгдүүлэх талаарх заалт, зохицуулалт шаардлагатай байна.
- **26 дугаар зүйл. Нөхөн сэргээлт.** Конвенцод заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээлт, нөхөн сэргээлт хэмээн тодорхойлолт болон Эрүүл мэндийн тухай хуульд заасан сэргээн засах гэсэн ойлголт, нэр томьёо зөрүүтэй байна. ХБХЭТХ-д зөвхөн эрүүл мэндийн салбартай уялдуулан тайлбарласан заалт оруулсан нь, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүрээнд сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээний цар хүрээ, түүнд чиглэсэн авах арга хэмжээг хязгаарлаж байна. Мөн ХБХЭТХ-ийн 20-р зүйлд заасан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хэсэгт заасан 20.1-т Төрөөс ХБИ-ийг сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ хэмээн заасан. ХБХЭТХ-д сэргээн засах арга хэмжээг зохицуулсан заалтууд нь гол төлөв санхүүжилтийн асуудлыг хөндсөн байдлаар тусгасныг шинэчлэн технологи, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах сургах чиглэлд зүйл заалтуудыг нэмэх шаардлагатай харагдаж байна. ХБХ-ийг туслах хэрэгслээр хангах журам зохицуулалт туслах технологи хэрэгслийг сонголт хийн худалдан авах боломжийг хязгаарлан зөвхөн хатуу тогтоосон жишиг үнийн хүрээнд цөөн тооны хэрэгслийг худалдан авдаг нь сонголттой байх эрхийг зөрчиж байгаа учраас журмыг хүний эрхэд суурилсан байдлаар дахин шинэчлэх, сайжруулах, худалдан авалтын сонголтыг өргөжүүлэх арга замыг тодорхойлох шаардлагатай байна.
- **27 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлт.** Хөдөлмөрийн тухай хууль болон хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байранд хийгдэх тохируулга буюу тохирох хэрэглэгдэхүүн гэсэн ойлголтыг тайлбарласан хууль зүйн тайлбар байхгүй тул хөгжлийн

бэрхшээлтэй ажилтан хэрэгцээндээ нийцсэн ажлын байрны тохируулгаар хангагдаж чадахгүй байна. ХБХ-ний ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөрт ХБ иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн тухайлбал бизнесийн зээл олгох, job coach, байгууллагуудад квотыг хэрхэн биелүүлэх талаар зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалт болон ХБ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ойлголт нэмэгдүүлэх нөлөөллийн гэх мэт хэд хэдэн арга хэмжээ тусгагдсан ч эдгээр нь өөр хоорондоо уялдаатай байж чаддаггүй тул бодит үр дүн гардаггүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин хөтөлбөрийн хүрээнд бизнес эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгож буй зээлийн хэмжээ 2008 оноос хойш нэмэгдээгүй нь бизнес эрхэлж буй ХБХ-т бодитой дэмжлэг болж чадахгүй байна. Мөн хөдөлмөр эрхэлж буй ХБХ-н нас, хүйс, ХБ-ийн төрөл хэлбэр, оршин суугаа газраар нь болон тэдгээрийн ажил үйлчилгээний чиглэлийг тодорхойлсон судалгаа, тоон мэдээлэл байхгүй тул хэрэгцээнд нийцсэн бодлого арга хэмжээ төлөвлөх боломжгүй байна.

Хөдөлмөрийн нөхөн сэргээлт гэсэн ойлголт ухагдахуун шийдвэр гаргагч болон оролцогч талуудын бүхий маш хангалтгүй тул бодлогод тусгагдаагүйн улмаас хөдөлмөрийн нөхөн сэргээх үйлчилгээ манай улсад хэрэгжихгүй байна

- **28 дугаар зүйл. Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал.** Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин,нийгмийн хамгааллын эрхийн асуудлыг ХБХЭТХ-н 25, 26 дугаар зүйлд тусган авч үздэг. Хууль, зохицуулалтыг хүрээнд амьжиргааны баталгааг хангах, нийгмийн халамжид хамруулах талаар улсын хэмжээнд хууль, журмын дагуу нийгмийн халамжийн тогтолцоог бүрдүүлсэн. Нийцлийн хувьд харьцангуй сайн байгаа тул хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх чиглэлд илүү анхаарах нь зүйтэй.

- **29 дүгээр зүйл. Улс төр, нийгмийн амьдралд оролцох**

  Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн амьдралд оролцох эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын их хурал, Аймаг нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулиудад сонгох, сонгогдох эрхүүдийг баталгаажуулж өгсөн. Гэвч, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн хувьд Иргэний хуулийн дагуу эрх зүйн чадамжгүй иргэн гэдэг ангиллаар эдгээр хуулиудад сонгох эрхийг бүрэн хязгаарлаж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хуулиар сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг жагсаал, цуглаанд оруулахыг бүрэн хориглосон. Эдгээр заалтууд нь Конвенц болон Үндсэн хуультай шууд зөрчилтэй байгаа тул, гол оролцогч талуудын дунд сэтгэцийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох, нийгмийн амьдралд оролцох эрхүүдийн хүрээнд эдгээр иргэдэд эрхийг нь олгох эсэх, түүний үр дагаврыг холбогдох эрхүүдийг зохицуулж буй хуулиуд дах заалт тус бүрээр харж, нэгдсэн ойлголтод хүрч, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

- **30 дугаар зүйл. Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх.** ХБХЭТК-ын 30 дугаар зүйлд нийцүүлэн, ХБХЭТХ-ийн 33 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих, 34 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих, болон 35 дугаар зүйл. Соёл, урлагийн бүтээлийн хүртээмжтэй байх тухай заалтуудыг тусгасан байдаг. Мөн Соёлын тухай хуулийн 37 дугаар зүйлд

заасан Соёлын үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлагын 37.3-т Соёлын үйлчилгээ эрхлэх барилга байгууламж, танхим, талбай нь ба хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх талаар заажээ. Гэхдээ эдгээр хүрээнд ХБХ-ийг тусламж хүртэгч байдлаар харж, тэднийг төрөөс дэмжих, эсхүл тэдэнд ээлтэй орчин бүрдүүлэхийг төрөөс дэмжих тухай зааж, төрийн байгууллагыг гол субъект байдлаар тодорхойлсон байдаг. Гэвч нийгмийн бүхий л хүрээнд ээлтэй орчин бүрдүүлэх, бүхий л эрхийг хангах боломжоор хангах нь нийгмийн гишүүд, хуулийн этгээд бүрийн үүрэг гэдгийг эдгээр дэмжлэгийн агуулгатай заалтууд хязгаарлаж байна. Конвенцод заагдсан ч, Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалтад бүрэн орхигдсон нэг асуудал нь оюуны өмчийн асуудал бөгөөд ХБХ өөрөө бүтээгч байх, оюуны өмчийн эрхээ хамгаалуулах, өөрөө бүтээлээ нийгэмд хүргэх, адил тэгш үнэлүүлэх, өрсөлдөх чиглэлд ямар нэгэн зохицуулалт дутмаг байна.

- **31 дүгээр зүйл. Статистик болон мэдээлэл цуглуулах.** ХБХ-ийн амьдралын нөхцөл байдлыг олон талаас нь буюу боловсрол, орлого, ядуурлын төвшин, орон байрны нөхцөл гэх мэтээр харуулсан болон конвенцын хэрэгжилтийг үнэлэн дүгнэхэд шаардлагатай бодит тоо баримт хангалтгүй байна. Тоо мэдээллийн дутагдалтай байдал нь ХБХ-ний амьдралын түвшинг сайжруулах тэдний нийгмийн оролцоог нь дэмжихэд чиглэсэн хэрэгцээнд үндэслэсэн бодлого боловсруулах, арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Иймд: ХБХ-ийн амьдралын нөхцөл байдал болон нийгмийн оролцоонд нь учирч буй саад бэрхшээлийг олон үзүүлэлтээр буюу нас, хүйс, ХБ-ийн төрөл хэлбэр, оршин суугаа газар, амьжиргааны төвшин, боловсрол гэх мэтээр харуулсан статистик, мэдээллийг цуглуулдаг тогтолцоог бий болгох, мэдээллийг Вашингтоны асуулга цуглуулдаг аргачлалтай уялдуулах мөн ХБХ эрхээ хэрэгжүүлэхэд нь тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох судалгааг тогтмол хийх, төсвийг хуваарилах улмаар бодлого боловсруулахад ашигладаг байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- **32 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа.** Засгийн газраас санаачлан боловсруулсан олон төсөл, хөтөлбөрүүд салбар бүрд олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжиж байна. Гэхдээ тэдгээр төслүүдийн ихэнх хэсэг нь хөгжлийн бэршээлтэй хүний асуудалд мэдрэмжгүй, тэднийг хамруулахгүйгээр үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлж байгаа нь төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг бууруулж байна. Зарим тохиолдолд төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжээд дуусах үед нь мэдээлэл авах явдал цөөнгүй байна.

  Иймд төсөл хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтэд нь хяналт үнэлгээ хийх үйл явцад ХБ-тэй экспертүүд, тэдгээрийн төлөөллийн байгууллагуудыг идэвхтэй оролцоог хангах, ХБИ-ийн байгууллагуудыг бусад улс орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтын харилцааг бий болгон хөгжүүлэх түүнчлэн ХБХ-ий эрхийн асуудлаар олон улсад зохиогдож буй аливаа хурал, зөвлөгөөн сургалтад оролцоход нь дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

- **33 дугаар зүйл. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих.** ХБХЭТ конвенцын 33-р зүйлийн 33.1-д заасан чиг үүрэг бүхий бүтцийг засгийн газрын бүтцэд байгуулан ажиллуулах чиглэлд төр засгаас тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж 2018 оны 9 сард байгуулахдаа Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны харьяанд Хэрэгжүүлэгч агентлаг гэсэн статустай “”Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Хөгжлийн Ерөнхий газар” (ХБХХЕГ) гэсэн нэршилтэйгээр байгуулсан нь сайшаалтай хэрэг болсон. Гэсэн хэдий ч хуулиар олгогдсон эрх хэмжээ нь хязгаарлагдмал болон ХНХЯ-ны харьяанд ажиллаж байгаа зэрэг шалтгаанаас тус агентлаг нь салбар дундын уялдааг зохицуулан конвенцын хэрэгжилтийг ханган ажиллаж чадахгүй байна. Өнөөдрийн байдлаар агентлаг нь ХБХ-ий ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлд голчлон ажиллаж байна. Боловсрол Шинжлэх Ухааны Яам 2023 оны 7-р сард яамны бүтцэд тэгш хамруулах хэлтсийг байгуулан ажиллуулж эхэлсэн нь сайшаалтай. Харин ХБХ-ий өдөр тутмын нийгмийн оролцоонд нь шууд нөлөө үзүүлэх бодлого шийдвэрийг олонтоо гаргаж байдаг Барилга Хот Байгуулалтын Яам, Цахим Хөгжлийн Яам болон Эрүүл Мэндийн Яамдын хувьд конвенцын хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий бүтэц орон тоо бий болгон ажиллах нь туйлын хангалтгүй байна. Эрүүл Мэндийн Яамны хувьд 3-4 асуудал хариуцсан мэргэжилтэн нь ХБ-ийн асуудал хариуцаж байгаа нь мөн л хангалтгүй. Үүнээс улбаалан тэдгээр яамдаас гаргаж буй бодлого шийдвэрт ХБ-ийн асуудал орхигдох, эрхэд суурилсан хандлагаар тусгагдахгүй байх зэрэг асуудал гарсаар байна.

  Иймд

  1. ГБХНХЯ-ны харьяанд үйл ажиллагаа явуулж буй Хөгжлийн Бэршээлтэй Хүний Хөгжлийн Ерөнхий газрыг Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын дарга, Монгол улсын Сайдын удирдлагад шилжүүлэн салбар дундын уялдааг зохицуулан Конвенцын хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэг бүхий бүтэц болгон ажиллуулах;
  2. ХБХЭТК-г хэрэгжилтийг хангах урт хугацааны стратеги төлөвлөгөө бүхий бодлогын бичиг баримтыг боловсруулан гаргаж, жил бүр төсвийг хуваарилан хэрэгжилтийг ханган ажиллах;
  3. Зарим яамдын тухайлбал Эрүүл Мэндийн, Орон Сууцжуулалт Барилга, Хот Байгуулалтын Яам болон Цахим Хөгжлийн Яамдын бүтцэд ХБХЭТ Конвенцын хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэг бүхий бүтэц орон тоог бий болгох;
  4. Хүний Эрхийн Үндэсний Комиссын дэргэд ХБХЭТ Конвенцын хэрэгжилтэд байнгын тогтвортой хяналт мониторинг хийдэг тодорхой орон тоо, төсөв санхүүтэй бүтцийг бий болгон ажиллуулах;
  5. Конвенцын хэрэгжилтэд хяналт мониторинг хийх үйл ажиллагаанд ХБХ-ий эрх ашгийг хамгаалах чиглэлд ажилладаг ТББ-дын бодитой үр дүнтэй оролцоог баталгаажуулсан тогтолцоог бий болгох;

# 6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

Конвенцын зүйл тус бүрийг зохицуулж буй хуулиуд, тэдгээрт туссан заалтуудад хийсэн дүн шинжилгээ болон илрүүлсэн зөрүүтэй байдалд үндэслэн, зүйл заалт тус бүрийн хүрээнд зөрүүтэй байдлыг арилган авч хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг нарийвчлан гаргаж санал болгосон. Нийцлийн судалгааны үр дүнд суурилан эдгээр санал болгож буй зөвлөмжүүдийг нийт 4 бүлэгт ангилсан бөгөөд Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх, Нэр томъёолол, тодорхойлолтын зөрүүг арилгах, Агуулга, арга хэмжээг нэмж тусгах, Конвенцын заалт, агуулга зөрчигдсөн тул зөрчлийг арилгах гэсэн 4 бүлэгт ангилж харан, дараах хүснэгтэд харууллаа.

| Конвенцын зүйлс | Саналын төрөл | Нарийвчилсан санал |
|---|---|---|
| 5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл алагчилал | Нэр томьёолол, тодорхойлолтын зөрүүг арилгах | Ялгаварлалт/Ялгаварлахгүй байх болон Алагчлал/Үл алагчлах хэмээн нэр томьёог жигд ашиглах. Ялгаварлахгүй байх зарчмыг тусгасан бүх заалтуудад хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан гадуурхахгүй байх агуулгыг нэмж тусгах замаар эрхийг баталгаажуулах<br><br>ХБХЭТК-ын заалтуудыг нийцүүлж, тусгагдсан асуудлыг зохицуулж буй хууль, журмуудад дурдсан бүхий л салбар дах хуулиудын зарчимд 'нас, хүйс, боловсролын түвшин, үндэс угсаа, гэх мэт бүхий л хувь хүний онцлог байдлаас үүдэн гадуурхагдах нэг шалтгаанд хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан ялгаварлан гадуурхахгүй байх агуулгыг тусгаж оруулах |
| 6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд | Конвенцын заалт, агуулга зөрчигдсөн тул зөрчлийг арилгах | Сэтгэцийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг эрх зүйн чадамжгүй гэж тодорхойлж буй учир гэр бүл, нөхөн үржихүйн эрхийг нь хязгаарлаж, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид уг шийдвэрийг гаргах эрхийг олгож байна. Энэхүү хууль, эрх зүйн заалтууд нь конвенцын заалтуудтай зөрчилдөг байгаа тул, нэгдсэн ойлголтод хүрэх, сайжруулах арга хэмжээг тодорхойлох. Мөн хөдөлмөр эрхлэлтийг оролцуулаад ХБХ-т чиглэсэн нийгмийн үйлчилгээнүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ ХБ-тэй охид, эмэгтэйчүүдийг ижил тэгш хамруулах нэмэлт зохицуулалт,арга хэмжээг авах. |

| | | |
|---|---|---|
| 7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | ХБХ-ийн эрхийг хангахтай холбоотой нийцүүлэн гаргасан хууль, эрх зүйн актуудад ХБХЭТХ болон Хүүхдийн эрхийн тухай хуулиуд багтаж байна. Гэвч, конвенцын агуулгаас хүүхдийн суурь эрхүүдийг сайтар тусгасан боловч авах арга хэмжээнд тусгагдсан ХБХ-ийг бүх эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх, ашиг сонирхлыг нь нэн түрүүнд харгалзах үзэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхүүдийг хангаж, насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх тухай агуулга, заалтууд орхигджээ. Тиймээс, дан ганц ХБХЭТХ-ийн 8 дугаар зүйлд заасан Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхээс гадна,Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Хууль тогтоомжийн хууль зэрэг аливаа шийдвэр гаргах түвшинд үр шим хүртгэгчдийн хамруулахтай холбоотой заалтуудад хүүхдүүд болон асран хамгаалагчдыг хамтран оролцуулах замаар уг эрхийг нь тусгах нэмэлт өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байна. |
| 8 дугаар зүйл. Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | ХБ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхтэй холбоотой конвенцын заалтууд бүрэн тусгагдаагүй, одоогийн хуулийн заалтууд нь хамрах хүрээ, зорилго, оролцогч талуудын хувь хязгаарлагдмал байгаа тул бүрэн агуулгыг тусгах, нэмж оруулах шаардлагатай. Нэн түрүүнд, ХБХЭТХ-ийн 7 дугаар зүйлд ХБ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх тухай тусдаа зүйлд, 7.1.3-аар заалтыг дахин сэргээн тусгах замаар бүхий л боловсролын түвшинд мэдлэг олгох шаардлагатай. Мөн дан ганц ХБХ болон тэдгээрийн гэр бүлүүдэд мэдлэг, мэдээлэл олгох бус нийгмийн бүхий л гишүүд, хуулийн этгээдүүд ХБХЭ-ийн тухай болон хуулийн өмнө хүлээсэн үүрэг, стандарт, шаардлагуудад тусгагдсан агуулгын хүрээнд зайлшгүй сургалтад хамруулах шаардлагыг тусгаж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах талаар хуульд тусгах. Мэдлэг ойлголтыг нийгмийн бүх түвшинд түгээх стратеги төлөвлөгөө гаргах |
| 9 дүгээр зүйл. Хүртээмж | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | ХБХЭТХ-д ХБХЭТК-ийн 9 дүгээр зүйлд заасан Хүртээмжийн асуудлыг нэгдсэн байдлаар тодорхойлох, стандарт, гарын авлага гаргах ажлыг нэмж тусгах, ялангуяа, конвенцод заасан'нийтэд нээлттэй үйлчлэх объект, үйлчилгээ'-г тодорхойлж, түүнийг төлөвлөх, барих үе шатуудад хамаарах шаардлага, стандартыг сайжруулж, гарын авлага тэмдэглэгээ хийхийг дэмжих шаардлагатай. Мөн хүртээмжийн зөвхөн объект бус бүхий л аж ахуй нэгж, байгууллага өөрсдийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх, мэдээлэл өгөхөд дэмжлэг үзүүлэх зорилготой хүний туслалцаа, зуучлалын үйлчилгээний хэлбэрүүдийг хөгжүүлэх, мэргэжилтэн бэлтгэхэд чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнээс гадна, мөн хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг зохиох, үйлдвэрлэх, түгээн борлуулах асуудлууд, тэдгээрийг хөхиүлэн дэмжих талаар хуулийн заалт, арга хэмжээ огт тусгагдаагүй байгаа тул конвенцтой уялдуулан тусгах шаардлагатай. |

| | | |
|---|---|---|
| 10 дугаар зүйл. Амьд явах эрх | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | Конвенцод заасан уг эрх нь зөвхөн Монгол Улсын үндсэн хуулиар зохицуулж байгаа. Тиймээс, ХБХЭТХ-д үндсэн эрхийн нэг болохын хувьд тусгаж баталгаажуулах шаардлагатай. Мөн амьд явах эрхийг зөрчсөн бол Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг дэх Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг гэж тусгай зүйл ангиар шийтгэдэг. Үүн дотор, 10.1 дүгээр зүйлийн 2.14.-т хүнийг үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол тусгай зүйл ангиар шийтгэх боловч эдгээр үзэн ядах төрөлд хөгжлийн бэрхшээлээс шалтгаалсан тохиолдлыг мөн тусгайлан авч үзсэн заалт байхгүй байна. Тиймээс, үзэн ядах шалтгаануудад хөгжлийн бэрхшээлийн шалтгааныг тусгах нь эрүүгийн хариуцлагыг илүү тодорхой болгож, аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зөрчигдсөн тохиолдлыг таних, тогтоож, бүртгэхэд чухал давуу талтай. |
| 11 дүгээр зүйл. Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Конвенцын агуулга бүрэн тусгагдсан тул хууль, эрх зүйн зохицуулалтад тусгахаас илүү хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээллийг хүртээмжтэй хувилбараар хүргэх, сургах, мэргэжлийн албан хаагчид олон нийтийг сургах, ажиллах зааварчилгааг ХБИ-ийн онцлогийг харгалзсан байдлаар сайжруулах зэрэг энэ чиглэлд авах арга хэмжээний хэрэгжилтийг хангах, төсөв хуваарилах, үнэлэх асуудалд анхаарах шаардлагатай. |
| 12 дугаар зүйл. Хуулийн өмнө тэгш байх эрх | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Монгол Улсад конвенцод заасан уг эрхэд нийцтэй байдлыг хангаж буй Монгол Улсын Үндсэн хууль болон эдгээр асуудлыг олон хууль, эрх зүйн зохицуулалтыг байгаа тул хангалттай орчин бүрдсэн гэж дүгнэж болно. Тиймээс уг эрхийг таниулах, баталгаажуулах арга хэмжээнд илүү анхаарах шаардлагатай. |
| 13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Конвенцод заасан уг эрхийг ХБХЭТХ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай хуулиудад бүрэн тусгажээ. Тиймээс, конвенцод заасан уг асуудал, түүнийг зохицуулж буй хууль, эрх зүйн актуудын хэрэгжилтэд анхаарах нь зүйтэй. |
| 14 дүгээр зүйл. Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Конвенцод заасан уг эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулж, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар хамгаалж, зохицуулж байна.Агуулга, асуудлын хувьд хангалттай нийцтэй байгаа тул хэрэгжилт, түүнийг хангах нөөцийг бүрдүүлэх, тайлагнах чиглэлд илүү хүчин чармайлтай гаргах нь зүйтэй. |
| 15 дугаар зүйл. Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Уг зүйлийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж, Эрүүгийн хэргийг хянах шийдвэрлэх тухай хуулиар давхар салбарын түвшинд тусгажээ. Эдгээрээс гадна, агуулгын хүрээнд тусгагдсан хүнлэг бус байдлаар судалгаа, шинжилгээ, туршилтад оруулах байдлыг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хууль болон түүнтэй уялдуулан гаргасан журам, үлгэрчилсэн дүрэм, судалгаа, туршилтад тавигдах шаардлагуудын хүрээнд зохицуулж байна. Тиймээс, энэхүү зохицуулалтын хэрэгжилтэд илүү анхаарах шаардлагатай. |

| | | |
|---|---|---|
| 16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Уг заалтын хүрээнд хүчирхийлэл, мөлжлөгийн асуудлыг түлхүү авч үздэг тул ХБЭХТХ, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зэрэг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд зохицуулж байна. Эдгээр зөрчил илэрсэн тохиолдолд мөн адил Эрүүгийн хэргийг хянах шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж, шийддэг. Тиймээс, конвенцтой нийцсэн хуулийн заалтууд бүрдсэн байгаа тул, түүний хэрэгжилтийг хангах, энэхүү заалтын талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сэргийлэх, хариу арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах нь зүйтэй. |
| 17 дугаар зүйл. Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах | Конвенцын заалт, агуулга зөрчигдсөн | Эрүүл мэндийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах, Үр хөндөлтийг зохицуулах журмуудад сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйгээс зөвшөөрөл авах талаар огт дурдаагүй, зөвхөн асран хамгаалагчийн шийдвэрээр үр хөндөлт хийхээр зааж байгаа нь конвенцод заасан нэгдмэл байдлыг хамгаалах заалттай зөрчилдөж байгаа тул хүний нөхөн үржихүйн эрхтэй холбоотой асуудлыг дахин шинжилж, конвенцын агуулгатай нийцүүлэх |
| 18 дугаар зүйл. Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх | Конвенцын заалт, агуулга зөрчигдсөн | ‘ хүрээнд сэтгэцийн өвчний улмаас зорчих эрхээ хязгаарлуулж, зөвхөн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хяналт дах зорчихоор заажээ. Тиймээс, сэтгэцийн өвчин гэсэн тодорхойлолтыг нарийвчлан гаргаж, уг эрхийг конвенцод нийцүүлэн шийдвэрлэх арга замыг хэлэлцэх. Харин ‘Харьяатын тухай хууль’-иар өөр улсаас сэтгэл мэдрэлийн өвчтэй нь зохих журмаар тогтоогдсон тохиолдолд өргөдлийг түдгэлзүүлнэ гэсэн үзүүлэлт нь ялгаварлан гадуурхалтын шинжтэй, конвенцын эсрэг заалт болж байгаа тул, мөн адил сэтгэл мэдрэлийн өвчтэй гэсэн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох замаар, конвенцтой нийцүүлэн шийдвэрлэх, түүний дагуу хуулиудад нэмэлт өөрчлөлт хийх боломжийг судлах |
| 19 дүгээр зүйл. Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | Конвенцын хүрээнд бие даан амьдрах эрх болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрхийг хангахын тулд ‘нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, объект’ -ыг хүртээмжтэй байлгахад ихээхэн нарийвчилсан арга хэмжээнүүдийг тусгасан. Гэвч эдгээр заалтуудын агуулга нь ХБХЭТХ-ийн хүрээнд түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн зэрэг хязгаарлагдмал байдлаар томьёологдсон тул авах арга хэмжээ ч мөн адил хумигдмал байна. Тиймээс, ХБХЭТХ-д "нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, объект’-ыг тодорхойлж, түүнийг үндэсний болон салбарын холбогдох хууль, журам, стандарт, шаардлагуудад нэмж тодорхойлж, тусгах замаар конвенцтой нийцүүлэх шаардлагатай байна. |

| | | |
|---|---|---|
| 20 дугаар зүйл. Хувийн хөдөлгөөн | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | ХБХЭТХ-ийн хүрээнд конвенцод нийцүүлэн хувийн хөдөлгөөний дэмжих хүрээнд тохирох хэрэглэгдэхүүн болон туслах хэрэгсэл нарийвлан тусгасан боловч туслах үйлчилгээ хүргэх, туслах мэргэжсэн ажилтнуудыг бэлтгэх зэрэг хүний нөөцийг бүрдүүлэх, туслах технологийг үйлдвэрлэх, дэмжих зэрэг технологид суурилсан, үр ашигтай шийдлүүдийг нэвтрүүлэхэд талаар орхигдуулсан. Тиймээс конвенцын эдгээр орхигдсон асуудлуудыг ХБХЭТХ-д нэмж оруулах, хүний нөөц бүрдүүлэх, зохицуулалтын таатай орчин бүрдүүлэх, технологид суурилсан, үр ашигтай шийдлүүдийг бодлого, хөтөлбөрүүдэд тусгах шаардлагатай байна. |
| 21 дүгээр зүйл. Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | -Хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрийн хэрэгцээнд тулгуурлан, сонгосон хэрэгслээр мэдээлэл хүлээн авах, түгээх нь тэдэнд давуу талыг үүсгэнэ. Төр болон нийтэд үйлчилгээ хүргэдэг байгууллагуудын цахим хуудас болон бусад мэдээлэл хүргэдэг технологи, хэрэгслийг хүртээмжтэй болгох замаар мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төдийгүй бүх хүнд хүртээмжийг бий болгох давуу талтай. |
| 22 дугаар зүйл. Хувийн нууцыг хүндэтгэх | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Монгол Улсын Үндсэн хууль болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль байдаг бөгөөд эдгээрт 'эрүүл мэндийн мэдээлэл' болон 'хүний эмзэг мэдээлэл'-ийг тодорхойлсон бөгөөд түүнд хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг нарийвчлан зааж, түүнийг бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан нь бол Зөрчлийн тухай хуулиар шийтгэхээр заажээ. Энэ нь хувийн нууцын тодорхойлолт, түүнтэй харьцах, хамгаалах, холбогдох зөрчлүүдийг сайтар тусгасан тул конвенцын агуулгатай бүрэн нийцтэй байгааг харуулж байна. Тиймээс, эдгээр заалтын хэрэгжилтэд илүү төвлөрвөл зохилтой байна. |
| 23 дугаар зүйл. Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | ХБХЭТК-д заасан Орон байр болон гэр бүлийг хүндэтгэхтэй холбоотой заалтуудыг халдашгүй байдлын эрхтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хууль болон Гэр бүлийн тухай хууль, Иргэний хуулиудаар зохицуулж байна. Гэвч конвенц болон үндэсний хууль, зохицуулалтад зөрчилтэй байгаа агуулга нь сэтгэцийн бэрхшээлтэй иргэний эрх зүйн чадамж бөгөөд энэ нь гэрлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх эсхүл гэрлэх хүн болон хууль ёсны асран хамгаалагчийнх нь зөвшөөрлөөр гэрлэхээр заажээ. Энэ нь конвенцод заасан нэр төр, нандин чанарыг нь хүндлэх, бүх эрхийг нь эдлүүлэх, хуулийн өмнө тэгш байх заалтуудтай зөрчилдөж байна. Тиймээс, эдгээр хуулиудын хоорондын зөрчлийг арилгах, хамгийн оновчтой шийдлийг конвенцтой нийцүүлэн гаргаж, талуудын ойлголтыг нэгтгэх шаардлагатай байна. |
| 24 дүгээр зүйл. Боловсрол | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Уг зүйлийн хэрэгжилтийг хангахын тулд хараагүй иргэдэд зориулсан брайл үсгийг ашиглан мэдээлэл түгээх, нийгмийн харилцаанд оролцоход дэмжлэг үзүүлэх нэн шаардлагатай байна. Мөн ХБХ-тэй эцэг эхчүүдэд чиглэсэн хүүхдээ тэгш хамруулах орчинд чанартай боловсрол эзэмшихэд нь хэрхэн дэмжиж хамтран ажиллах болон эрхийн хэрэгжилтийг бодит болгоход хэрхэн нөлөөлж ажиллах талаар чадавх бэхжүүлэх сургалт арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх нь зүйтэй. Орчныг бүрдүүлэхийн тулд, сургалтын материал хэрэглэгдэхүүнийг |

| | | |
|---|---|---|
| | | оюутан сурагчдад хүртээмжтэй болгох болон тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээ авах, шаардагдах хөрөнгө санхүүг тухайн сургуулийн жил бүрийн төсөвт тусгах замаар бодит ажил болгох шаардлагатай. |
| 25 дугаар зүйл. Эрүүл мэнд | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | Эрүүл мэндийн салбар хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ гэдэг ойлголтод эмнэлгийн орчны хүртээмжтэй байдлыг хамруулан авч үзэж, эмч мэргэжилтнүүдэд хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээ, болон тэдний эрхийг таниулах арга хэмжээ, болон эмнэлгийн орчин болон үйлчилгээнд тохируулга хийх үйл ажиллагааг орхигдуулсаар байна. Эдгээр заалтууд нь ХБХЭТК-ын Эрүүл мэндийн эрхийн хэсэгт заагдсан үйлчилгээний хүрээнд алагчлахгүй байх, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байршлаас үл хамааран эмнэлгийн үйлчилгээг ХБХ-ийг аль гэрт нь ойр газар хүртээмжтэйгээр хүргэх гэм мэт заалтуудыг орхигдуулжээ. Тиймээс, эдгээрийг тодорхой зүйл заалтуудаар тусгахын сацуу дараах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэхээр тусгах шаардлагатай.<br>1. Эмч эмнэлгийн ажилтан бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт “хүний эрхэд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ” сургалтын хөтөлбөрийг оруулж ХБ-тэй экспертүүдээр өөрсдөөр нь сургалтыг хүргүүлж, салбарын мэргэжилтнүүдэд ХБ-тэй хүний эрх, нийгмийн загварыг таниулах замаар иргэдийн ЭМ үйлчилгээ авах эрхийг хангах, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг бий болгох<br>2. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын эмч ажилтнуудад ХБ хүний эрх болон тэдэнд хандах хүний эрхийн загвар хандлага, хүртээмжтэй тохируулга бүхий орчныг хэрхэн бүрдүүлэх талаар цогц сургалтыг үе шаттайгаар явуулдаг тогтолцоог бий болгох уг сургалтыг ХБ иргэдийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах; |
| 26 дугаар зүйл. Нөхөн сэргээлт | Нэр томьёолол, тодорхойлолтын зөрүүг арилгах | ХБХЭТК-д Сэргээлт, нөхөн сэргээлт гэсэн агуулга нь ХБХЭТХ-д тусгагдаагүй, энэхүү нэр томьёог ашиглаагүй байгаа бөгөөд сэргээн засалт хэмээх хэллэгийг ашигласан цөөн заалт байна. Тухайлбал, Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.21-т "сэргээн засах" гэсэн нэршлээр явж байна. Тиймээс эдгээр тодорхойлолтыг нэн түрүүнд жигдлэх, түүний дараа ХБХЭТХ-д сэргээлт, нөхөн сэргээлт, сэргээн засах гэсэн нэр томьёог тусгаж уг эрхийг баталгаажуулж, авах арга хэмжээг өргөжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа, , хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүрээнд сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээг бий болгох чиглэлд арга хэмжээ тусгаж, түүний агуулга, хамрах хүрээг конвенцтой нийцүүлэх шаардлагатай байна. |
| 27 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлт | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Конвенцын үзэл санаа зарчимд нийцүүлэн “ХБ ажилтны хэрэгцээнд нийцсэн ажлын байрны тохируулга” гэсэн ойлголтыг тайлбарласан тодорхойлолтыг холбогдох хууль журамд тусгаж хэрэгжилтийг нэг мөр болгох арга хэмжээ авах шаардлагатай. ХБХ-ий ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд олгож буй бизнес дэмжих зээлийн хэмжээг үнийн өсөлт болон инфляцын төвшинтэй уялдуулан нэмэх, ЖДҮ сангаас квотын тогтолцоог бий болгох замаар хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдэд томоохон хэмжээний зээл олгодог болох нь үр дүнтэй. Мөн Гарааны |

| | | |
|---|---|---|
| | | бизнес болон ашгийн бус social enterprise-ын үйл ажиллагаа эрхлэх төсөлд буцалтгүй санхүүгийн дэмжлэг олгодог тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ харагдаж байна. |
| 28 дугаар зүйл. Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | Халамжийн сангаас олгож буй мөнгөн тусламж дэмжлэгийн хэмжээг амьжиргааны баталгаажих доод төвшинтэй уялдуулан нэмэгдүүлдэг түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж дэмжлэгийг тухайн ХБ хүний онцлог хэрэгцээ болон амьдралын нөхцөл байдалтай нь уялдуулан ялгаатай тогтоож олгодог тогтолцоог бий болгоход анхаарах нь зүйтэй. ХБ-тэй гишүүнтэй өрхийг амьжиргааны төвшин болон хэрэгцээг нь үндэслэн олон хэлбэрт хувилбараар орон сууцаар хангах болон орон байрны нөхцөл сайжруулах хөтөлбөрийг ХБИ-ийн ТББ-уудын оролцоотой боловсруулан батлуулж хэрэгжүүлэх, шаардагдах төсвийг жил бүрийн улс орон нутгийн төсөвт хуваарилах замаар хэрэгжилтийг хангах шаардлагатай байна. |
| 29 дүгээр зүйл. Улс төр, нийгмийн амьдралд оролцох | Конвенцын заалт, агуулга зөрчигдсөн | Сонгуулийн холбогдох хуулиуд болон Зөрчлийн тухай хуулиудыг конвенцын үзэл санаа зарчимд нийцүүлэн өөрчилж ХБ хүний сонгууль оролцох эрхийг хязгаарлаж болзошгүй тэдгээр зүйл заалтыг өөрчлөх хасах арга хэмжээ авах; |
| 30 дугаар зүйл. Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | Конвенцын 30 дугаар зүйлд заасан агуулга ХБХЭТХ-ийн 33-аас 35-р зүйлд тусгасан асуудлуудад хязгаарлагдмал байдлаар буюу соёл, биеийн тамир, спортын арга хэмжээнд орчны хүртээмжтэй байдлыг хангах эсхүл оролцоход нь төрөөс дэмжлэг үзүүлэх байдлаар л тусгагдсан байна. Тиймээс, Энэхүү хуульд нийгмийн бүхий л хүрээнд эзлэх орчин бүрдүүлэх, бүхий л эрхийг хангах боломжоор хангах нь нийгмийн гишүүд, хуулийн этгээд бүрийн үүрэг гэдэг агуулгын тусгах шаардлагатай байна. Мөн конвенцод заасан, оюуны өмчийн асуудал бүрэн орхигдсон байгаа тул, ХБХ-ий бүтээх, оюуны өмчийн эрхээ хамгаалуулах, өөрөө бүтээлээ нийгэмд хүргэх, адил тэгш үнэлүүлэх, өрсөлдөх эрхийг нь ХБХЭТХ-ийн 35 дугаар заалтад тусгах, мөн ‘Оюуны өмчийн тухай хууль’-д үл ялгаварлах зарчмыг тусгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний оюуны өмчийн эрхийг баталгаажуулах шаардлагатай байна. |
| 31 дүгээр зүйл. Статистик болон мэдээлэл цуглуулах | Агуулга, арга хэмжээг нэмж тусгах | ХБХЭТК-д заасан агуулгыг тусгаж, арга хэмжээг өргөжүүлэхийн тулд дараах зүйлсийг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.<br>1. ХБИ болон ХБ-тэй эмэгтэйчүүдийн амьдралын нөхцөл, нийгмийн оролцоонд нь учирч буй саад бэрхшээл, орлого, боловсрол, үйлчилгээнд хамрагдалтыг нас, хүйс, ХБ-ийн төрөл хэлбэр, оршин суугаа газраар нь харуулсан статистик, тоон мэдээллийг гаргадаг механизмыг бий бий болгох,<br>2. Хөгжлийн бэршээлтэй хүмүүст эрхээ хэрэгжүүлэхэд нь тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох нөхцөл байдлын судалгааг тодорхой үечилсэн хугацаанд тогтмол хийхэд түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлаар аливаа бодлого боловсруулахад хөрөнгө хуваарилах, |
| 32 дугаар зүйл. Олон | Бүрэн нийцтэй тул | ХБХЭТК-д заасан арга хэмжээг өргөжүүлэхийн тулд дараах зүйлсийг нэн тэргүүнд анхаарч, гүйцэтгэх шаардлагатай байна. |

| | | |
|---|---|---|
| улсын хамтын ажиллагаа | хэрэгжилтэд төвлөрөх | 1. Засгийн газраас санаачлан боловсруулж хэрэгжүүлж буй олон улсын хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх болон хяналт үнэлгээ хийх бүхий л шатанд ХБ иргэдийн байгууллагуудын үр дүнтэй оролцоог баталгаажуулсан механизмыг бий болгох;<br>2. ХБХ-ий эрхийн асуудлаар олон улсад зохиогдож буй аливаа хурал, зөвлөгөөн сургалтад оролцоход ХБХ тэдгээрийн төлөөллийн байгууллагын төлөөлөлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;<br>3. Засгийн газрын хөнгөлөлттэй зээл тусламжийн хүрээнд хэрэгжиж төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд өндөр төсөв,санхүү зарцуулан хийгдсэн судалгааны тайлан,бодлогын бичиг баримтуудыг хэрэглээнд нэвтрүүлэх, бодлогод тусгах; |
| 33 дугаар зүйл. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих | Бүрэн нийцтэй тул хэрэгжилтэд төвлөрөх | ХБХЭТК-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд дараах зүйлсийг нэн тэргүүнд анхаарч, гүйцэтгэх шаардлагатай байна.<br>1. ГБХНХЯ-ны харьяанд үйл ажиллагаа явуулж буй Хөгжлийн Бэршээлтэй Хүний Хөгжлийн Ерөнхий газрыг салбар дундын уялдааг зохицуулан Конвенцын хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүргийн дагуу ажиллуулах;<br>2. ХБХЭТК-г хэрэгжүүлэх урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан, төсвийн хамт батлан, жил бүр хэрэгжилтийг үнэлэн ажиллах |